



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025.06.25 № 35-1/81
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Нийтийн өмчийн хууль (Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга)-ийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025. 05. 28 № ХЭГ/1543
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Нийтийн өмчийн хууль (Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга)-ийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалыг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт ⁴¹³ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

900255008486



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2025.05.26 № 01/4832

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Нийтийн өмчийн хууль (Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга)-ийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761000383



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025. 05. 22 № 1/2819

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Нийтийн өмчийн хууль /Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



О.АЛТАНГЭРЭЛ

А5 файл.2025
15160-432

1516017.4



.. хэрэгсэлээр үйлдсэн үйлдэл нь үйлдсэн үйлдэл
/хэрэгсэлээр үйлдсэн үйлдэл нь үйлдсэн үйлдэл
/хэрэгсэлээр үйлдсэн үйлдэл нь үйлдсэн үйлдэл
/хэрэгсэлээр үйлдсэн үйлдэл нь үйлдсэн үйлдэл
/хэрэгсэлээр үйлдсэн үйлдэл нь үйлдсэн үйлдэл

МОНГОЛЫН ХӨРӨН
МОНГОЛЫН ХӨРӨН

МОНГОЛЫН ХӨРӨН

МОНГОЛЫН ХӨРӨН

www.mojha.gov.mn
info@mojha.gov.mn
(976) 26 75 33
15160
8/4


МОНГОЛЫН ХӨРӨН
МОНГОЛЫН ХӨРӨН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 24 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“З.ХЭЛЭЛЦСЭН нь: Нийтийн өмчийн хууль (Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга)-ийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Нийтийн өмчийн хууль (Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга)-ийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцээд, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.УЧРАЛ

БАТЛАВ.
САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

О.АЛТАНГЭРЭЛ

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН **ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж, Иргэний хуулийн 99 дүгээр зүйлийн 99.2 дахь хэсэгт “Нийтийн өмч нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй байна” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. ...Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно”, Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх,... эрхтэй.” гэсэн зарчмыг хуульчлан баталгаажуулсан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-т төрийн нийтийн өмчийн зохицуулалтыг тодорхой болгохоор зааж, тус хуваарийн 1.1.1-д “...стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны үр өгөөжийн дийлэнх нь буюу тавиас дээш хувь нь монголын ард түмэнд ногдох, шаардлагатай бол иргэдийн саналыг харгалзан Улсын Их Хурал хэлэлцэн байгалийн баялаг ард түмний мэдэлд, төрийн нийтийн өмч байх эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ энэхүү баялгийг төр өмчлөх...зарчмыг

хуульчлах;”, 1.2.6-д “төрийн нийтийн өмчийг зохистой ашиглах, зарцуулахад тавих хяналтыг боловсронгуй болгох.”, 4.3.2-т “аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх,...эрх зүйн үндсийг бүрдүүлэх;”, 4.3.3-т “аймаг, нийслэл, сум, дүүргийн эрх зүйн байдал, өмчийн болон төсвийн харилцааг тусгайлсан хуулиар ялгамжтай зохицуулах,...” гэж тусгажээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтын 5.2.6-д “Бие даан хөгжих боломжийг бүрдүүлсэн орон нутгийн өмч, татварын боловсронгуй тогтолцоо бүхий эдийн засаг, санхүүгийн эрх мэдлийг орон нутагт шилжүүлнэ” гэж, 5.2.19-д “Төрийн компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна” гэж тус тус заасан байна.

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.4.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх, төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, үр өгөөж, хяналтыг сайжруулах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчилнэ.” гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.1.1-д “Төрийн болон орон нутгийн өмч, түүний ангилал, өмчийн удирдлага, төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх, бүртгэл, тооллого, тайлагналт, хяналт, ил тод байдалтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулах” хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэхээр тусгажээ.

Дээрх эрх зүйн шинэчлэл, бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилтын хүрээнд нийтийн өмч, түүний дотор төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх, хууль хоорондын давхардал, хийдлийг арилгах, төрийн болон орон нутгийн өмчийн ангилал, хэлбэрийг зохистой тогтоож, өмчийн удирдлага, бүртгэл, ашиглалт, хамгаалалт, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх нь тус хуулийг шинэчлэн найруулах хууль зүйн шаардлагыг илэрхийлж байна.

1.2.Практик хэрэгцээ, шаардлага

-Монгол Улс 1990 оноос зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбогдуулан 1996 онд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг анх баталсан бөгөөд уг хууль нь шилжилтийн үеийн төрийн болон орон нутгийн өмчийн талаарх төрийн байгууллагын эрх хэмжээг тогтоон, өмч хувьчлалыг зохицуулахад чиглэсэн байдаг. Гэтэл нийгэм, эдийн засгийн харилцаа хурдацтай өөрчлөгдөхийн хэрээр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зохицуулалт нь цаг үеийн нөхцөл байдалтай нийцэхгүй, нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцрох болжээ.¹

¹ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2025 он.

Тухайлбал, хууль батлагдсанаас хойш нийт 39 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд тэдгээрийн дийлэнх нь тус хуулийн зохицуулалттай холбоотой тулгарч байгаа бэрхшээлийг шийдвэрлэхэд бус харин салбарын бусад хууль шинэчлэгдсэн, эсхүл тэдгээрт нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой байна. Өөрөөр хэлбэл, хуулийн нийт зүйлийн 80 орчим хувьд өөрчлөлт орсон ч тэдгээр нь нэгдсэн бодлого, зарчмаар биш салангид байдлаар өөр, өөр зорилгын хүрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт байна.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойших өнгөрсөн 29 жилийн хугацаанд нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг дагаж өмчийн харилцаатай холбоотой эрх зүйн зохицуулалтын хүрээнд томоохон өөрчлөлтүүд гарсны дотор 2002 онд Иргэний хууль, Газрын тухай хууль батлагдаж, 2005, 2023 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 2011 онд Төсвийн тухай хууль, Компанийн тухай хууль, 2020 онд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдсэн зэрэг төрийн болон орон нутгийн үйл ажиллагаа, өмч болон бизнесийн харилцааг зохицуулсан хуулийн шинэчлэл томоохон байр суурийг эзэлнэ.

Ийнхүү Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зохицуулалтын хийдэлтэй болон эрх зүйн шинэчлэлээс хоцорсон, хуульд цаг үеийн шинжтэй, бусад салбарын хуулийн өөрчлөлттэй уялдуулсан нэмэлт, өөрчлөлтийг удаа дараа оруулсан зэрэг нь хуулийн зохицуулалтын нэгдмэл, цогц байдлыг алдагдуулахад хүргэжээ.

-Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Үндсэн хөрөнгийн, шаардлагатай гэж үзвэл эргэлтийн хөрөнгийн улсын үзлэг тооллогыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн 4 жилд нэг удаа Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа эхэлсэн анхны жилийн IV улиралд багтаан явуулна” гэж заасны дагуу өнгөрсөн хугацаанд улсын тооллогыг нийт 7 удаа (1996, 2000, 2003, 2007, 2011, 2015, 2022 он) явуулсан байна.

2015 оны тооллогоор нийт 30 их наяд, 74 тэрбум, 984.7 сая төгрөгийн хөрөнгө тоологдсон нь өмнөх буюу 2011 оны тооллогын дүнгээс 15 их наяд, 614 тэрбум, 300 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байсан бол 2022 оны тооллогоор нийт 91.7 их наяд төгрөгийн хөрөнгө 6614 нэгж байгууллагад тоологдсон нь 2015 оны тооллогын дүнгээс 61.7 их наяд төгрөгөөр буюу 67 орчим хувиар нэмэгдсэн байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой толгой 99 компани, үйлдвэрийн газар нь 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 23 их наяд 617 тэрбум төгрөгийн орлого, 16 их наяд 912 тэрбум төгрөгийн зардал, 4 их наяд 983 тэрбум төгрөг буюу 21.1%-ийн цэвэр ашиг, 64 их наяд 200 тэрбум төгрөгийн нийт хөрөнгө, 7.76%-ийн хөрөнгийн өгөөжтэй ажилласан байна. Мөн төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийн орлогоор улсын төсөвт 2019 онд 155.2 тэрбум, 2020 онд 173.6 тэрбум, 2021 онд 207.2 тэрбум, 2022 онд 469 тэрбум, 2023 онд 449.8 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.²

Төр болон орон нутаг нь улсын төсвөөс гадуур их хэмжээний хөрөнгийг өмчилж байгаа боловч өмчийг зохистой удирдах, үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлд эрх зүйн зохицуулалт хангалтгүй хэвээр байна.

² “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, 2024 он.

-Хуульд төрийн өмчийг төрийн нийтийн зориулалттай болон төрийн өөрийн өмч гэж ангилж, ангилал тус бүрт хамаарах өмчийг ялган тодорхойлсон боловч тэдгээрийн хооронд давхцал үүссэн, төрийн өмчид хамаарах эдийн бус хөрөнгө болох эрх, оюуны өмчийн төрлийг орхигдуулсан байна.

Өөрөөр хэлбэл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн нийтийн зориулалттай өмч”-ийн хүрээ нь зөвхөн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгөд хамаарахаар байгаа нь оновчгүй байна. Гэтэл зах зээлийн харилцаа хөгжихийн хэрээр аливаа баялгийг эдийн бус хөрөнгө хэлбэрээр удирдах нь зайлшгүй зүйл болсон. Энэ ч утгаараа, Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2-т “...газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.”, “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” хэмээн заажээ.

2024 онд батлагдсан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12.5-д “Орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд нь 100 хувь төрийн өмчит компани байх бөгөөд хувьцааг Засгийн газар эзэмшинэ” гэж, 12.7-д “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд эзэмшинэ” гэж заасан нь төрийн нийтийн өмчид хамаарах газрын хэвлийн баялгийг эдийн бус хөрөнгө болох хувьцаагаар дамжуулан удирдах асуудлыг хүлээн зөвшөөрсөн байна.

Түүнчлэн, “төрийн нийтийн зориулалтай өмч”-ийн жагсаалтад “Үндэсний баялгийн сан”, “Эрдэнэсийн сан”, “Монгол Улсын агаарын зай”, “Үндэсний архивын сан хөмрөг” зэргийг тусгаагүй байна. Эдгээр хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг гагцхүү Улсын Их Хурал хуулиар тогтоох тул энэ шинжээрээ Монгол Улсын Үндсэн хуульд заасан “төрийн нийтийн өмч”-ийн ангилалд хамааруулж болохоор байна.

Төрийн нийтийн өмчийн зонхилох хэсэг болох газрын бүртгэл манай улстай адил өмчийн эрх зүйн тогтолцоотой улс орнуудад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд тооцогддог боловч Монгол Улсын хувьд төрийн ба орон нутгийн өмчид хамаарах үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл байхгүй хэвээр байна.

-Нөгөө талаар өмчлөгч, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч этгээдүүдийн эрх мэдлийн хуваарилалт ойлгомжгүй буюу өмчийн талаар эдлэх эрх, хүлээх үүргийг хөрөнгийн зориулалт, төрөлтэй уялдуулж тогтоогоогүй, хөрөнгийн ашиглалт, захиран зарцуулалтад тавих хяналт сул, төрийн өмчит хуулийн этгээдийг үүсгэн байгуулахад тавигдах нөхцөл, шаардлагыг хэт ерөнхий тодорхойлсон нь асуудал, хийдлийг үүсгэж байна.

Тухайлбал, Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын өмчийг удирдах бүрэн эрх ойлгомжгүй, уялдаа холбоо сул, төрийн өмчийг эзэмшиж байгаа төрийн байгууллага, албан газар, үйлдвэрийн газар, компанийн эд хөрөнгийн эрх тодорхойгүй, төрийн өмчид хөрөнгө олж авах хязгаарлалт байхгүй, төрийн өмчийг захиран зарцуулах харилцааг шинж чанараар нь бус гэрээний төрлөөр шууд тулган зааж, өмчийг захиран зарцуулах уян хатан байдлыг хязгаарласан, төрийн өмчийг бусдад шилжүүлэх, ашиглуулах арга хэлбэр явцуу, төрийн өмчийн бүртгэл, тооллого, тайлагнал, хяналт, мэдээллийн тогтолцоо

нь зөвхөн төрийн өөрийн өмч, хяналтаар хязгаарлагдсан зэрэг асуудлыг дурдаж болохоор байна.³

-Төрийн болон орон нутгийн өмчийн харилцаанд “төрийн болон орон нутгийн өмчийг удирдах” тухай ойлголт ач холбогдолтой байдгаараа хувийн өмчийн эрх зүйгээс ялгаатай.⁴

Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага нь онолын хувьд эзэн-төлөөллийн асуудал (agency problem) болон хэлцлийн зардал (transaction cost) -ын тэнцвэрийг хангахад чиглэх учиртай. Энэхүү хоёр ойлголтын тэнцвэрийг сайн хангаж чадсан тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын үр ашиг болон зардлын харьцаа сайжирна.⁵

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хөдөлгөөнийг шийдвэрлэх бүрэн эрхийг Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад төвлөрүүлэх нь хэлцлийн зардлыг нэмэгдүүлж, төрийн өмчийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсонги байдалд оруулах эрсдэлийг дагуулж байдаг.

Өөрөөр хэлбэл, төрийн болон орон нутгийн өмчийг эзэмшигчийн дотоод засаглал, хяналтын хүрээнд хэрэгжүүлэх боломж бүхий өмчийн удирдлагыг Улсын Их Хурал, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Засаг дарга, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын түвшинд шийдвэрлэж байгаа нь өмчийн удирдлагын зардал болон үр ашгийн харьцаанд сөргөөр нөлөөлж байна.⁶

-Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч, аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчийн хурал нь орон нутгийн өмчийн өмчлөгч байхаар заасан боловч өмчлөх эрхийг төлөөлөн хэрэгжүүлэх журмыг тодорхой зохицуулаагүйгээс хуулийн хэрэгжилтэд хүндрэл учрах болсон.

Нөгөө талаар төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх этгээдүүдийн чиг үүрэг, эрх хэмжээг хэт ерөнхий болон давхцал, хийдэлтэй зохицуулсны улмаас төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагын чиг үүрэг, хяналт хэрэгжүүлэх эрх хэмжээ хязгаарлагдаж, төрийн өмчийн бүртгэл, хяналтыг нэгдсэн журмаар хэрэгжүүлэхэд хүндрэл учирч, төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, түүнд тавих хяналтыг сулруулж, үр өгөөжгүй захиран зарцуулах сөрөг үр дагаварт хүргэж байна.

Түүнчлэн, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгийн эрх хэт хязгаарлагдмал буюу хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад эд хөрөнгө захиран зарцуулах эрх олгоогүй нь компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх, компанийн үр ашигтай ажиллах боломжийг хязгаарлахад хүргэжээ.

-Орон нутгийн хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь хуулиар тусгайлан олгосон чиг

³ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2025 он.

⁴ Н.Баярмаа, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төсөлд өгөх санал, шүүмж, цуврал №40, 5, (ННФ., 2022).

⁵ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2025 он.

⁶ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2025 он.

үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” хэмээн заасан. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх эрхтэй” гэж хэмээн зааж, өмчлөгчийн эрхийг нь баталгаажуулсан байдаг.

Эдийн засгийн цогцолбор болохын хувьд орон нутаг нь 2021 оны байдлаар 11.901 тэрбум төгрөгийн хөрөнгийг өмчилж байна. Үүнээс нийслэлийн хувьд дангаараа 4.84 тэрбум буюу орон нутгийн нийт өмчийн гуравны нэгээс илүү хувийг өмчилж байна. Харин бодит байдал дээр сум, дүүрэг өөрийн өмчлөлийн хөрөнгөгүй байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санааг амьдрал дээр хэрэгжүүлэх хуулийн зохицуулалт дутмаг байгааг илтгэж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар орон нутгийн өмчийн харилцааг зөвхөн Есдүгээр бүлгээр зохицуулж ирсэн бөгөөд орон нутгийн өмчийг удирдах, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн харилцаа нь зохицуулалтын тодорхойгүй байдалд хүрчээ. Улмаар орон нутгийн өмчийн харилцаа нь тухайн шатны нэгжийн удирдлагаас гаргасан хэм хэмжээний актын хүрээнд өөр хоорондоо ялгаатай байдлаар зохицуулагдаж байна.

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан (2025)-д дурдсанаар төрийн байгууллагад олон тооны журам батлах эрхийг шилжүүлэх байдлаар хуулийн суурь бүтэц, бүрэн эрхийн хуваарилалтыг алдагдуулсан байна. Тухайлбал, төрийн өмчийг бусдад барьцаалуулах шийдвэрийг Улсын Их Хурал, бусдад шилжүүлэх шийдвэрийг Засгийн газар гаргахаар хуульд тус тус заасан нь бүрэн эрхийн хуваарилалтыг ойлгомжгүй болгосон, төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит компани өөрийн өмчлөлийн эд хөрөнгө (эд хогшил зэрэг хөдлөх эд хөрөнгө)-ийн захиран зарцуулах эрхийг хязгаарлаж, гүйлгээнд орох боломжийг хаасан, төрийн өмчийг удирдахтай холбоотой Засгийн газар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан журмууд үйлчилж, хуулийн зохицуулалт дутагдаж байна. Иймд төрийн болон орон нутгийн өмчийг бусдад шилжүүлэх, ашиглуулахтай холбоотой суурь зохицуулалтыг журмаар бус хуульд нарийвчлан тусгаж, хууль тогтоомжийн тодорхой, нэгдмэл байдлыг хангах шаардлага үүсэж байна.

-2022 оны төрийн болон орон нутгийн өмчийн тооллогоор төрийн өмчит 1273, орон нутгийн өмчит 5341 хуулийн этгээд хамрагдсанаас хуулийн этгээдийн гэрчилгээтэй 5484 байгууллага байна. Үүнийг зохион байгууллалтын хэлбэрээр нь ангилж үзвэл, төсөвт байгууллага 4733, ХК 68, ХХК 99, төрийн болон орон нутгийн өмчит ААТҮГ 357, банк 3, төрийн тусгай сан 20, өрхийн эмнэлэг 204 байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд байхаар заасан. Ингэхдээ “төрийн өмчит хуулийн этгээд” гэсэн ерөнхий ухагдахуун үүсгэж түүнийг дотор нь (i) төрийн байгууллага, албан газар, (ii) төрийн өмчит үйлдвэрийн газар, (iii) төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, (iv) төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага /сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсрол/ хэмээн 4 ангилсан байна. Өөрөөр хэлбэл, төрийн өмчит этгээдийн нийтийн ба хувийн эрх зүйн статусыг үл харгалзан “төрийн өмчит хуулийн этгээд” гэсэн нэгдсэн ухагдахуунаар зохицуулсан нь гол алдаа болжээ. Үүний үр

дүнд хоорондоо үйл ажиллагаа нь уялдаагүй, үр ашиг муутай олон компани, сан, төслийн нэгж, үйлдвэрийн газрууд төрөн гарсан гэсэн шүүмжлэлийг дагуулж байна.

Түүнчлэн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд оруулсан 2016 оны нэмэлт, өөрчлөлтөөр төрийн болон орон нутгийн өмчит мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийг, 2023 оны өөрчлөлтөөр төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг төрийн өмчит хуулийн этгээдийн ангилалд тус тус хамааруулахдаа чухам ямар үндэслэл, шалгуурыг баримталсан нь тодорхойгүй байх бөгөөд төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн шалгуураар нь ангилах бүтцийг алдагдуулсан байна.

Иймд (i) төрийн өмчит хуулийн этгээдийн ангиллыг эргэн харж, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг Иргэний хуульд заасан ашгийн төлөө хуулийн этгээдийн хэлбэрээр нэгтгэн зохион байгуулах, (ii) гүйцэтгэх засаглал болон шүүх эрх мэдэл зэрэг төрийн үндсэн чиг үүргийг гүйцэтгэдэг байгууллагыг зөвхөн төсвөөс санхүүжих шаардлагаар бус нийтийг засаглах эрх мэдлийн шалгуураар нэгтгэн Захиргааны ерөнхий хуульд заасан нийтийн эрх зүйн этгээдийн ойлголттой нийцүүлэх, (iii) хувийн эрх зүйн этгээдийн хүрээнд зохион байгуулагдах учиртай төрийн өмчийн компанийн зохицуулалтыг тусгайлсан хууль, эсхүл Компанийн тухай хууль үйлчлэхээр тодорхой заах, (iv) төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх субъектыг байгуулахдаа тухайлсан хуулиар хуулийн этгээдийн эрх олгох болон засаглал, бүтэц, хяналт механизмын тогтолцоог нарийвчлан зохицуулдаг байх өөрчлөлтийг хийх шаардлагатай байна.⁷

-Төрийн болон орон нутгийн өмчийн хуулиар төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг болон хурал, даргын бүрэн эрх, тэдгээрийн эрх мэдлийн хуваарилалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хурлын ирц, шийдвэр гаргах процесстэй холбоотой зохицуулалт тодорхой бус байна.

Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралд төрийн өмчийн эзэмшигч холбогдох яамдын төлөөллийг оролцуулж, хамтын удирдлагын зарчимд тулгуурлан шийдвэр гаргаж байгаа хэдий ч орон тооны бус гишүүд нь бүхэлдээ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яамдын төлөөллөөс бүрдэж байна. Иймд тус газрын бүрэлдэхүүнд төрийн өмчийг удирдахад зохих мэдлэг, ур чадвар бүхий хөндлөнгийн этгээдийг оролцуулах замаар мэргэшсэн байдлыг хангах, хяналтыг бэхжүүлэх шаардлагатай байна.

-Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хийх мэргэжлийн хяналтын хувьд 2016 он хүртэл Төрийн өмчийн хороо, түүнээс хойш Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нэртэйгээр өөрчлөн зохион байгуулсан ч орон нутгийн өмч хариуцсан газар бүрэн бэхжээгүй, төрийн өмчит хуулийн этгээдэд тус газраас хяналт шалгалт хийсэн ч албан хаагч нь бусад төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллагын адил улсын байцаагчийн эрх олгогдоогүйгээс хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах зэрэг эрх хэмжээ хуулиар олгогдоогүй. Энэ нь төрийн өмчийн хөрөнгийг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллагын зүгээс хийх төрийн мэргэжлийн хяналтыг үр дүнгүй болгох тул (i) Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төрийн өмчид тавих мэргэжлийн

⁷ Мөн тэнд.

хяналтын чиг үүргийг тодорхой болгох, (ii) улмаар хяналт тавих албан хаагчид улсын байцаагчийн статус олгож, мэргэжлийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

-Одоогийн хууль, эрх зүйн орчинд төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим систем үүсгэх, мэдээллийн сан бүрдүүлэх эрх зүйн үндэс бүрдээгүй бөгөөд цахим системээр дамжуулан олон нийтэд төрийн болон орон нутгийн өмчийн нээлттэй тайлан, мэдээлэл гаргах үүргийн зохицуулалт байхгүй байна.

Иймд төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим сан үүсгэх эрх зүйн үндсийг хуулиар тогтоох, түүний аюулгүй байдал, засвар шинэчлэлт, мэдээллийн найдвартай байдлыг хангах, тухайн цахим мэдээллийн системд байршуулах төрийн өмчит хуулийн этгээдийн тайланг тодорхой болгож, зөвхөн санхүүгийн тайлан бус олон нийтэд ойлгомжтой байдлаар тайлбарласан өмчийн төлөв байдал, бүртгэл, тооллого зэрэгтэй холбоотой тайлан гаргах зохицуулалтыг бий болгох замаар өмчийн ил тод байдлыг хангах шаардлагатай байна.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагын хүрээнд Монгол Улсын зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үеийн төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, өмч хувьчлалын зохицуулалтаас өмчийг зохистой удирдах, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эрх зүйн шинэчлэлийг хийх практик шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн нэрийг Иргэний хуульд заасан өмчийн төрөлд нийцүүлэн өргөжүүлж, нийтийн өмчийн суурь харилцааг зохицуулах хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12, 28 дугаар зүйлийн 28.5.2-т заасны дагуу “Нийтийн өмчийн хууль” гэж өөрчилж, нийтийн өмчийг удирдах зарчим, өмчийн зориулалт, ангилал болон өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх нийтлэг харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ. Ингэхдээ төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг тус хуулиар, харин олон нийтийн болон шашны өмчийн харилцааг уг хуульд нийцүүлэн тухайлсан хуулиар зохицуулахаар тусгана.

Энэ хүрээнд хуулийн зорилтыг нийтийн өмч, түүний ангилал, өмчийн удирдлага, нийтийн өмчид хөрөнгө олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах, бүртгэл, тооллого, тайлагнал, хяналт, ил тод байдлыг хангахтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулах гэсэн агуулгаар өргөжүүлэн тодорхойлж, хуулийн төсөлд дараах зарчмын өөрчлөлтийг тусгана:

1.Нийтийн өмч, түүний дотор төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалт, хяналтын нэгдмэл байдлыг хангах зорилгоор хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэхийн зэрэгцээ хуулийн үйлчлэлд хамаарахгүй боловч тухайлсан хуулиар нарийвчлан зохицуулах харилцааг бусад хууль тогтоомж болон эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан тодорхойлно;

2.Хуулийн нэр томъёог Монгол Улсын Үндсэн хууль болон Иргэний хуульд нийцүүлэн шинэчилж, төрийн болон орон нутгийн өмчийн харилцаанд баримтлах зарчимд өмчийн удирдлага нэгдмэл байх, өмчийн удирдлагыг хуулиар тогтоосон

хязгаарлалтын хүрээнд хэрэгжүүлэх, тооцоо, судалгаанд үндэслэсэн, тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байх зэрэг тусгай зарчмыг тусган хуульчилна;

3.Төрийн болон орон нутгийн өмчийн ангиллыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн шинэчилж, төрийн өмчийн өмчлөгч нь Улсын Их Хурал, орон нутгийн өмчийн өмчлөгч нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал байх зарчмыг хэвээр хадгалж, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч этгээдүүдийн эрх хэмжээний давхцал, ойлгомжгүй байдлыг арилгаж, харилцан уялдаатай байдлаар зохицуулна. Мөн төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн өмчийн газрын чиг үүргийг тодруулан хуульчилна;

4.Төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөгч, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, өмчийн эзэмшигч этгээдийн эрх зүйн байдлыг хөрөнгийн эрхийн байдалтай нь уялдуулан оновчтой тогтооно. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн өмчийн удирдлага болон хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, гүйцэтгэх удирдлагыг томилох зэрэг асуудлыг төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай бие даасан хуулиар зохицуулахаар хуульчилна;

5.Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэх асуудлыг үр ашигтай, шударга байдлаар хэрэгжүүлэх журам, аргыг нарийвчлан хуульчилна. Энэ хүрээнд төрийн өмчийг нийтийн эрх ашгийн төлөө түр ашиглуулах зориулалт, гэрээний нөхцөл, төрийн болон орон нутгийн өмчийг бусдын өмчлөлд шилжүүлэх ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх журмыг шинээр тогтооно;

6.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн нэгдмэл тогтолцоо, түүний бүрдэл хэсэг (төрийн нийтийн болон тусгайлсан өмч, орон нутгийн өмч)-ийг тодорхойлж, хөрөнгө бүртгэх, тоолох, үнэлэх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулна. Төрийн болон орон нутгийн өмчийн эдийн болон эдийн бус хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэхтэй холбоотой гэрээний бүртгэлийг бий болгож, холбогдох мэдээллийн ил тод байдлыг хангах хууль зүйн үндэслэлийг бүрдүүлнэ;

7.Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалтын хяналт шалгалт, сахилга, хариуцлагын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлж, өмчлөгч болон төрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг нарийвчлан зохицуулж, Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн газраас хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндэслэл, журмыг тодорхойлно;

8.Төрийн болон орон нутгийн өмчийг удирдах үйл ажиллагааны ил тод байдал болон олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор өмчийн бүртгэл, тайлагналттай холбоотой журмыг шинэчилж, өмчийн бүртгэл, хөдөлгөөн, хяналт шалгалтын талаарх мэдээллийг тусгасан төлөв байдлын тайланг гаргаж, Улсын Их Хурал, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах, тайланг олон нийтэд нээлттэй байршуулах талаар нарийвчлан зохицуулна;

9.Төрийн болон орон нутгийн өмчийн төрөл, ангилал, үнэлгээ, өмчийн хөдөлгөөн, тооллого, тайлан, хяналт шалгалттай холбоотой мэдээллийг төвлөрүүлсэн “Мэдээллийн нэгдсэн сан”-г бүрдүүлж, санг эрхлэн хөтлөх, мэдээллийг баталгаажуулах болон хадгалалт, хамгаалалтыг хэрэгжүүлэх журмыг хуульчилна;

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан хэлбэр, мөн хуулийн 28-30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчийн төрөл, хөрөнгийн ангилал, өмчлөх эрх болон өмчийн удирдлага хэрэгжүүлэх субьектын чиг үүрэг, үйл ажиллагааны үндэслэл, журам тодорхой болж, төрийн болон орон нутгийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, үр ашиг, үнэлгээг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Мөн төрийн болон орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой хууль хоорондын хийдэл, зөрчил арилж, төрийн нийтийн өмчид хамаарах газар, байгалийн баялаг болон бусад хөрөнгийн удирдлагын нэгдмэл тогтолцоо, Монгол Улсын Үндсэн хуульд тодорхойлсон байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчим бодитой хэрэгжих хууль зүйн суурь нөхцөл бүрдэнэ.

Төрийн болон орон нутгийн өмчтэй холбоотой шийдвэр хариуцлагатай, ил тод, нээлттэй байх, төрийн үйлчилгээ түргэн шуурхай, хүнд суртлаас ангид байх зарчмын хэрэгжилт хангагдаж, төрийн болон орон нутгийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах болон үнэлэх, бүртгэх, эзэмших, ашиглах үйл ажиллагаа нийтийн эрх ашигт нийцсэн, үр ашигтай байх хууль зүйн үндэслэл бүрдэнэ.

Өмчийн удирдлагын эрх мэдлийн хуваарилалтыг оновчилж, төрийн болон орон нутгийн өмчийн хөдөлгөөний шийдвэр гаргалтын процессыг хялбаршуулж, нэгдсэн хяналтын механизмыг бүрдүүлснээр өмчийн удирдлагын үр ашиг болон зардлын харьцаа сайжирна.

Төрийн болон орон нутгийн өмчийн үр ашигт байдлыг дээшлүүлж, хөрөнгийг бүрэн бүртгэж өмчлөх эрхийг баталгаажуулснаар төрийн өмч нэрийн дор хэн нэгэн эрх мэдэлтэн, албан тушаалтан хувьдаа шамшигдуулах, зүй бус үйлдэл гаргахаас сэргийлэх, улмаар төрд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төслийн Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буюу Нийтийн өмчийн хуулийн төслийг хуульд заасан шаардлагын дагуу Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн, Иргэний хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд болон бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсруулна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэн найруулж байгаатай холбогдуулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 25.2-т заасны дагуу 1996 оны 05 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан Төрийн болон орон нутгийн

өмчийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулна.

Түүнчлэн, Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигч этгээдийн ангиллын шинэчлэлд нийцүүлэн хуулийн этгээдийг татан буулгах, өөрчлөн байгуулах зэрэг арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд, хугацааг тогтоосон шилжилтийн үеийн зохицуулалт бүхий Нийтийн өмчийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулна.

Мөн хуулийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан, түүнчлэн хуульд заасан нэр томъёог жигдлэх, зохицуулалт хоорондын уялдааг хангах зорилгоор Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Музейн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулалт тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

---o0o---

НИЙТИЙН ӨМЧИЙН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж, Иргэний хуулийн 99 дүгээр зүйлийн 99.2 дахь хэсэгт “Нийтийн өмч нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй байна” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. ...Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно”, Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх,... эрхтэй.” гэсэн зарчмыг хуульчлан баталгаажуулсан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-т төрийн нийтийн өмчийн зохицуулалтыг тодорхой болгохоор зааж, тус хуваарийн 1.1.1-д “...стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны үр өгөөжийн дийлэнх нь буюу тавиас дээш хувь нь монголын ард түмэнд ногдох, шаардлагатай бол иргэдийн саналыг харгалзан Улсын Их Хурал хэлэлцэн байгалийн баялаг ард түмний мэдэлд, төрийн нийтийн өмч байх эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ энэхүү баялгийг төр өмчлөх...зарчмыг хуульчлах;”, 1.2.6-д “төрийн нийтийн өмчийг зохистой ашиглах, зарцуулахад тавих хяналтыг боловсронгуй болгох.”, 4.3.2-т “аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх,...эрх зүйн үндсийг бүрдүүлэх;”, 4.3.3-т “аймаг, нийслэл, сум, дүүргийн эрх зүйн байдал, өмчийн болон төсвийн харилцааг тусгайлсан хуулиар ялгамжтай зохицуулах,...” гэж тусгажээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтын 5.2.6-д “Бие даан хөгжих боломжийг бүрдүүлсэн орон нутгийн өмч, татварын боловсронгуй тогтолцоо бүхий эдийн засаг, санхүүгийн эрх мэдлийг орон нутагт шилжүүлнэ” гэж, 5.2.19-д “Төрийн компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна” гэж тус тус заасан байна.

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.4.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах

зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх, төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, үр өгөөж, хяналтыг сайжруулах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчилнэ.” гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.1.1-д “Төрийн болон орон нутгийн өмч, түүний ангилал, өмчийн удирдлага, төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх, бүртгэл, тооллого, тайлагналт, хяналт, ил тод байдалтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулах” хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэхээр тусгажээ.

Монгол Улс 1990 оноос зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбогдуулан 1996 онд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг анх баталсан бөгөөд уг хууль нь шилжилтийн үеийн төрийн болон орон нутгийн өмчийн талаарх төрийн байгууллагын эрх хэмжээг тогтоон, өмч хувьчлалыг зохицуулахад чиглэсэн байдаг. Гэтэл нийгэм, эдийн засгийн харилцаа хурдацтай өөрчлөгдөхийн хэрээр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зохицуулалт нь цаг үеийн нөхцөл байдалтай нийцэхгүй, нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцрох болжээ.¹

Тухайлбал, хууль батлагдсанаас хойш нийт 39 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд тэдгээрийн дийлэнх нь тус хуулийн зохицуулалттай холбоотой тулгарч байгаа бэрхшээлийг шийдвэрлэхэд бус харин салбарын бусад хууль шинэчлэгдсэн, эсхүл тэдгээрт нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой байна. Өөрөөр хэлбэл, хуулийн нийт зүйлийн 80 орчим хувьд өөрчлөлт орсон ч тэдгээр нь нэгдсэн бодлого, зарчмаар биш салангид байдлаар өөр, өөр зорилгын хүрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт байна.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойших өнгөрсөн 29 жилийн хугацаанд нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг дагаж өмчийн харилцаатай холбоотой эрх зүйн зохицуулалтын хүрээнд томоохон өөрчлөлтүүд гарсны дотор 2002 онд Иргэний хууль, Газрын тухай хууль батлагдаж, 2005, 2023 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 2011 онд Төсвийн тухай хууль, Компанийн тухай хууль, 2020 онд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдсэн зэрэг төрийн болон орон нутгийн үйл ажиллагаа, өмч болон бизнесийн харилцааг зохицуулсан хуулийн шинэчлэл томоохон байр суурийг эзэлнэ.

Ийнхүү Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зохицуулалтын хийдэлтэй болон эрх зүйн шинэчлэлээс хоцорсон, хуульд цаг үеийн шинжтэй, бусад салбарын хуулийн өөрчлөлттэй уялдуулсан нэмэлт, өөрчлөлтийг удаа дараа оруулсан зэрэг нь хуулийн зохицуулалтын нэгдмэл, цогц байдлыг алдагдуулахад хүргэжээ.

Иймд эрх зүйн шинэчлэл, бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилтын хүрээнд нийтийн өмч, түүний дотор төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх, хууль хоорондын давхардал, хийдлийг арилгах, төрийн болон орон нутгийн өмчийн ангилал, хэлбэрийг зохистой тогтоож, өмчийн удирдлага, бүртгэл, ашиглалт, хамгаалалт, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн

¹ “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”, 2025 он.

болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн нэрийг Иргэний хуульд заасан өмчийн төрөлд нийцүүлэн өргөжүүлж, нийтийн өмчийн суурь харилцааг зохицуулах хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12, 28 дугаар зүйлийн 28.5.2-т заасны дагуу “Нийтийн өмчийн хууль” гэж өөрчилж, нийтийн өмчийг удирдах зарчим, өмчийн зориулалт, ангилал болон өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх нийтлэг харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ. Ингэхдээ төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг тус хуулиар, харин олон нийтийн болон шашны өмчийн харилцааг уг хуульд нийцүүлэн тухайлсан хуулиар зохицуулахаар тусгалаа.

Энэ хүрээнд хуулийн зорилтыг “нийтийн өмч, түүний ангилал, өмчийн удирдлага, нийтийн өмчид хөрөнгө олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах, бүртгэл, тооллого, тайлагнал, хяналт, ил тод байдлыг хангахтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулах”-аар өргөжүүлэн тодорхойлсон.

Хуулийн төсөлд дараах зарчмын өөрчлөлтийг тусгалаа:

1.Нийтийн өмч, түүний дотор төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалт, хяналтын нэгдмэл байдлыг хангах зорилгоор хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэхийн зэрэгцээ хуулийн үйлчлэлд хамаарахгүй боловч тухайлсан хуулиар нарийвчлан зохицуулах харилцааг бусад хууль тогтоомж болон эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан тодорхойлсон;

2.Хуулийн нэр томъёог Монгол Улсын Үндсэн хууль болон Иргэний хуульд нийцүүлэн шинэчилж, төрийн болон орон нутгийн өмчийн харилцаанд баримтлах зарчимд өмчийн удирдлага нэгдмэл байх, өмчийн удирдлагыг хуулиар тогтоосон хязгаарлалтын хүрээнд хэрэгжүүлэх, тооцоо, судалгаанд үндэслэсэн, тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байх зэрэг тусгай зарчмыг шинээр тусгасан;

3.Төрийн болон орон нутгийн өмчийн ангиллыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн шинэчилж, төрийн өмчийн өмчлөгч нь Улсын Их Хурал, орон нутгийн өмчийн өмчлөгч нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал байх зарчмыг хэвээр хадгалж, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч этгээдүүдийн эрх хэмжээний давхцал, ойлгомжгүй байдлыг арилгаж, харилцан уялдаатай байхаар тусгасан. Мөн Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газрын хяналтын чиг үүргийг тодруулан хуульчилсан, түүнчлэн, Төрийн өмчийн хорооны бүрэлдэхүүнд хөрөнгийн удирдлага, хөрөнгийн үнэлгээ, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэшсэн иргэнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилж ажиллуулах боломжийг бүрдүүлээ;

4.Төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөгч, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, өмчийн эзэмшигч этгээдийн эрх зүйн байдлыг хөрөнгийн эрхийн байдалтай нь уялдуулан оновчилж тогтоосон. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн өмчийн удирдлага болон хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, гүйцэтгэх удирдлагыг томилох зэрэг асуудлыг төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай бие даасан хуулиар зохицуулахаар тусгасан;

5.Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэх асуудлыг үр ашигтай, нээлттэй, ил тод байдлаар хэрэгжүүлэх журам, аргыг нарийвчлан тусгасан. Энэ хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийтийн эрх ашгийг хангах зорилгоор өмчийг ашиглуулах, шилжүүлэх үндэслэл, зорилго, гэрээний нөхцөл, талуудын хүлээх эрх, үүргийг тодорхой хуульчилж, өмчийг бусдын өмчлөлд шилжүүлсний дараа хэрэгжүүлэх хяналтын зохицуулалтыг шинээр тусгасан;

6.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн нэгдмэл тогтолцоо, түүний бүрдэл хэсгийг тодорхойлж, хөрөнгө бүртгэх, тоолох, үнэлэх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан. Төрийн нийтийн өмчийн нэгдсэн бүртгэл, тооллого, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн дагнасан бүртгэлийг хийх, хөрөнгийн өөрчлөлт, хөдөлгөөн, хөрөнгө эзэмшигчийн мэдээллийг нээлттэй байлгах хууль зүйн үндэслэлийг бүрдүүлсэн;

7.Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалтын хяналт шалгалт, сахилга, хариуцлагын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлж, өмчлөгч болон төрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг нарийвчлан зохицуулж, Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн газраас хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндэслэл, журмыг тодорхойлсон;

8.Төрийн болон орон нутгийн өмчийг удирдах үйл ажиллагааны ил тод байдал болон олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор өмчийн бүртгэл, тайлагналттай холбоотой журмыг шинэчилж, өмчийн бүртгэл, хөдөлгөөн, өмчийн ашиглалтын менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл, хяналт шалгалтын талаарх мэдээллийг тусгасан төлөв байдлын тайланг гаргаж, Улсын Их Хурал, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах, тайланг олон нийтэд нээлттэй байршуулах талаар нарийвчлан тусгасан;

9.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого, үнэлгээ, өмчийн хөдөлгөөн, тайлан, хяналт шалгалттай холбоотой мэдээллийг төвлөрүүлсэн цахим систем, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, эрхлэн хөтлөх, хөгжүүлэх, мэдээллийг баталгаажуулах болон хадгалалт, хамгаалалтыг хэрэгжүүлэх журмыг тодорхой хуульчилсан.

Хуулийн төсөл нь 9 бүлэг, 81 зүйлтэй бөгөөд хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар зохицуулахаар тусгасан:

-Хуулийн төслийн Нэгдүгээр бүлэг буюу нийтлэг үндэслэлд хуулийн төслийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, нийтийн өмчийг удирдах зарчмын талаар тусгалаа. Хуулийн зорилт нь нийтийн өмч, түүний ангилал, өмчийн удирдлага, нийтийн өмчид хөрөнгө олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах, бүртгэл, тооллого, тайлагнал, хяналт, ил тод байдлыг хангахтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

Тус хуулиар нийтийн өмчийг удирдахтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулах бөгөөд нийтийн өмчийг удирдахтай холбоотой тухайлсан хуулиар зохицуулах харилцааг жагсаах байдлаар хуульд нэрлэн заасан болно. Тухайлбал, олон нийтийн болон шашны өмч, улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит компани, газар, төрийн худалдан авах ажиллагаа, соёлын биет

өв, төр, хувийн хэвшлийн түншлэл болон төрийн нийтийн өмчид хамаарах газрын хэвлий, түүний баялаг, ой, ус, ургамал, ан амьтан, палеонтологи, археологийн олдвор, төрийн архивын сан хөмрөг зэргийн бүртгэл, тооллогыг зохион байгуулах, ашиглуулах, түүнд тавих хяналттай холбогдсон харилцааг тухайлсан зохицуулахаар тусгасан.

Ингэхдээ тухайлсан хуулиар тогтоох нийтийн өмчийг удирдахтай холбоотой зохицуулалт нь тус хуульд заасан өмчийг удирдах зарчим, өмчийн зориулалт, ангилал болон өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх нийтлэг эрх хэмжээнд нийцсэн байхыг баталгаажуулан хуульчилсан.

“Өмчийн удирдлага” гэдэгт гэж төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөгч, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, өмчийн эзэмшигчээс өмчийг бусдад ашиглуулах, шилжүүлэх үйл ажиллагааг ойлгохоор зааж, өмчийн удирдлагын тогтолцоог өмчлөгч, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, өмчийн эзэмшигч гэсэн субьектын хүрээнд хэрэгжүүлэх буюу өмчийн удирдлагын эрх хэмжээг зааглах нөхцөлийг бүрдүүлсэн.

Нийтийн өмчийг удирдах зарчмын хүрээнд өмчийг удирдах төрийн бодлого нэгдмэл байх, хуульд заасан зорилго, тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байх, тооцоо, судалгаанд үндэслэсэн, үр нөлөөтэй, үр ашигтай байх, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зэрэг зарчмыг шинээр баталгаажуулан хуульчилсан.

-Хуулийн төслийн Хоёдугаар бүлэгт нийтийн өмчийн хэлбэр, ангиллыг Иргэний хуульд заасантай нийцүүлэн төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй байх, эдийн болон эдийн бус хөрөнгөөс бүрдэхээр заасан.

1996 оны Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан “төрийн нийтийн зориулалтай өмч” гэснийг Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “төрийн нийтийн өмч” гэсэн хууль зүйн нэр томъёонд нийцүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үүнээс гадна “төрийн нийтийн өмч”-ийн жагсаалтыг өргөжүүлэх нь зохистой байна.²

Энэ хүрээнд хуулийн төсөлд төрийн өмч нь төрийн нийтийн болон төрийн тусгайлсан өмчөөс бүрдэхээр зааж, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар ард түмний мэдэлд байхаар заасан дараах байгалийн баялаг, хөрөнгийг төрийн нийтийн өмчид хамаарахаар нэрлэн заасан. Энэ хүрээнд Үндэсний баялгийн сангийн хөрөнгө, палеонтологи, археологийн олдвор, төрийн архивын сан хөмрөг, стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг төрийн нийтийн өмчид хамааруулсан. Харин төрийн тусгайлсан өмчийн хувьд төрийн байгууллага, төрийн нийтийн үйлчилгээний байгууллагын хөрөнгө, улсын төсвийн хөрөнгө, төрийн өмчийн хөрөнгөөр бүтээсэн, олж авсан оюуны өмч, эрх, төрийн үйл ажиллагаанд хамаарах хуульд заасан бүртгэл, мэдээллийн сан зэргийг хамааруулахаар тусгасан.

Орон нутгийн өмчийн эрх зүйн үндсийг 2020 онд батлагдсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар бэхжүүлсэн. Энэ нь цаашид аймаг, нийслэл төдийгүй сум, дүүрэг нь өөрийн чиг үүргийн хүрээнд өөртөө хөрөнгийг олж авч, бие даасан эдийн засгийн цогцолбор

² Мөн тэнд.

болон хөгжих боломжийг бүрдүүлсэн хэмээн ойлгож болно. Гэсэн хэдий ч 1996 оны Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль нь орон нутгийн өмчийн харилцааг зөвхөн Есдүгээр бүлгээр зохицуулжээ. Өөрөөр хэлбэл, орон нутгийн өмчийг удирдах, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдох харилцаа нь зохицуулалтын хувьд тодорхойгүй байдалд хүрсэн, өнөөгийн байдлаар сум, дүүрэг нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх өөрийн өмчлөлийн хөрөнгөгүй хэвээр байна.³

Иймд хуулийн төсөл орон нутгийн өмч нь аймаг, сум, нийслэл, дүүргийн өмчөөс бүрдэхээр зааж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан тодорхой чиг үүрэгтэйгээ уялдсан байдлаар өмчтэй байх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Тухайлбал, сум, дүүргийн өмчид сум, дүүргийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын хөрөнгө, сум, дүүргийн төсөв, сум, дүүргийн өмчийн хөрөнгөөр байгуулсан нийтийн эзэмшлийн гудамж, талбай, хөшөө дурсгал, олон нийтийн соёл, амралтын хүрээлэн, ногоон байгууламж, авто зам, авто зогсоол болон төвлөрсөн бус ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн байгууламж зэрэг нийтийн хэрэгцээнд зориулсан хөрөнгө, сум, дүүргийн эзэмшлийн үнэт цаас зэргийг хамаарахаар тодорхой тусгаж өгсөн.

Мөн хот, тосгоны өмчийн харилцаанд энэ хуульд заасан орон нутгийн өмчийн зохицуулалт нэгэн адил үйлчлэхээр зохицуулж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 68, 69 дүгээр зүйлд заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэхтэй холбогдуулан тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төрийн болон орон нутгийн өмчийг хот, тосгонд шилжүүлэх талаар тусгайлан заасан.

-Хуулийн төслийн Гуравдугаар бүлэгт төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, зохион байгуулалттай холбоотой харилцааг тусгасан. Улсын Их Хурал нь Монгол Улсын ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байх зарчмыг хэвээр хадгалж, Засгийн газар нь хуульд заасан эрх хэмжээний хүрээнд төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлж, төрийн өмчийн үр нөлөөтэй, үр ашигтай байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцахаар тусгалаа.

Энэ хүрээнд Улсын Их Хурал нь бусдын өмчлөлд шилжүүлж үл болох төрийн тусгайлсан өмчийн жагсаалт батлах, төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө, эд юмсын хязгаарлагдмал эрхийг орон нутгийн өмчид шилжүүлэх, нийтийн эрх ашиг, нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн орон нутгийн өмчийг төрийн өмчид шилжүүлэн авах талаар Засгийн газрын саналыг хэлэлцэж, шийдвэрлэх, төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэлийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр хэлэлцэж, батлах, стратегийн ач холбогдол бүхий салбар дахь төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлэх, барьцаалуулах талаар Засгийн газрын саналыг хэлэлцэж, зөвшөөрөл олгох зэрэг бүрэн эрхтэй байхаар хуульчилсан.

Харин Засгийн газар нь төрийн тусгайлсан өмчийг удирдахтай холбогдуулан төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшлийн үл хөдлөх эд хөрөнгө, түүнийг дагалдах хөрөнгө, үл хөдлөх эд хөрөнгөд үүссэн эд юмсын хязгаарлагдмал эрх болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 500 дахин нэмэгдүүлснээс доошгүй хэмжээний нэг бүрийн балансын үнэ бүхий хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалуулах, төрийн өмчийн үл

³ Мөн тэнд.

хөдлөх эд хөрөнгийг таваас арав хүртэлх жилийн хугацаагаар, эсхүл эд хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхээр бусдад ашиглуулах зэрэг шийдвэр гаргах эрхтэй байхаар заасан.

Мөн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрх зүйн статус, нэрийг өөрчилж, төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж, Засгийн газрын бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага-Засгийн газрын тохируулагч агентлаг буюу Төрийн өмчийн хороо болгон өөрчлөн байгуулахаар тусгалаа.

Ингэхдээ хамтын удирдлагын зарчмаар хуралдааны үндсэн дээр үйл ажиллагаа явуулах зохицуулалтыг хэвээр хадгалж, Төрийн өмчийн хороо нь дарга болон орон тооны бус 8 гишүүнтэй байхаар заасан бөгөөд хорооны даргад тавих шаардлага, бүрэн эрх, түүнийг томилж, чөлөөлөхтэй холбогдсон харилцааг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулиар, хорооны гишүүнийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас санал болгосноор Засгийн газар 4 жилийн хугацаагаар томилохоор тус тус зохицуулсан.

Мөн төрийн өмчийн хорооны 3 гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилох ба хөрөнгийн удирдлага, хөрөнгийн үнэлгээ, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэшсэн, тухайн чиглэлээр таваас доошгүй жил ажилласан туршлагатай, удирдан зохион байгуулах чадвартай хөндлөнгийн, мэргэжлийн этгээдийг хорооны бүрэлдэхүүн орж ажиллах боломжийг бүрдүүлээ.

Өмчийг удирдах төрийн бодлого нэгдмэл байх зарчмын хэрэгжилтийг хангах үүднээс Төрийн өмчийн хороо нь аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн газрыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах асуудлаар үүрэг, чиглэл өгөх чиг үүргийг хэрэгжүүлнэ. Мөн Төрийн өмчийн хороо нь төрийн тусгайлсан өмчийг удирдахтай холбогдуулан төрийн байгууллага, төрийн нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшлийн хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалуулах, төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг гурван сараас тав хүртэлх жилийн хугацаагаар, эсхүл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 500 дахин нэмэгдүүлснээс доошгүй хэмжээний нэг бүрийн балансын үнэ бүхий хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг бусдад ашиглуулах зөвшөөрөл олгох эрх хэмжээтэй байна.

2022 оны төрийн болон орон нутгийн өмчийн тооллогоор төрийн өмчит 1273, орон нутгийн өмчит 5341 хуулийн этгээд хамрагдсанаас хуулийн этгээдийн гэрчилгээтэй 5484 байгууллага байна. Үүнийг зохион байгууллалтын хэлбэрээр нь ангилж үзвэл, төсөвт байгууллага 4733, ХК 68, ХХК 99, төрийн болон орон нутгийн өмчит ААТҮГ 357, банк 3, төрийн тусгай сан 20, өрхийн эмнэлэг 204 байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд байхаар заасан. Ингэхдээ “төрийн өмчит хуулийн этгээд” гэсэн ерөнхий ухагдахуун үүсгэж түүнийг дотор нь (i) төрийн байгууллага, албан газар, (ii) төрийн өмчит үйлдвэрийн газар, (iii) төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, (iv) төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага /сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсрол/ хэмээн 4 ангилсан байна. Өөрөөр хэлбэл, төрийн өмчит

этгээдийн нийтийн ба хувийн эрх зүйн статусыг үл харгалзан “төрийн өмчит хуулийн этгээд” гэсэн нэгдсэн ухагдахуунаар зохицуулсан нь гол алдаа болжээ. Үүний үр дүнд хоорондоо үйл ажиллагаа нь уялдаагүй, үр ашиг муутай олон компани, сан, төслийн нэгж, үйлдвэрийн газрууд төрөн гарсан гэсэн шүүмжлэлийг дагуулж байна.

Түүнчлэн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд оруулсан 2016 оны нэмэлт, өөрчлөлтөөр төрийн болон орон нутгийн өмчит мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийг, 2023 оны өөрчлөлтөөр төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг төрийн өмчит хуулийн этгээдийн ангилалд тус тус хамааруулахдаа чухам ямар үндэслэл, шалгуурыг баримталсан нь тодорхойгүй байх бөгөөд төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн шалгуураар нь ангилах бүтцийг алдагдуулсан байна.

Иймд (i) төрийн өмчит хуулийн этгээдийн ангиллыг эргэн харж, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг Иргэний хуульд заасан ашгийн төлөө хуулийн этгээдийн хэлбэрээр нэгтгэн зохион байгуулах, (ii) гүйцэтгэх засаглал болон шүүх эрх мэдэл зэрэг төрийн үндсэн чиг үүргийг гүйцэтгэдэг байгууллагыг зөвхөн төсвөөс санхүүжих шаардлагаар бус нийтийг засаглах эрх мэдлийн шалгуураар нэгтгэн Захиргааны ерөнхий хуульд заасан нийтийн эрх зүйн этгээдийн ойлголттой нийцүүлэх, (iii) хувийн эрх зүйн этгээдийн хүрээнд зохион байгуулагдах учиртай төрийн өмчийн компанийн зохицуулалтыг тусгайлсан хууль, эсхүл Компанийн тухай хууль үйлчлэхээр тодорхой заах, (iv) төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх субъектыг байгуулахдаа тухайлсан хуулиар хуулийн этгээдийн эрх олгох болон засаглал, бүтэц, хяналт механизмын тогтолцоог нарийвчлан зохицуулдаг байх өөрчлөлтийг хийх шаардлагатай байна.⁴

Энэ хүрээнд хуулийн төсөлд “төрийн өмчийн эзэмшигч” нь төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад төрийн өмчийг хууль тогтоомжид заасны дагуу захиран зарцуулах эрхтэй байхаар тодорхой зааж, төрийн өмчийн эзэмшигчийг төрийн байгууллага, төрийн нийтийн үйлчилгээний байгууллага, төрийн өмчит компани гэж ангилахаар тусгасан.

Төрийн байгууллагын хувьд төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг төв болон орон нутгийн бүх шатанд хэрэгжүүлэх зорилгоор хуульд заасны дагуу байгуулагдсан, төсвөөс санхүүждэг байгууллага, түүний үндсэн чиг үүргийг хариуцсан харьяа нэгжийг ойлгох бөгөөд Төв Банк /Монголбанк/, Харилцаа холбооны зохицуулах хороо, Эрчим хүчний зохицуулах хороо болон түүнтэй адилтгах төрийн тухайлсан чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулсан, төсвөөс санхүүждэггүй, бие даасан хуулиар үйл ажиллагаа нь зохицуулагдаж байгаа нийтийн эрх зүйн бусад этгээдийг мөн төрийн байгууллагад хамааруулж үзнэ.

Мөн “нийтийн үйлчилгээний байгууллага” гэдэгт төрийн чиг үүрэгт хамаарах боловсрол, эрүүл мэнд, соёл спорт, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүч зэрэг нийтийн үйлчилгээ үзүүлэх, төрийн байгууллагад чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой, хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийг ойлгохоор зааж, төрийн нийтийн үйлчилгээний байгууллагыг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц, орон тооны дээд хязгаар, дүрмийг Засгийн газар баталж мөрдүүлэхээр зохицуулсан. Харин Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг болон Улсын Их Хурлаас байгуулдаг

⁴ Мөн тэнд.

байгууллагын харьяанд ажиллах нийтийн үйлчилгээний байгууллага болон боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх нийтийн үйлчилгээний байгууллагыг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, дүрмийг батлах болон бүтэц, зохион байгуулалт, хяналттай холбоотой харилцааг тухайлсан хуулиар зохицуулахаар тусгасан болно.

Түүнчлэн, “төрийн өмчит компани” гэдэгт Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуульд заасан холбогдох хуулийн этгээдийг ойлгохоор зааж, хууль хоорондын нэр томьёоны нийцлийг хангасан.

Мөн дээрх удирдлагын зарчмын дагуу аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн орон нутагт оршин суугаа иргэдийг төлөөлөн орон нутгийн өмчийн өмчлөгч байх, Засаг дарга нь хуульд заасан эрх хэмжээний хүрээнд орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлж, орон нутгийн өмчийн үр нөлөөтэй, үр ашигтай байдлыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө хариуцах, тухайн орон нутагт төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж, орон нутгийн нэгжийн удирдлагын өмчийн талаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих чиг үүргийг Орон нутгийн өмчийн газар хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгалаа.

-Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэгт төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, төрийн болон орон нутгийн өмчийг бусдад ашиглуулах, шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар тусгасан.

Энэ хүрээнд төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах үндэслэлийг тодорхой хуульчилсан бөгөөд эрх бүхий байгууллагын баталсан төсөв, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу худалдан авсан, эсхүл хөрөнгө зарцуулсны үр дүнд бий болсон хөрөнгө, өмчийн хөрөнгийн ашиглалтаас бий болсон үр шим, ашиг, орлого, үйлчилгээ, үйл ажиллагаанаас бий болсон орлого, эдийн болон эдийн бус баялаг, шаардах эрх, хохирлын нөхөн төлбөр, даатгалын нөхөн олговорт авсан хөрөнгө, хуульд заасны дагуу хандив, тусламж, бэлэглэл, өв, эрх залгамжлах журмаар олж авсан хөрөнгө, зээлээр, эсхүл сольж авсан хөрөнгө зэргийг нэг бүрчлэн үндэслэл болгон заасан. Мөн эдгээрээс хандив, тусламж, бэлэглэл, өв, эрх залгамжлах журмаар болон улсын орлого болгох, эсхүл төрийн өмчид шилжүүлэх шийдвэрийн дагуу хураагдсан хөрөнгө олж авах харилцааг нарийвчлан зохицуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийтийн эрх ашгийг хангах зорилгоор гэрээний үндсэн дээр төлбөртэй, хөнгөлөлттэй нөхцөлөөр, хариу төлбөргүй, эсхүл эд юмсын хязгаарлагдмал эрхээр бусдад ашиглуулах бөгөөд өмчийн эзэмшигчид тухайн хөрөнгө түр хугацаагаар хэрэгцээгүй болсон, өмчийг нөөцлөх, хадгалах нөхцөлийг хангахгүй болсон, илүү талбай, хэсэг гарсан гэсэн үндэслэлээр төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулахаар хуулийн төсөлд тодорхой заасан. Мөн төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах шийдвэр, түүний агуулга, өмчийг ашиглуулах гэрээ байгуулах журам, гэрээний нөхцөлийг тодорхой зааж, үл хөдлөх эд хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхийн үндсэн дээр бусдад ашиглуулах харилцааг нарийвчлан зохицууллаа.

Мөн төрийн болон орон нутгийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийтийн эрх ашгийг хангах зорилгоор зах зээлийн үнээр, эсхүл төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр, эсхүл хариу төлбөргүйгээр, ингэхдээ тухайн өмчийн хөрөнгө өмчийн эзэмшигчид хэрэгцээгүй, шаардлагагүй болсон, компанид мөнгөн бус хэлбэрээр

хувь нийлүүлэх болсон, хуульд заасан бусад үндэслэлээр бусдад шилжүүлэхээр тусгалаа. Энэ хүрээнд төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчийг шилжүүлэн авах хүсэлт гаргасан, эсхүл орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэн авах хүсэлт гаргасан зэрэг тохиолдолд тухайн хөрөнгийг төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр, эсхүл хариу төлбөргүй шилжүүлж болохоор зохицуулсан. Мөн төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх шийдвэр, түүний агуулга, өмчийг шилжүүлэх гэрээ байгуулах журам, гэрээний нөхцөлийг тодорхой зааж, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг солих, барьцаалуулах, балансаас баланс хооронд шилжүүлэх, орон нутгийн өмчийг төрийн өмчид шилжүүлэх, өмч шилжүүлсний дараах хяналттай холбоотой харилцааг нарийвчлан зохицууллаа.

-Хуулийн төслийн Тавдугаар бүлэгт төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах, шилжүүлэх арга, журамтай холбоотой харилцааг зохицуулахаар тусгасан. Төрийн болон орон нутгийн өмчийг бусдад ашиглуулах, шилжүүлэхдээ дуудлага худалдаа, эсхүл уралдаант шалгаруулалт зохион байгуулах, эсхүл гэрээ шууд байгуулах гэсэн гурван төрлийг аргыг хэрэглэхээр хуульчилсан. Мөн төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэхдээ тэргүүн ээлжид дуудлага худалдааны аргыг хэрэглэх бөгөөд тусгай болзол, нөхцөл заах шаардлагатай бол уралдаант шалгаруулалтын аргыг хэрэглэхээр, дуудлага худалдааг зөвхөн нээлттэй дуудлага худалдааны хэлбэрээр явуулахаар тодорхой заасан.

Түүнчлэн, дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах, доод үнэ болон хураамж, дэнчин тогтоох, үр дүнг батлах, ялагчийг шалгаруулах, гэрээ байгуулахтай холбоотой зохицуулалтыг нарийвчилж, дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалт зохион байгуулах журмыг Төрийн өмчийн хороо батлахаар тусгасан.

Гэрээ шууд байгуулах аргыг төрийн болон орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компанид өмчийг шилжүүлэх, ашиглуулах, хуульд заасны дагуу дуудлага худалдааг дахин зарласан, эсхүл уралдаант шалгаруулалтын тусгай болзол, шаардлага болон нэмэлт нөхцөлийг бууруулж, дахин зарласан боловч ялагч тодроогүй зэрэг тохиолдолд хэрэглэхээр зааж, гэрээ шууд байгуулах зарлалыг нийтлэх, сонирхогч этгээдтэй хэлэлцээ хийх, хамгийн сайн үнийн саналыг үндэслэн гэрээ байгуулах шийдвэр гаргахтай холбоотой зохицуулалтыг нэмж тусгалаа.

-Хуулийн төслийн Зургадугаар бүлэгт төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого, тайлантай холбоотой зохицуулалтыг нэгтгэн оруулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлийг төрийн нийтийн өмчийн бүртгэл, төрийн тусгайлсан өмчийн бүртгэл, орон нутгийн өмчийн бүртгэлээс тус тус бүрдэхээр зааж, төрийн нийтийн болон тусгайлсан өмчийн анхан шатны бүртгэлийг тухайн салбарыг хариуцсан төрийн байгууллага, өмчийн эзэмшигч, нэгтгэсэн бүртгэлийг Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн анхан шатны бүртгэлийг өмчийн эзэмшигч, нэгтгэсэн бүртгэлийг Орон нутгийн өмчийн газар хөтөлнө тус тус хариуцан хөтлөхөөр зохицуулсан. Түүнчлэн, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө, түүнийг бусдад ашиглуулах, шилжүүлэх болон холбогдох гэрээ хэлцэлд хяналт тавих, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор үл хөдлөх эд хөрөнгийн дагнасан бүртгэлийг хөтлөх, уг бүртгэлд тусгах

мэдээлэл, бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой асуудлыг нарийвчлан зохицууллаа.

Төрийн болог орон нутгийн өмчийн бүртгэл, тооллогын хувьд 2015 оны тооллогоор нийт 30 их наяд, 74 тэрбум, 984.7 сая төгрөгийн хөрөнгө тоологдсон нь өмнөх буюу 2011 оны тооллогын дүнгээс 15 их наяд, 614 тэрбум, 300 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байсан бол 2022 оны тооллогоор нийт 91.7 их наяд төгрөгийн хөрөнгө 6614 нэгж байгууллагад тоологдсон нь 2015 оны тооллогын дүнгээс 61.7 их наяд төгрөгөөр буюу 67 орчим хувиар нэмэгдсэн байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой толгой 99 компани, үйлдвэрийн газар нь 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 23 их наяд 617 тэрбум төгрөгийн орлого, 16 их наяд 912 тэрбум төгрөгийн зардал, 4 их наяд 983 тэрбум төгрөг буюу 21.1%-ийн цэвэр ашиг, 64 их наяд 200 тэрбум төгрөгийн нийт хөрөнгө, 7.76%-ийн хөрөнгийн өгөөжтэй ажилласан байна. Мөн төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийн орлогоор улсын төсөвт 2019 онд 155.2 тэрбум, 2020 онд 173.6 тэрбум, 2021 онд 207.2 тэрбум, 2022 онд 469 тэрбум, 2023 онд 449.8 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.⁵

Ийнхүү төр болон орон нутаг нь улсын төсвөөс гадуур их хэмжээний хөрөнгийг өмчилж байгаа боловч өмчийг зохистой удирдах, үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлд эрх зүйн зохицуулалт хангалтгүй хэвээр байна.

Иймд төрийн болон орон нутгийн өмчийн тооллогыг тухайн өмчийн бүртгэл дээр үндэслэн явуулах зарчмыг хуульчилж, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн тооллогыг төрийн нийтийн өмчийн нэгдсэн тооллого, төрийн тусгайлсан өмчийн нэгдсэн тооллого, орон нутгийн өмчийн нэгдсэн тооллого гэсэн хэлбэрээр зохион байгуулахаар тусгасан. Ингэхдээ төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн, төрийн тусгайлсан өмчийн нэгдсэн тооллогыг дөрвөн жил тутам Төрийн өмчийн хороо, холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран, орон нутгийн өмчийн нэгдсэн тооллогыг хоёр жил тутам Засаг даргын шийдвэрийн дагуу Орон нутгийн өмчийн газар тус тус зохион байгуулна. Түүнчлэн, төрийн болон орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын өмчийн тооллого, төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасны тооллого хийх, тооллогын комисс байгуулах, түүний эрх, үүргийг тогтоохтой холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө бүрийн үнэлгээг бүртгэлд тусгасан байхаар зааж, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч болон эзэмшигч нь хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэх, компани, санд хувь нийлүүлэх, хөрөнгө оруулах, төрийн өмчийн компанийн хувьцааг нийтэд санал болгох, хохирол арилгуулах, нэхэмжлэх, авлагад тооцож хөрөнгө хүлээн авах, өглөгөд тооцож хөрөнгө шилжүүлэх, хөрөнгө барьцаалуулах, эсхүл солилцох зэрэг тохиолдолд Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7.2-т заасан журам, аргачлалыг баримтлан тухайн хөрөнгөнд үнэлгээ хийх үүргийг хүлээлгэсэн.

Мөн төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэхээс өмнө төрийн болон орон нутгийн хэрэгцээнд шаардлагатай эсэхийг тодорхойлох зорилгоор магадлах ажиллагаа хийх шинэлэг зохицуулалтыг нэмж тусгасан бөгөөд магадлах ажиллагаа хийх журмыг Төрийн

⁵ “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, 2024 он.

өмчийн хороо батлахаар зохицуулсан. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашиглах боломжгүй болсонд тооцох үндэслэл, ашиглах боломжгүй хөрөнгийг данс, бүртгэлээс хасах журмыг нарийвчлан тусгалаа.

Төрийн болон орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага нь өмчийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгийн удирдлагын стратегийг тодорхойлсон өмчийн ашиглалтын менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг гарган Засгийн газар, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх, тайланг ил тод, нээлттэй байршуулах асуудлыг зохицуулсан.

-Хуулийн төслийн Долдугаар бүлгээр төрийн болон орон нутгийн өмчийн хяналттай холбоотой харилцааг зохицуулах бөгөөд төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт нь өмчлөгчийн хяналт, төрийн хяналт болон өмчийн эзэмшигчийн дотоодын хяналтаас тус тус бүрдэхээр заасан.

Тодруулбал, төрийн өмчийн өмчлөгчийн хяналтыг Улсын Их Хурал, Засгийн газар, орон нутгийн өмчийн өмчлөгчийн хяналтыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, төрийн хяналтыг хуульд заасан журмын дагуу Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газар, төрийн аудитын байгууллага болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, дотоодын хяналтыг өмчийн эзэмшигч тус тус хэрэгжүүлнэ.

Энэ хүрээнд өмчлөгчийн хяналтыг төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллогын дүн, тайлан, мэдээ, төрийн болон орон нутгийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын үр дүн, эд хөрөнгийн удирдлагын талаар гаргасан шийдвэр, гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулсан, дүгнэсэн байдалтай танилцаж, үүрэг чиглэл өгөх үүрэг чиглэл өгөх зэрэг хэлбэрээр, төрийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.1-д заасны дагуу тус тус хэрэгжүүлэх бөгөөд Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газрын улсын байцаагчийн бүрэн эрхийг хуульчилж, холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг зөрчсөн аливаа үйлдлийг таслан зогсоох, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах зэрэг арга хэмжээ авах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Харин дотоод хяналтыг төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигч нь өөрийн үйл ажиллагаанд хууль тогтоомжид заасан журмаар, эсхүл төрийн байгууллага, орон нутгийн нэгжийн удирдлага нь өөрийн харьяа байгууллага, хуулийн этгээдийн эд хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэхээр тусгаж, өмчийн эзэмшигчийн хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий байнгын ажиллагаатай, орон тооны бус Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг оруулсан.

-Хуулийн төслийн Наймдугаар бүлэгт төрийн болон орон нутгийн өмчийн цахим систем болон мэдээллийн сантай холбоотой асуудлыг зохицуулсан бөгөөд өмчийн цахим системд төрийн болон орон нутгийн өмчийн талаарх өгөгдөл, мэдээллийг цуглуулах, боловсруулах, хайлт хийх, илгээх, хүлээн авах, ашиглах болон аюулгүй байдлыг хангах зорилго бүхий программ хангамж, техник хангамж, мэдээллийн сан, бусад бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийн иж бүрдлийг ойлгохоор зааж, уг цахим системийн үйл ажиллагааг хариуцан хөтлөх, хөгжүүлэх, удирдлага зохион байгуулалтаар болон аюулгүй байдлыг хангах чиг үүргийг Төрийн өмчийн хороонд хариуцуулсан. Мөн өмчийн цахим системийн ашиглалтын болон мэдээллийн санг

хөтлөх, мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах, нууцлал, аюулгүй байдлыг хангах журмыг Засгийн газар батлахаар заасан.

Өмчийн мэдээллийн сангийн хувьд төрөлжсөн мэдээллийн санд хамаарах ба уг мэдээллийн санд төрийн болон орон нутгийн өмчийн ангилал, бүртгэл, тооллого, өмчийн эзэмшигч, өмчийн хөдөлгөөн, холбогдох хуульд заасан тайлан, дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалтад оруулах хөрөнгийн талаарх мэдээллийг төвлөрүүлнэ. Ингэхдээ өмчийн мэдээллийн санд мэдээллийг төрийн болон орон нутгийн өмчийн тайлан, өмчийн эзэмшигчид холбогдох хөрөнгийн мэдээлэл, бусдад ашиглуулах, шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл гэсэн төрлөөр ангилан тусгах бөгөөд ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмын хэрэгжилтийг хангах зорилгоор төрийн болон албаны нууцад хамаарах болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хаалттай болон хязгаарлалтайгаас бусад өмчийн мэдээллийн сангийн мэдээлэл нь олон нийтэд ил тод, нээлттэй байхаар хуульчилсан. Мөн Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газар, өмчийн эзэмшигч нь холбогдох бүртгэл, мэдээллийг өмчийн мэдээллийн санд тогтоосон хугацаанд бүрэн, үнэн зөв оруулах үүрэгтэй хэмээн зааж, өмчийн эзэмшигчийн үүргийн биелэлтэд хяналт тавих асуудлыг зохицуулсан.

-Хуулийн төслийн Есдүгээр бүлэгт гомдол хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, хууль хүчин төгөлдөр болохтой холбоотой зохицуулалтыг тусгалаа. Хуулийг дагаж мөрдөх шилжилтийн үеийн зохицуулалттай холбоотой харилцааг дагалдан гарах бие даасан хуулийн хүрээнд зохицуулахаар хуулийн төслийг боловсруулсан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, эрх зүйн хөгжилд чухал ач холбогдол бүхий бодлогын чанартай дараах үр дагавар бий болно гэж үзэж байна:

-Төрийн болон орон нутгийн өмчийн төрөл, хөрөнгийн ангилал, өмчлөх эрх болон өмчийн удирдлага хэрэгжүүлэх субъектын чиг үүрэг, үйл ажиллагааны үндэслэл, журам тодорхой болж, төрийн болон орон нутгийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, үр ашиг, үнэлгээг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

-Төрийн болон орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой хууль хоорондын хийдэл, зөрчил арилж, төрийн нийтийн өмчид хамаарах газар, байгалийн баялаг болон бусад өмчийн хөрөнгийн удирдлагын нэгдмэл тогтолцоо хангагдаж, Монгол Улсын Үндсэн хуулиар тодорхойлсон байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчим бодитой хэрэгжих суурь нөхцөл бүрдэнэ.

-Төрийн болон орон нутгийн өмчтэй холбоотой шийдвэр хариуцлагатай, ил тод, нээлттэй байх, төрийн үйлчилгээ түргэн шуурхай, хүнд суртлаас ангид байх зарчмын хэрэгжилт хангагдаж, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах болон үнэлэх, бүртгэх, бусад ашиглуулах, шилжүүлэх үйл ажиллагаа нийтийн эрх ашигт нийцсэн, үр ашигтай байх хууль зүйн үндэслэл бүрдэнэ.

-Өмчийн удирдлагын эрх мэдлийн хуваарилалтыг оновчилж, төрийн болон орон нутгийн өмчийн хөдөлгөөний шийдвэр гаргалтын процессыг хялбаршуулж, нэгдсэн хяналтын механизмыг бүрдүүлснээр өмчийн удирдлагын үр ашиг болон зардлын харьцаа сайжирна.

-Төрийн болон орон нутгийн өмчийн үр ашигтай байдлыг дээшлүүлж, хөрөнгийг бүрэн бүртгэж өмчлөх эрхийг баталгаажуулснаар төрийн өмч нэрийн дор хэн нэгэн эрх мэдэлтэн, албан тушаалтан хувьдаа шамшигдуулах, хууль бус үйлдэл гаргахаас сэргийлэх, улмаар төрд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлнэ.

---o0o---

НИЙТИЙН ӨМЧИЙН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж, Иргэний хуулийн 99 дүгээр зүйлийн 99.2 дахь хэсэгт “Нийтийн өмч нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй байна” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. ...Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно”, Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх,... эрхтэй.” гэсэн зарчмыг хуульчлан баталгаажуулсан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-т төрийн нийтийн өмчийн зохицуулалтыг тодорхой болгохоор зааж, тус хуваарийн 1.1.1-д “...стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны үр өгөөжийн дийлэнх нь буюу тавиас дээш хувь нь монголын ард түмэнд ногдох, шаардлагатай бол иргэдийн саналыг харгалзан Улсын Их Хурал хэлэлцэн байгалийн баялаг ард түмний мэдэлд, төрийн нийтийн өмч байх эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ энэхүү баялгийг төр өмчлөх...зарчмыг хуульчлах;”, 1.2.6-д “төрийн нийтийн өмчийг зохистой ашиглах, зарцуулахад тавих хяналтыг боловсронгуй болгох.”, 4.3.2-т “аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх,...эрх зүйн үндсийг бүрдүүлэх;”, 4.3.3-т “аймаг, нийслэл, сум, дүүргийн эрх зүйн байдал, өмчийн болон төсвийн харилцааг тусгайлсан хуулиар ялгамжтай зохицуулах,...” гэж тусгажээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтын 5.2.6-д “Бие даан хөгжих боломжийг бүрдүүлсэн орон нутгийн өмч, татварын боловсронгуй тогтолцоо бүхий эдийн засаг, санхүүгийн эрх мэдлийг орон нутагт шилжүүлнэ” гэж, 5.2.19-д “Төрийн компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна” гэж тус тус заасан байна.

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.4.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах

зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх, төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, үр өгөөж, хяналтыг сайжруулах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчилнэ.” гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.1.1-д “Төрийн болон орон нутгийн өмч, түүний ангилал, өмчийн удирдлага, төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх, бүртгэл, тооллого, тайлагналт, хяналт, ил тод байдалтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулах” хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэхээр тусгажээ.

Монгол Улс 1990 оноос зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбогдуулан 1996 онд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг анх баталсан бөгөөд уг хууль нь шилжилтийн үеийн төрийн болон орон нутгийн өмчийн талаарх төрийн байгууллагын эрх хэмжээг тогтоон, өмч хувьчлалыг зохицуулахад чиглэсэн байдаг. Гэтэл нийгэм, эдийн засгийн харилцаа хурдацтай өөрчлөгдөхийн хэрээр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зохицуулалт нь цаг үеийн нөхцөл байдалтай нийцэхгүй, нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцрох болжээ.¹

Тухайлбал, хууль батлагдсанаас хойш нийт 39 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд тэдгээрийн дийлэнх нь тус хуулийн зохицуулалттай холбоотой тулгарч байгаа бэрхшээлийг шийдвэрлэхэд бус харин салбарын бусад хууль шинэчлэгдсэн, эсхүл тэдгээрт нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой байна. Өөрөөр хэлбэл, хуулийн нийт зүйлийн 80 орчим хувьд өөрчлөлт орсон ч тэдгээр нь нэгдсэн бодлого, зарчмаар биш салангид байдлаар өөр, өөр зорилгын хүрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт байна.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойших өнгөрсөн 29 жилийн хугацаанд нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг дагаж өмчийн харилцаатай холбоотой эрх зүйн зохицуулалтын хүрээнд томоохон өөрчлөлтүүд гарсны дотор 2002 онд Иргэний хууль, Газрын тухай хууль батлагдаж, 2005, 2023 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 2011 онд Төсвийн тухай хууль, Компанийн тухай хууль, 2020 онд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдсэн зэрэг төрийн болон орон нутгийн үйл ажиллагаа, өмч болон бизнесийн харилцааг зохицуулсан хуулийн шинэчлэл томоохон байр суурийг эзэлнэ.

Ийнхүү Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зохицуулалтын хийдэлтэй болон эрх зүйн шинэчлэлээс хоцорсон, хуульд цаг үеийн шинжтэй, бусад салбарын хуулийн өөрчлөлттэй уялдуулсан нэмэлт, өөрчлөлтийг удаа дараа оруулсан зэрэг нь хуулийн зохицуулалтын нэгдмэл, цогц байдлыг алдагдуулахад хүргэжээ.

Иймд эрх зүйн шинэчлэл, бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилтын хүрээнд нийтийн өмч, түүний дотор төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх, хууль хоорондын давхардал, хийдлийг арилгах, төрийн болон орон нутгийн өмчийн ангилал, хэлбэрийг зохистой тогтоож, өмчийн удирдлага, бүртгэл, ашиглалт, хамгаалалт, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн

¹ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2025 он.

болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн нэрийг Иргэний хуульд заасан өмчийн төрөлд нийцүүлэн өргөжүүлж, нийтийн өмчийн суурь харилцааг зохицуулах хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12, 28 дугаар зүйлийн 28.5.2-т заасны дагуу “Нийтийн өмчийн хууль” гэж өөрчилж, нийтийн өмчийг удирдах зарчим, өмчийн зориулалт, ангилал болон өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх нийтлэг харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ. Ингэхдээ төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг тус хуулиар, харин олон нийтийн болон шашны өмчийн харилцааг уг хуульд нийцүүлэн тухайлсан хуулиар зохицуулахаар тусгалаа.

Энэ хүрээнд хуулийн зорилтыг “нийтийн өмч, түүний ангилал, өмчийн удирдлага, нийтийн өмчид хөрөнгө олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах, бүртгэл, тооллого, тайлагнал, хяналт, ил тод байдлыг хангахтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулах”-аар өргөжүүлэн тодорхойлсон.

Хуулийн төсөл нь 9 бүлэг, 81 зүйлтэй бөгөөд дараах зарчмын өөрчлөлтийг тусгалаа. Үүнд:

1.Нийтийн өмч, түүний дотор төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалт, хяналтын нэгдмэл байдлыг хангах зорилгоор хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэхийн зэрэгцээ хуулийн үйлчлэлд хамаарахгүй боловч тухайлсан хуулиар нарийвчлан зохицуулах харилцааг бусад хууль тогтоомж болон эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан тодорхойлсон;

2.Хуулийн нэр томъёог Монгол Улсын Үндсэн хууль болон Иргэний хуульд нийцүүлэн шинэчилж, төрийн болон орон нутгийн өмчийн харилцаанд баримтлах зарчимд өмчийн удирдлага нэгдмэл байх, өмчийн удирдлагыг хуулиар тогтоосон хязгаарлалтын хүрээнд хэрэгжүүлэх, тооцоо, судалгаанд үндэслэсэн, тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байх зэрэг тусгай зарчмыг шинээр тусгасан;

3.Төрийн болон орон нутгийн өмчийн ангиллыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн шинэчилж, төрийн өмчийн өмчлөгч нь Улсын Их Хурал, орон нутгийн өмчийн өмчлөгч нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал байх зарчмыг хэвээр хадгалж, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч этгээдүүдийн эрх хэмжээний давхцал, ойлгомжгүй байдлыг арилгаж, харилцан уялдаатай байхаар тусгасан. Мөн Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газрын хяналтын чиг үүргийг тодруулан хуульчилсан, түүнчлэн, Төрийн өмчийн хорооны бүрэлдэхүүнд хөрөнгийн удирдлага, хөрөнгийн үнэлгээ, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэшсэн иргэнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилж ажиллуулах боломжийг бүрдүүлээ;

4.Төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөгч, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, өмчийн эзэмшигч этгээдийн эрх зүйн байдлыг хөрөнгийн эрхийн байдалтай нь уялдуулан оновчилж тогтоосон. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн өмчийн удирдлага болон хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, гүйцэтгэх удирдлагыг томилох зэрэг асуудлыг төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай бие даасан хуулиар зохицуулахаар тусгасан;

5.Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэх асуудлыг үр ашигтай, нээлттэй, ил тод байдлаар хэрэгжүүлэх журам, аргыг нарийвчлан тусгасан. Энэ хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийтийн эрх ашгийг хангах зорилгоор өмчийг ашиглуулах, шилжүүлэх үндэслэл, зорилго, гэрээний нөхцөл, талуудын хүлээх эрх, үүргийг тодорхой хуульчилж, өмчийг бусдын өмчлөлд шилжүүлсний дараа хэрэгжүүлэх хяналтын зохицуулалтыг шинээр тусгасан;

6.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн нэгдмэл тогтолцоо, түүний бүрдэл хэсгийг тодорхойлж, хөрөнгө бүртгэх, тоолох, үнэлэх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан. Төрийн нийтийн өмчийн нэгдсэн бүртгэл, тооллого, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн дагнасан бүртгэлийг хийх, хөрөнгийн өөрчлөлт, хөдөлгөөн, хөрөнгө эзэмшигчийн мэдээллийг нээлттэй байлгах хууль зүйн үндэслэлийг бүрдүүлсэн;

7.Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалтын хяналт шалгалт, сахилга, хариуцлагын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлж, өмчлөгч болон төрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг нарийвчлан зохицуулж, Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн газраас хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндэслэл, журмыг тодорхойлсон;

8.Төрийн болон орон нутгийн өмчийг удирдах үйл ажиллагааны ил тод байдал болон олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор өмчийн бүртгэл, тайлагналттай холбоотой журмыг шинэчилж, өмчийн бүртгэл, хөдөлгөөн, өмчийн ашиглалтын менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл, хяналт шалгалтын талаарх мэдээллийг тусгасан төлөв байдлын тайланг гаргаж, Улсын Их Хурал, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах, тайланг олон нийтэд нээлттэй байршуулах талаар нарийвчлан тусгасан;

9.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого, үнэлгээ, өмчийн хөдөлгөөн, тайлан, хяналт шалгалттай холбоотой мэдээллийг төвлөрүүлсэн цахим систем, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, эрхлэн хөтлөх, хөгжүүлэх, мэдээллийг баталгаажуулах болон хадгалалт, хамгаалалтыг хэрэгжүүлэх журмыг тодорхой хуульчилсан.

Хууль батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчийн төрөл, хөрөнгийн ангилал, өмчлөх эрх болон өмчийн удирдлага хэрэгжүүлэх субъектын чиг үүрэг, үйл ажиллагааны үндэслэл, журам тодорхой болж, төрийн болон орон нутгийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, үр ашиг, үнэлгээг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Мөн төрийн болон орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой хууль хоорондын хийдэл, зөрчил арилж, төрийн нийтийн өмчид хамаарах газар, байгалийн баялаг болон бусад өмчийн хөрөнгийн удирдлагын нэгдмэл тогтолцоо хангагдаж, Монгол Улсын Үндсэн хуулиар тодорхойлсон байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчим бодитой хэрэгжих суурь нөхцөл бүрдэнэ.

Төрийн болон орон нутгийн өмчтэй холбоотой шийдвэр хариуцлагатай, ил тод, нээлттэй байх, төрийн үйлчилгээ түргэн шуурхай, хүнд суртлаас ангид байх зарчмын хэрэгжилт хангагдаж, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг эдийн

засгийн эргэлтэд оруулах болон үнэлэх, бүртгэх, бусад ашиглуулах, шилжүүлэх үйл ажиллагаа нийтийн эрх ашигт нийцсэн, үр ашигтай байх хууль зүйн үндэслэл бүрдэнэ.

Өмчийн удирдлагын эрх мэдлийн хуваарилалтыг оновчилж, төрийн болон орон нутгийн өмчийн хөдөлгөөний шийдвэр гаргалтын процессыг хялбаршуулж, нэгдсэн хяналтын механизмыг бүрдүүлснээр өмчийн удирдлагын үр ашиг болон зардлын харьцаа сайжирна.

Түүнчлэн, төрийн болон орон нутгийн өмчийн үр ашигтай байдлыг дээшлүүлж, хөрөнгийг бүрэн бүртгэж өмчлөх эрхийг баталгаажуулснаар төрийн өмч нэрийн дор хэн нэгэн эрх мэдэлтэн, албан тушаалтан хувьдаа шамшигдуулах, хууль бус үйлдэл гаргахаас сэргийлэх, улмаар төрд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Хуулийн төслийг дагалдуулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 25.2-т заасны дагуу 1996 оны 05 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл;

Түүнчлэн, Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигч этгээдийн ангиллын шинэчлэлд нийцүүлэн хуулийн этгээдийг татан буулгах, өөрчлөн байгуулах зэрэг арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд, хугацааг тогтоосон шилжилтийн үеийн зохицуулалт бүхий Нийтийн өмчийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл;

Мөн хуулийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан, түүнчлэн хуульд заасан нэр томъёог жигдлэх, зохицуулалт хоорондын уялдааг хангах зорилгоор Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Музейн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулалт тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.2-т заасны дагуу хуулийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын <https://cabinet.gov.mn/> цахим хуудсанд нээлттэй байршуулж, иргэд, олон нийтээс санал авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд бичгээр болон цахимаар санал ирээгүй болно.

Мөн хуулийн 38.6.2-т заасны дагуу Нийтийн өмчийн хуулийн төслийн танхимын хэлэлцүүлгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хамтран 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны 702 тоот Хурлын танхимд зохион байгуулсан.

Хэлэлцүүлэгт аймаг, нийслэлийн өмчийн харилцааны газрын удирдлага, зарим төрийн өмчит компанийн захирал болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид, судлаач, иргэдийн төлөөлөл бүхий 80 гаруй хүн оролцсон бөгөөд оролцогчдын зүгээс одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хэрэгжилттэй холбоотой практикт тулгамдаж байгаа асуудлуудыг дурдаж, орон нутгийн өмчийн харилцааны зохицуулалтыг тодорхой хуульчлах, өмчтэй холбоотой шийдвэр гаргалтыг хариуцлагатай, ил тод, нээлттэй болгох, төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүнд суртлаас ангид байлгах зэрэг саналуудыг дэвшүүлсэн бөгөөд эдгээр саналыг хуулийн төсөлд тусган боловсруулалтыг сайжруулахад анхаарч ажилласан болно.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙТИЙН ӨМЧИЙН ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь нийтийн өмч, түүний ангилал, өмчийн удирдлага, нийтийн өмчид хөрөнгө олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах, бүртгэл, тооллого, тайлагнал, хяналт, ил тод байдлыг хангахтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Нийтийн өмчийн хууль тогтоомж

2.1.Нийтийн өмчийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар нийтийн өмчийг удирдахтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулна.

3.2.Нийтийн өмчийг удирдахтай холбоотой дараах харилцааг энэ хуульд нийцүүлэн тухайлсан хуулиар зохицуулна:

3.2.1.олон нийтийн болон шашны өмчийн харилцаа;

3.2.2.улсын болон орон нутгийн төсөв, Үндэсний баялгийн сан, Эрдэнэсийн сан, Засгийн газрын тусгай сан болон орон нутгийн тусгай сан, улсын болон орон нутгийн нөөц хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт, түүнийг захиран зарцуулах, тайлагнах, хяналт тавих;

3.2.3.энэ хуулиар зохицуулснаас бусад төрийн болон орон нутгийн өмчит компанитай холбоотой харилцаа;

3.2.4.төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигчээс үүсгэн байгуулсан ашгийн төлөө бус сантай холбоотой харилцаа;

3.2.5.энэ хуулиар зохицуулснаас бусад газартай холбоотой харилцаа;

¹ Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Иргэний хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

3.2.6.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэх;

3.2.7.энэ хуулийн 8.1.1, 8.1.2, 8.1.3, 8.1.4, 8.1.5, 8.1.7, 8.1.8, 8.1.9, 8.1.10-т заасан өмчийн бүртгэл, тооллогыг зохион байгуулах, өмчийг ашиглуулах болон энэ хуулийн 8.1.6-д заасан агаарыг хамгаалах, агаарын орон зайг ашиглуулах, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэх;

3.2.8.соёлын биет өвийг бүртгэх, үнэлгээ тогтоох, тооллого хийх, түрээслэх, солилцох, шилжүүлэх болон түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэх;

3.2.9.төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх, түншлэлийн төлбөрийг санхүүжүүлэх болон дэмжлэг үзүүлэх;

3.2.10.Монгол Улсын Төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцоор далай ашиглах;

3.2.11.хууль болон гэрээний дагуу төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, ашгийн төлөө бус хуулийн этгээд болон хуулиар тусгайлан эрх олгосон этгээдээр гүйцэтгүүлэх;

3.2.12.Орон сууц хувьчлах тухай хуульд заасны дагуу төрийн өмчийн орон сууцыг иргэдэд хувьчлах.

3.3.Тухайлсан хуулиар тогтоох нийтийн өмчийг удирдахтай холбоотой зохицуулалт нь энэ хуульд заасан өмчийг удирдах зарчим, өмчийн зориулалт, ангилал болон өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх нийтлэг эрх хэмжээнд нийцсэн байна.

3.4.Тухайлсан хуулиар зохицуулаагүй энэ хуулийн 3.2-т заасан өмчийг удирдахтай холбоотой харилцаанд энэ хууль үйлчилнэ.

3.5.Төрийн нууцад хамаарах хөрөнгө олж авах, бүртгэх, үнэлэх, ашиглуулах журмыг Засгийн газар, түүнийг захиран зарцуулах, хяналт тавих журмыг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороо энэ хууль болон холбогдох хуульд нийцүүлэн тус тус батална.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“бусдад ашиглуулах” гэж Иргэний хууль, бусад хуульд заасан эд хөрөнгө хөлслөх, түрээслэх, эд хөрөнгийг үнэ төлбөргүй болон бусад гэрээ, эд юмсын хязгаарлагдмал эрхийн үндсэн дээр төрийн болон орон нутгийн өмчийг бусдын эзэмшил, ашиглалтад шилжүүлэхийг;

4.1.2.“бусдад шилжүүлэх” гэж Иргэний хууль, бусад хуульд заасан худалдах-худалдан авах, солилцох, бэлэглэх болон бусад гэрээний үндсэн дээр төрийн болон орон нутгийн өмчийг өмчлөх эрхийг шилжүүлэхийг;

4.1.3.“орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч” гэж Засаг дарга, түүнээс эрх шилжүүлэн авсан орон нутгийн өмчийн асуудал хариуцсан газрыг;

4.1.4.“орон нутгийн өмчийн эзэмшигч” гэж орон нутгийн өмчийг эзэмшиж байгаа орон нутгийн байгууллага, орон нутгийн нийтийн үйлчилгээний байгууллага, орон нутгийн өмчит компанийг;

4.1.5.“өмчийн удирдлага” гэж төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөгч, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, өмчийн эзэмшигчээс өмчийг бусдад ашиглуулах, шилжүүлэх үйл ажиллагааг;

4.1.6.“төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч” гэж Засгийн газар, төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг;

4.1.7.“төрийн өмчийн эзэмшигч” гэж төрийн өмчийг эзэмшиж байгаа төрийн байгууллага, төрийн нийтийн үйлчилгээний байгууллага, төрийн өмчит компанийг.

5 дугаар зүйл.Нийтийн өмчийг удирдах зарчим

5.1.Нийтийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмаас гадна дараах зарчмыг баримтална:

5.1.1.өмчийг удирдах төрийн бодлого нэгдмэл байх;

5.1.2.хуульд заасан зорилго, тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байх;

5.1.3.үр өгөөжийг ард түмэнд тэгш, шударга хүртээх;

5.1.4.тооцоо, судалгаанд үндэслэсэн, үр нөлөөтэй, үр ашигтай байх;

5.1.5.хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэх;

5.1.6.ил тод, нээлттэй, хариуцлагатай байх;

5.1.7.хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол эдийн болон эдийн бус хөрөнгийн салгаж үл болох бүрдэл хэсгийн өмчийн удирдлагыг нэг этгээд хэрэгжүүлэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ НИЙТИЙН ӨМЧИЙН ХЭЛБЭР, АНГИЛАЛ

6 дугаар зүйл.Нийтийн өмчийн хэлбэр, ангилал

6.1.Нийтийн өмч нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй байна.

6.2.Нийтийн өмч нь эдийн болон эдийн бус хөрөнгөөс бүрдэнэ.

6.3.Нийтийн өмчийн эд хөрөнгө нь үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө байна.

7 дугаар зүйл.Төрийн өмчийн ангилал

7.1.Төрийн өмч нь төрийн нийтийн болон төрийн тусгайлсан өмчөөс бүрдэнэ.

8 дугаар зүйл.Төрийн нийтийн өмч

8.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар ард түмний мэдэлд байхаар заасан дараах байгалийн баялаг, хөрөнгө нь төрийн нийтийн өмч байна:

- 8.1.1.Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар;
- 8.1.2.газрын хэвлий, түүний баялаг;
- 8.1.3.ой, түүний нөөц, дагалдах баялаг;
- 8.1.4.ус, түүний нөөц;
- 8.1.5.ургамал, ан амьтны нөөц;
- 8.1.6.агаар, агаарын орон зай;
- 8.1.7.Эрдэнэсийн сангийн хөрөнгө;
- 8.1.8.Үндэсний баялгийн сангийн хөрөнгө;
- 8.1.9.палеонтологи, археологийн олдвор;
- 8.1.10.төрийн архивын сан хөмрөг;
- 8.1.11.стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас;
- 8.1.12.нийтийн өмчийн соёлын биет өв;
- 8.1.13.нийтийн зориулалтаар ашиглахаар хуульд заасан бусад.

8.2.Төрийн нийтийн өмч нь төрийн хяналт, хамгаалалтад байна.

8.3.Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн нь бусдад эзэмшүүлж, өмчлүүлж, ашиглуулснаас бусад газарт, ой, усны сан бүхий газарт чөлөөтэй нэвтрэх, энэ хуулийн 8.1.3, 8.1.4, 8.1.5, 8.1.6-д заасан төрийн нийтийн өмчийг хуульд заасны дагуу ахуйн болон гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар ашиглах эрхтэй.

8.4.Энэ хуулийн 8.1.1-д заасан төрийн нийтийн өмчийн газрыг эзэмшиж байгаа төрийн болон орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага нь бусад этгээдэд эрхийн зүйлийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь шилжүүлэх, барьцаалуулахыг хориглоно.

8.5.Энэ хуулийн 8.1.1-д заасан төрийн нийтийн өмчийн газрыг эзэмшиж байгаа төрийн болон орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компани нь өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь бусдад ашиглуулах, эрхийг зориулалтын бусаар ашиглахыг хориглоно.

8.6.Төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшилд байгаа энэ хуулийн 8.1.1-д заасан төрийн нийтийн өмчийн газрыг бусад төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшилд шилжүүлэхэд энэ хуулийн 45.1-д заасан журмыг баримтална.

8.7.Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газрыг Газрын тухай хуульд заасан болзол, журмын дагуу иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулна.

9 дүгээр зүйл.Төрийн тусгайлсан өмч

9.1.Төрийн тусгайлсан өмчид дараах хөрөнгө хамаарна:

9.1.1.төрийн байгууллага, төрийн нийтийн үйлчилгээний байгууллагын хөрөнгө;

9.1.2.улсын төсвийн хөрөнгө;

9.1.3.Засгийн газрын тусгай сангийн хөрөнгө;

9.1.4.улсын нөөц;

9.1.5.төрийн өмчийн хөрөнгөөр бүтээсэн, олж авсан оюуны өмч, эрх;

9.1.6.төрийн үйл ажиллагаанд хамаарах хуульд заасан бүртгэл, мэдээллийн сан;

9.1.7.энэ хуулийн 8.1.11-д зааснаас бусад төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас.

10 дугаар зүйл.Орон нутгийн өмч

10.1.Орон нутгийн өмч нь аймаг, сум, нийслэл, дүүргийн өмчөөс бүрдэнэ.

10.2.Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуульд заасан дараах чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор өмчтэй байна:

10.2.1.аймаг нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21.1.10, 21.1.11, 21.1.12, 21.1.14, 21.1.15, 21.1.16-д заасан чиг үүрэг;

10.2.2.нийслэл нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24.1.10, 24.1.11, 24.1.12, 24.1.13, 24.1.14, 24.1.15, 24.1.16, 24.1.17, 24.1.18, 24.1.19, 24.1.21, 24.1.22 дахь хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8.2.3, 8.2.4, 8.2.5, 8.2.7, 8.3.6, 8.3.7, 8.3.8, 8.3.10, 8.3.13, 8.3.15, 8.3.16-д заасан чиг үүрэг;

10.2.3.сум нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22.1.8, 22.1.10, 22.1.11, 22.1.12, 22.1.13, 22.1.15, 22.1.16, 22.1.17, 22.1.18, 22.1.19, 22.1.20, 22.1.21-д заасан чиг үүрэг;

10.2.4.дүүрэг нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25.1.8, 25.1.9, 25.1.10, 25.1.11, 25.1.12, 25.1.13, 25.1.14-т заасан чиг үүрэг.

10.3.Энэ хуулийн 10.2-т зааснаас бусад чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутаг өмчтэй байх, эсхүл орон нутгийн нийтийн үйлчилгээний байгууллага, орон нутгийн өмчит компани байгуулахыг хориглоно.

10.4.Аймаг, нийслэлийн өмчид дараах хөрөнгө хамаарна:

10.4.1.аймаг, нийслэлийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын хөрөнгө;

10.4.2.аймаг, нийслэлийн төсөв;

10.4.3.аймаг, нийслэлийн өмчийн хөрөнгөөр байгуулсан нийтийн эзэмшлийн гудамж, талбай, хөшөө дурсгал, олон нийтийн соёл, амралтын хүрээлэн, ногоон байгууламж, авто зам, авто зогсоол болон цэвэр, бохир усны шугам, дулааны шугам, хог хаягдал болон хаягдал ус цэвэрлэх байгууламж, үерийн далан,

ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн байгууламж зэрэг нийтийн хэрэгцээнд зориулсан хөрөнгө;

10.4.4.аймаг, нийслэлийн соёлын биет өв;

10.4.5.аймаг, нийслэлийн тусгай сангийн хөрөнгө;

10.4.6.аймаг, нийслэлийн эзэмшлийн үнэт цаас;

10.4.7.аймаг, нийслэлийн нөөц;

10.4.8.аймаг, нийслэлийн өмчийн хөрөнгөөр бүтээсэн, олж авсан оюуны өмч, эрх.

10.5.Сум, дүүргийн өмчид дараах хөрөнгө хамаарна:

10.5.1.сум, дүүргийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын хөрөнгө;

10.5.2.сум, дүүргийн төсөв;

10.5.3.сум, дүүргийн өмчийн хөрөнгөөр байгуулсан нийтийн эзэмшлийн гудамж, талбай, хөшөө дурсгал, олон нийтийн соёл, амралтын хүрээлэн, ногоон байгууламж, авто зам, авто зогсоол болон төвлөрсөн бус ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн байгууламж зэрэг нийтийн хэрэгцээнд зориулсан хөрөнгө;

10.5.4.сум, дүүргийн тусгай сангийн хөрөнгө;

10.5.5.сум, дүүргийн эзэмшлийн үнэт цаас;

10.5.6.сум, дүүргийн нөөц;

10.5.7.сум, дүүргийн өмчийн хөрөнгөөр бүтээсэн, олж авсан оюуны өмч, эрх.

10.6.Хот, тосгон нь Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор өмчтэй байна.

10.7.Хот, тосгоны өмчийн харилцаанд энэ хуульд заасан орон нутгийн өмчийн зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.

10.8.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 68, 69 дүгээр зүйлд заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэхтэй холбогдуулан тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төрийн болон орон нутгийн өмчийг хот, тосгонд шилжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

11 дүгээр зүйл.Өмчийн удирдлага

11.1.Улсын Их Хурал нь Монгол Улсын ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байна.

11.2.Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдсэн бодлогыг Улсын Их Хурал тодорхойлж, Засгийн газар хэрэгжүүлнэ.

11.3.Улсын Их Хурал нь төрийн болон орон нутгийн өмчийн талаар дараах бүрэн эрхтэй байна:

11.3.1.төрийн өмчид хөрөнгө олж авах;

11.3.2.төрийн өмчийн өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлэх;

11.3.3.бусдын өмчлөлд шилжүүлж үл болох төрийн тусгайлсан өмчийн жагсаалт батлах;

11.3.4.төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө, эд юмсын хязгаарлагдмал эрхийг орон нутгийн өмчид шилжүүлэх;

11.3.5.нийтийн эрх ашиг, нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн орон нутгийн өмчийг төрийн өмчид шилжүүлэн авах талаар Засгийн газрын саналыг хэлэлцэж, шийдвэрлэх;

11.3.6.төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэлийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр хэлэлцэж, батлах;

11.3.7.стратегийн ач холбогдол бүхий салбар дахь төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлэх, барьцаалуулах талаар Засгийн газрын саналыг хэлэлцэж, зөвшөөрөл олгох;

11.3.8.төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн тооллогын дүн, төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг хэлэлцэж, Засгийн газарт үүрэг, чиглэл өгөх.

12 дугаар зүйл.Төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч

12.1.Засгийн газар нь хуульд заасан эрх хэмжээний хүрээнд төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлж, төрийн өмчийн үр нөлөөтэй, үр ашигтай байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.

12.2.Засгийн газар нь төрийн болон орон нутгийн өмчийн талаар дараах бүрэн эрхтэй байна:

12.2.1.төрийн болон орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

12.2.2.бусдын өмчлөлд шилжүүлж үл болох төрийн тусгайлсан өмчийн жагсаалт болон төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэлийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

12.2.3.төрийн тусгайлсан өмчид хөрөнгө олж авах;

12.2.4.Улсын Их Хурлын зөвшөөрлийг үндэслэн энэ хуулийн 11.3.7-д заасан асуудлаар шийдвэр гаргах;

12.2.5.хуульд заасан үндэслэлээр төрийн өмчийн компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах;

12.2.6.төрийн өмчийн оролцоотой компани үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл олгох;

12.2.7.төрийн тусгайлсан өмчийн хөдлөх болон эдийн бус хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх;

12.2.8.улсын тусгай хэрэгцээ, нийтийн эрх ашгийг үндэслэн газрыг нөхөн олговортойгоор солих, эргүүлэн авах болон хуульд заасны дагуу хураан авах;

12.2.9.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагыг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоох, дүрмийг батлах;

12.2.10.төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн тооллогыг зохион байгуулах шийдвэр гаргах, дүнг хэлэлцэх, тайланг Улсын Их Хуралд хүргүүлэх;

12.2.11.төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг хэлэлцэж, Улсын Их Хуралд хүргүүлэх.

12.3.Засгийн газар нь төрийн тусгайлсан өмчийг удирдахтай холбоотой дараах шийдвэрийг гаргана:

12.3.1.Улсын Их Хурал шийдвэрлэхээр хуульд зааснаас бусад төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлэх, барьцаалуулах;

12.3.2.төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшлийн үл хөдлөх эд хөрөнгө, түүнийг дагалдах хөрөнгө, үл хөдлөх эд хөрөнгөд үүссэн эд юмсын хязгаарлагдмал эрхийг бусдад шилжүүлэх, барьцаалуулах;

12.3.3.төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 500 дахин нэмэгдүүлснээс доошгүй хэмжээний нэг бүрийн балансын үнэ бүхий хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалуулах;

12.3.4.энэ хуулийн 11.3.4-т зааснаас бусад төрийн өмчийн үл хөдлөх ба түүний иж бүрдэл буюу цогцолбор хөдлөх эд хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалуулах;

12.3.5.төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг таваас арав хүртэлх жилийн хугацаагаар бусдад ашиглуулах;

12.3.6.төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхээр бусдад ашиглуулах;

12.3.7.гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагад төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах.

12.4.Засгийн газар нь энэ хуулийн 12.3.3, 12.3.5, 12.3.6-д заасан бүрэн эрхээ төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжүүлж болно.

13 дугаар зүйл.Төрийн өмчийн хороо, түүний чиг үүрэг

13.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж, Засгийн газрын бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий

төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага-Засгийн газрын тохируулагч агентлаг (цаашид “Төрийн өмчийн хороо” гэх) ажиллана.

13.2.Төрийн өмчийн хорооны дүрэм, бүтэц, орон тооны дээд хязгаарыг Засгийн газар батална.

13.3.Төрийн өмчийн хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааны шийдвэр нь тогтоол, тэмдэглэл хэлбэртэй байна.

13.4.Төрийн өмчийн хороо нь төрийн болон орон нутгийн өмчийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

13.4.1.Орон нутгийн өмчийн газрыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах асуудлаар үүрэг, чиглэл өгөх;

13.4.2.хуульд заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн тооллогыг зохион байгуулж, нэгдсэн дүнг Засгийн газарт тайлагнах;

13.4.3.төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг бэлтгэн Засгийн газарт тайлагнах;

13.4.4.төрийн болон орон нутгийн өмчийн цахим систем, мэдээллийн сангийн үйл ажиллагааг хариуцан эрхлэх;

13.4.5.төрийн нийтийн үйлчилгээний байгууллагын хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор төрийн өмчийн төлөөлөгчийг түр томилон ажиллуулах, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудлаар холбогдох байгууллагад санал хүргүүлэх;

13.4.6.төрийн өмчид хохирол учруулах эрсдэл бүхий үйлдэл, эс үйлдэхүйг таслан зогсоох талаар шаардлага гаргах, төрийн өмчид учруулсан хохирлыг барагдуулах, энэ чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах, шүүхэд нэхэмжлэл гаргах;

13.4.7.төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомжийн талаар сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулахад Төрийн албаны зөвлөл болон холбогдох бусад байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

13.4.8.төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан эрх зүйн актын хэрэгжилтэд хяналт тавих, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.

13.5.Төрийн өмчийн хороо нь энэ хуулийн 12.3-т зааснаас бусад төрийн тусгайлсан өмчийг удирдахтай холбоотой дараах шийдвэрийг гаргана:

13.5.1.төрийн байгууллага, төрийн нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшлийн хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалуулах зөвшөөрөл олгох;

13.5.2.төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг гурван сараас тав хүртэлх жилийн хугацаагаар бусдад ашиглуулах зөвшөөрөл олгох;

13.5.3.хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 500 дахин нэмэгдүүлснээс доошгүй хэмжээний нэг бүрийн балансын үнэ бүхий хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг бусдад ашиглуулах зөвшөөрөл олгох.

13.6.Төрийн өмчийн хороонд улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид "улсын байцаагч" гэх/ ажиллана.

13.7.Төрийн өмчийн хорооны дарга нь улсын ерөнхий байцаагчийн эрхтэй байх бөгөөд улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно. Улсын ерөнхий байцаагч нь улсын ахлах болон улсын байцаагчийн эрхийг олгоно.

13.8.Улсын байцаагч холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан эрх зүйн актын биелэлтэд хяналт тавьж, хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

14 дүгээр зүйл.Төрийн өмчийн хорооны дарга, гишүүнийг томилж, чөлөөлөх

14.1.Төрийн өмчийн хороо нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд дарга болон орон тооны бус 8 гишүүнтэй байна.

14.2.Төрийн өмчийн хорооны гишүүнийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас санал болгосноор Засгийн газар 4 жилийн хугацаагаар томилно.

14.3.Төрийн өмчийн хороонд төрийн захиргааны төв байгууллагыг төлөөлөх 5 гишүүн Төрийн албаны тухай хуулийн 23.2.1-д заасан шаардлагыг хангасан байна.

14.4.Төрийн өмчийн хорооны нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилогдох 3 гишүүн дараах шаардлагыг хангасан байна:

14.4.1.хөрөнгийн удирдлага, хөрөнгийн үнэлгээ, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэшсэн, тухайн чиглэлээр таваас доошгүй жил ажилласан туршлагатай, удирдан зохион байгуулах чадвартай;

14.4.2.эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэл, эрх зүй, бизнесийн удирдлагын дээд боловсролтой;

14.4.3.Эрүүгийн хуульд заасан эдийн засгийн, авлигын, өмчлөх эрхийн, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй байх.

14.5.Энэ хуулийн 14.4-т заасан гишүүн нь төрийн үйлчилгээний албан хаагч байж болно.

14.6.Засгийн газар дараах үндэслэлээр Төрийн өмчийн хорооны гишүүнийг чөлөөлнө:

14.6.1.бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;

14.6.2.эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

14.6.3.өөрөө чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;

14.6.4.энэ хуулийн 14.3, 14.4.3-т заасан шаардлагыг хангахгүй болсон.

14.7.Энэ хуулийн 14.4-т заасан нээлттэй сонгон шалгаруулалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар зохион байгуулна.

14.8.Төрийн өмчийн хорооны гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах журам, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, нэр дэвшигч тус бүрийн үнэлгээний оноо, нэр дэвшигчийн мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын цахим хуудаст нээлттэй, ил тод байршуулна.

14.9.Төрийн өмчийн хорооны даргад тавих шаардлага, бүрэн эрх, түүнийг томилж, чөлөөлөхтэй холбогдсон харилцааг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.

15 дугаар зүйл.Төрийн өмчийн эзэмшигч

15.1.Төрийн өмчийн эзэмшигч нь төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад төрийн өмчийг хууль тогтоомжид заасны дагуу захиран зарцуулна.

15.2.Төрийн өмчийн эзэмшигчийг дараах байдлаар ангилна:

15.2.1.төрийн байгууллага;

15.2.2.төрийн нийтийн үйлчилгээний байгууллага;

15.2.3.төрийн өмчит компани.

15.3.Энэ хуулийн 15.2.1-д заасан төрийн байгууллага гэдэгт төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг төв болон орон нутгийн бүх шатанд хэрэгжүүлэх зорилгоор хуульд заасны дагуу байгуулагдсан, төсвөөс санхүүждэг байгууллага, түүний үндсэн чиг үүргийг хариуцсан харьяа нэгжийг ойлгоно.

15.4.Төв Банк /Монголбанк/, Харилцаа холбооны зохицуулах хороо, Эрчим хүчний зохицуулах хороо болон түүнтэй адилтгах төрийн тухайлсан чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулсан, төсвөөс санхүүждэггүй, бие даасан хуулиар үйл ажиллагаа нь зохицуулагдаж байгаа нийтийн эрх зүйн бусад этгээдийг энэ хуулийн 15.2.1-д заасан төрийн байгууллагад хамааруулна.

15.5.Энэ хуулийн 15.2.2-т заасан төрийн нийтийн үйлчилгээний байгууллага гэдэгт төрийн чиг үүрэгт хамаарах боловсрол, эрүүл мэнд, соёл спорт, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүч зэрэг нийтийн үйлчилгээ үзүүлэх, төрийн байгууллагад чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой, хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийг ойлгоно.

15.6.Энэ хуулийн 15.2.3-т заасан төрийн өмчит компани гэдэгт Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн 4.1.1-д заасан хуулийн этгээдийг ойлгоно.

16 дугаар зүйл.Нийтийн үйлчилгээний байгууллага, түүний эд хөрөнгийн эрх

16.1.Төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах нийтийн үйлчилгээ болон төрийн болон орон нутгийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээг хувийн хэвшил, ашгийн төлөө бус хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх боломжгүй нөхцөлд нийтийн үйлчилгээний байгууллагыг байгуулна.

16.2.Нийтийн үйлчилгээний байгууллага нь төсвийн хөрөнгөөр санхүүжих бөгөөд эд хөрөнгийн талаар энэ хуулийн 15.3-т заасан төрийн байгууллагатай нэгэн адил эрхтэй.

16.3.Хуульд өөрөөр заагаагүй бол нийтийн үйлчилгээний байгууллагыг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоох, дүрмийг батлах эрх хэмжээг дараах этгээд хэрэгжүүлнэ:

16.3.1.төрийн нийтийн үйлчилгээний байгууллагыг Засгийн газар;

16.3.2.орон нутгийн нийтийн үйлчилгээний байгууллагыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал.

16.4.Засгийн газрын гишүүн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн нийтийн үйлчилгээний байгууллагын, аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн орон нутгийн нийтийн үйлчилгээний байгууллагын даргыг томилж, чөлөөлнө.

16.5.Дараах нийтийн үйлчилгээний байгууллагыг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, дүрмийг батлах болон бүтэц, зохион байгуулалт, хяналттай холбоотой харилцааг тухайлсан хуулиар зохицуулна:

16.5.1.Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг болон Улсын Их Хурлаас байгуулдаг байгууллагын харьяанд ажиллах нийтийн үйлчилгээний байгууллага;

16.5.2.боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх нийтийн үйлчилгээний байгууллага;

16.5.3.хуульд тусгайлан заасан бусад.

16.6.Нийтийн үйлчилгээний байгууллагын дарга нь Төрийн албаны тухай хуулийн 22.1-д заасан нийтлэг шаардлага болон холбогдох хууль, дүрэмд заасан тусгай шаардлагыг хангасан байна.

17 дугаар зүйл.Орон нутгийн өмчийн удирдлага

17.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн орон нутагт оршин суугаа иргэдийг төлөөлөн орон нутгийн өмчийн өмчлөгч байна.

17.2.Засаг дарга нь хуульд заасан эрх хэмжээний хүрээнд орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлж, орон нутгийн өмчийн үр нөлөөтэй, үр ашигтай байдлыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө хариуцна.

17.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь бусдын өмчлөлд шилжүүлж үл болох орон нутгийн өмчийн жагсаалтыг батална.

17.4.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн шатны орон нутгийн өмчийг удирдахтай холбоотой дараах шийдвэрийг гаргана:

17.4.1.орон нутгийн өмчит компанийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлэх, барьцаалуулах;

17.4.2.орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшлийн үл хөдлөх эд хөрөнгө, түүнийг дагалдах хөрөнгө, үл хөдлөх эд хөрөнгөд үүссэн эд юмсын хязгаарлагдмал эрхийг бусдад шилжүүлэх, барьцаалуулах;

17.4.3.үйлдвэр, аж ахуйг хэрэглэгдэхүүний хамт буюу цогцолбор эд хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалуулах;

17.4.4.аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчийн Хурал нь харьяа сум, дүүргийн өмчлөлд хөрөнгө шилжүүлэх.

18 дугаар зүйл.Орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч

18.1.Засаг дарга нь орон нутгийн өмчийг удирдахтай холбоотой дараах шийдвэрийг гаргана:

18.1.1.орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшилд байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300 дахин нэмэгдүүлснээс доошгүй хэмжээний нэг бүрийн балансын үнэ бүхий хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалуулах;

18.1.2.орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшлийн үл хөдлөх эд хөрөнгийг нэгээс гурав хүртэлх жилийн хугацаагаар бусдад ашиглуулах;

18.1.3.эд юмсын хязгаарлагдмал эрхээр үл хөдлөх эд хөрөнгийг бусдад ашиглуулах;

18.1.4.хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300 дахин нэмэгдүүлснээс доошгүй хэмжээний нэг бүрийн балансын үнэ бүхий хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг бусдад ашиглуулах.

18.2.Засаг дарга нь энэ хуулийн 18.1.1, 18.1.4-т заасан эрхээ Орон нутгийн өмчийн газарт шилжүүлж болно.

19 дүгээр зүйл.Орон нутгийн өмчийн газар, түүний чиг үүрэг

19.1.Орон нутагт төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж, орон нутгийн нэгжийн удирдлагын өмчийн талаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих чиг үүргийг Орон нутгийн өмчийн газар хэрэгжүүлнэ.

19.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь харьяа Орон нутгийн өмчийн газрын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоож, даргыг нь Төрийн өмчийн хороотой зөвшилцөн томилж, чөлөөлнө.

19.3.Орон нутгийн өмчийн газар нь дараах чиг үүрэгтэй:

19.3.1.харьяа орон нутагт төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр зөвлөмж, шаардлага хүргүүлэх;

19.3.2.иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас орон нутгийн өмчийн талаар гарах шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэх чиглэлд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, шийдвэрийн биелэлтийг хангуулах;

19.3.3.холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан эрх зүйн актын хэрэгжилтэд хяналт тавих, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

19.3.4.орон нутгийн өмчид хохирол учруулах эрсдэл бүхий үйлдэл, эс үйлдэхүйг таслан зогсоох шаардлага гаргах, учруулсан хохирлыг барагдуулах, энэ чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах, шүүхэд нэхэмжлэл гаргах.

19.4.Орон нутгийн өмчийн газарт улсын ерөнхий байцаагчаас эрх олгосон улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана.

19.5.Сум, дүүрэг энэ хуулийн 19.3.1, 19.3.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ажилтантай байна.

19.6.Орон нутгийн өмчийн газар нь энэ хуулийн 17.4, 18.1-д зааснаас бусад орон нутгийн өмчийг удирдахтай холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.6.1.орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшилд байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300 дахин нэмэгдүүлснээс доош хэмжээний нэг бүрийн балансын үнэ бүхий хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалуулах зөвшөөрөл олгох;

19.6.2.орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшлийн үл хөдлөх эд хөрөнгийг гурван сараас нэг хүртэлх жилийн хугацаагаар бусдад ашиглуулах зөвшөөрөл олгох;

19.6.3.энэ хуулийн 17.4, 18.1-д заасан асуудлаар дүгнэлт гаргах.

20 дугаар зүйл.Орон нутгийн өмчийн эзэмшигч

20.1.Орон нутгийн өмчийн эзэмшигч нь орон нутгийн өмчийн өмчлөгч, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгчийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад орон нутгийн өмчийн удирдлагыг хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.

20.2.Орон нутгийн өмчийн эзэмшигчийг дараах байдлаар ангилна:

20.2.1.орон нутгийн байгууллага;

20.2.2.орон нутгийн нийтийн үйлчилгээний байгууллага;

20.2.3.орон нутгийн өмчит компани.

20.3.Энэ хуулийн 20.2.1-д заасан орон нутгийн байгууллага гэдэгт нутгийн захиргааны чиг үүргийг орон нутгийн бүх шатанд хэрэгжүүлэх зорилгоор хуульд заасны дагуу байгуулагдсан, орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллага, түүний үндсэн чиг үүргийг хариуцсан харьяа захиргааны нэгжийг ойлгоно.

20.4.Энэ хуулийн 20.2.2-т заасан орон нутгийн нийтийн үйлчилгээний байгууллага гэдэгт орон нутгийн чиг үүрэгт хамаарах боловсрол, эрүүл мэнд, соёл, спорт, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүч зэрэг нийтийн үйлчилгээ үзүүлэх, орон

нутгийн байгууллагад чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой, хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийг ойлгоно.

20.5.Энэ хуулийн 20.2.3-т заасан орон нутгийн өмчит компани гэдэгт Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн 4.1.2-т заасан хуулийн этгээдийг ойлгоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ,
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙГ
БУСДАД АШИГЛУУЛАХ, ШИЛЖҮҮЛЭХ

НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД
ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ

21 дүгээр зүйл.Төрийн өмчид хөрөнгө олж авах

21.1.Төрийн өмчид дараах үндэслэлээр хөрөнгө олж авна:

21.1.1.эрх бүхий байгууллагын баталсан төсөв, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу худалдан авсан, эсхүл хөрөнгө зарцуулсны үр дүнд бий болсон хөрөнгө;

21.1.2.төрийн өмчийн хөрөнгийн ашиглалтаас бий болсон үр шим, ашиг, орлого;

21.1.3.төрийн үйлчилгээ, үйл ажиллагаанаас бий болсон орлого, эдийн болон эдийн бус баялаг;

21.1.4.шаардах эрх, хохирлын нөхөн төлбөр, даатгалын нөхөн олговорт авсан хөрөнгө;

21.1.5.хуульд заасны дагуу хандив, тусламж, бэлэглэл, өв, эрх залгамжлах журмаар олж авсан хөрөнгө;

21.1.6.эзэнгүй болон дарагдмал үнэт зүйл;

21.1.7.зээлээр авсан хөрөнгө;

21.1.8.сольж авсан хөрөнгө;

21.1.9.төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу шинээр бий болсон хөрөнгө;

21.1.10.орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэн хөрөнгө;

21.1.11.эргүүлэн авсан, сольж авсан газар;

21.1.12.хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан үндэслэл, журмын дагуу шилжүүлэн авсан, дайчлан авсан, хурааж улсын орлого болгосон, төрд учирсан хохирлын нөхөн төлбөрт төлүүлсэн хөрөнгө;

21.1.13.хөрөнгө оруулах замаар эзэмших үнэт цаас;

21.1.14.хуульд заасан бусад.

21.2.Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон эд хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.

21.3.Орон нутаг чиг үүргээ хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд гадаад улс, олон улсын байгууллагаас хандив, зээл, тусламж авахыг хориглоно.

21.4.Энэ хуулийн 21.1.12-т заасан үндэслэлээр олж авсан хөрөнгөөс төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага, албан тушаалтанд аливаа хэлбэрийн урамшуулал, тэтгэмж олгох, хувь хүртээх, эсхүл уг асуудлаар захиргааны шийдвэр гаргахыг хориглоно.

21.5.Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн эзэмшигчийг төсвийн ерөнхийлөн захирагчийн саналыг үндэслэн Төрийн өмчийн хороо тогтооно.

21.6.Дарагдмал үнэт зүйлс доторх түүх, соёлын дурсгалт зүйлийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Иргэний хуулийн 118.3-т заасны дагуу төрийн өмчлөлд шилжүүлэн авна.

21.7.Бусад этгээдтэй хамтарч бий болгосон хөрөнгийн хувьд тухайн оруулсан хөрөнгийн хэмжээгээр төрийн өмч гэж үзнэ.

22 дугаар зүйл.Орон нутгийн өмчид хөрөнгө олж авах

22.1.Орон нутгийн өмчид энэ хуулийн 21.1.1, 21.1.4, 21.1.5, 21.1.7, 21.1.8, 21.1.9, 21.1.11, 21.1.12, 21.1.13-т зааснаас гадна дараах үндэслэлээр хөрөнгө олж авна:

22.1.1.улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн өмчид зориулж бий болгосон хөрөнгө;

22.1.2.төрийн өмчөөс орон нутгийн өмчид, эсхүл орон нутаг хооронд шилжүүлсэн хөрөнгө;

22.1.3.орон нутгийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулж, үр шим, ашиг олсны үр дүнд бий болсон хөрөнгө;

22.1.4.орон нутгийн үйлчилгээ, үйл ажиллагааны орлогоор бий болсон хөрөнгө;

22.1.5.хуульд заасан бусад.

22.2.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон үл хөдлөх эд хөрөнгийн эзэмшигчийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хөдлөх эд хөрөнгийн эзэмшигчийг аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

23 дугаар зүйл.Хандив, тусламж, бэлэглэл, өв, эрх залгамжлалын журмаар хөрөнгө олж авах

23.1.Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигч нь Төсвийн тухай хууль, Иргэний хуульд³ заасны дагуу хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор хандив, тусламж, бэлэглэл болон өв, эрх залгамжлалын журмаар хөрөнгө олж авч болно.

23.2.Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигч нь бэлэг, хандив, тусламжаар хүлээн авсан хөрөнгөд үнэлгээ тогтоож, данс бүртгэлд тусгах үүрэгтэй.

23.3.Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсад бэлэглэсэн, хандивласан, тусламжаар олгосон эд хөрөнгийг үнэлэх, зориулалт, ашиглалтын нөхцөлийг харгалзан эзэмших этгээдийг Төрийн өмчийн хороо тогтооно.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан эд хөрөнгийг орон нутагт зориулан олгосон бол уг эд хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлнэ.

23.5.Дараах нөхцөлийн аль нэгийг хангаагүй тохиолдолд тухайн хөрөнгийг энэ хуулийн 23.1-д заасан журмаар хүлээн авахыг хориглоно:

23.5.1.хэрэгцээ, шаардлагагүй;

23.5.2.үр ашиггүй, нэмэлт зардал гарах;

23.5.3.хуульд нийцээгүй үүрэг хүлээлгэх нөхцөлтэй.

24 дүгээр зүйл.Улсын орлого болгох, эсхүл төрийн өмчид шилжүүлэх шийдвэрийн дагуу хураагдсан хөрөнгө олж авах

24.1.Хуульд заасны дагуу улсын орлого болгох, эсхүл төрийн өмчид шилжүүлэх шийдвэрийн дагуу хураагдсан хөрөнгийг Төрийн өмчийн хороо дуудлага худалдаагаар борлуулж, олсон орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ.

24.2.Хураагдсан хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах хүртэл хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хариуцах этгээдийг Төрийн өмчийн хороо тогтооно.

24.3.Хураагдсан хөрөнгийн дуудлага худалдаатай холбогдсон зардлыг тухайн дуудлага худалдаанаас олсон орлогоос гаргуулна.

24.4.Дуудлага худалдаагаар худалдагдаагүй хөрөнгийг Төрийн өмчийн хороо төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын хэрэгцээнд шаардлагатай эсэхийг энэ хуульд заасны дагуу тогтоож, тухайн байгууллагыг хөрөнгийн эзэмшигчээр бүртгэнэ.

24.5.Хураан авсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг дуудлага худалдаагаар худалдахгүй бөгөөд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Төрийн өмчийн хороо хөрөнгийн эзэмшигчийг тогтоож, бүртгэнэ.

24.6.Хөрөнгийн үнэлгээгээр тухайн хөрөнгийг ашиглах боломжгүй нь тогтоогдвол энэ хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ

³ Иргэний хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙГ БУСДАД АШИГЛУУЛАХ

25 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг бусдад ашиглуулах

25.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийтийн эрх ашгийг хангах зорилгоор гэрээний үндсэн дээр төлбөртэй, хөнгөлөлттэй нөхцөлөөр, хариу төлбөргүй, эсхүл эд юмсын хязгаарлагдмал эрхээр бусдад ашиглуулна.

25.2.Дараах үндэслэлээр төрийн болон орон нутгийн өмчийг бусдад ашиглуулж болно:

25.2.1.өмчийн эзэмшигчид тухайн хөрөнгө түр хугацаагаар хэрэгцээгүй болсон;

25.2.2.өмчийг нөөцлөх, хадгалах нөхцөлийг хангахгүй болсон;

25.2.3.илүү талбай, хэсэг гарсан.

25.3.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад ашиглуулах тохиолдолд Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газраас зөвшөөрөл авна.

25.4.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад ашиглуулахаас өмнө энэ хуулийн 68 дугаар зүйлд заасны дагуу магадлах ажиллагаа хийнэ.

25.5.Өмчийг дамжуулан ашиглуулах тохиолдолд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, эсхүл өмчийн эзэмшигчийн зөвшөөрлийг бичгээр авсан байна.

25.6.Өмчийг ашиглуулах гэрээ төр, орон нутагт хохиролтой байж болохгүй.

25.7.Төрийн болон орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага байрлан үйл ажиллагаа явуулж байгаа үл хөдлөх эд хөрөнгийг энэ хуулийн 25.2.3-т заасан үндэслэлээр тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд харшлахгүй хэлбэрээр бусдад ашиглуулж болно.

26 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр, эсхүл хариу төлбөргүйгээр ашиглуулах

26.1.Хуульд өөрөөр заагаагүй бол дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийг төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр бусдад ашиглуулж болно:

26.1.1.төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийг ашиглах хүсэлт гаргасан;

26.1.2.орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчийн болон орон нутгийн өмчийг ашиглах хүсэлт гаргасан;

26.1.3.орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага тухайн орон нутагт оршин суугаа иргэдэд нийгэм, соёлын үйлчилгээ хүргэх, нийтийн эрх ашгийг хангах зорилгоор төрийн өмчийг ашиглах хүсэлт гаргасан;

26.1.4.нийтийн эрх зүйн хуулийн этгээд хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийг ашиглах хүсэлт гаргасан;

26.1.5.онцгой байдал, боловсрол, эрүүл мэнд, соёл, урлаг, спортын зэрэг үйл ажиллагааг дэмжих нийгмийн үйлчилгээ, нийгмийн халамжийн чиглэлээр нийтийн эрх ашгийн төлөө байгуулагдсан ашгийн төлөө бус байгууллага үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийг ашиглах хүсэлт гаргасан;

26.1.6.олон улсын байгууллага, түүний Монгол Улс дахь салбар, төлөөлөгчийн газар улс орны нийтлэг эрх ашигт нийцсэн олон улсын төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд төрийн болон орон нутгийн өмчийг ашиглах хүсэлт гаргасан;

26.1.7.олон улсын байгууллага, түүний Монгол Улс дахь салбар, төлөөлөгчийн газар хүмүүнлэгийн зорилготой үйл ажиллагаа явуулахад төрийн болон орон нутгийн өмчийг ашиглах хүсэлт гаргасан.

26.2.Энэ хуулийн 26.1.1, 26.1.2, 26.1.3, 26.1.6-д заасан тохиолдолд хариу төлбөргүйгээр бусдад ашиглуулж болно.

26.3.Төрийн болон орон нутгийн өмчийг хоёр болон түүнээс дээш этгээд ашиглах хүсэлт гаргасан тохиолдолд илүү ашигтай нөхцөлийг санал болгосон этгээдэд ашиглуулна.

26.4.Төрийн болон орон нутгийн өмчийг хоёр болон түүнээс дээш этгээд хариу төлбөргүй ашиглах хүсэлт гаргасан тохиолдолд нийтийн эрх ашигт илүү хувь нэмэр оруулах үйл ажиллагаа явуулах этгээдэд ашиглуулна.

27 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах арга

27.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг энэ хуулийн 47.1-д заасан аргаар ашиглуулна.

27.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийг бусдад ашиглуулахдаа тэргүүн ээлжид дуудлага худалдааны аргыг хэрэглэх бөгөөд тусгай нөхцөл заах шаардлагатай бол уралдаант шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.

27.3.Энэ хуулийн 26.1, 26.2-т заасан үндэслэлээр төрийн болон орон нутгийн өмчийг төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр, эсхүл хариу төлбөргүй бусдад ашиглуулах бол гэрээ шууд байгуулна.

27.4.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах гэрээ байгуулах журам, гэрээний загварыг Төрийн өмчийн хороо батална.

28 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулсны төлбөр

28.1.Төрийн болон орон нутгийн өмчийг бусдад хариу төлбөртэй ашиглуулах бол төлбөрийг тухайн үеийн зах зээлийн үнээр тогтооно.

28.2.Төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах гэрээний төлбөрийн доод хэмжээг тухайн эд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай арчлалт, хадгалалт, хамгаалалтын зардал болон тухайн үеийн зах зээлийн үнийн 30 хувиас багагүй байхаар тогтооно.

28.3.Төрийн болон орон нутгийн хөрөнгийг ашиглуулах гэрээ байгуулах бол тухайн эд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай арчлалт, хадгалалт, хамгаалалт, элэгдэл, ашиглалтын болон нотариатын үйлчилгээний төлбөр зэрэг бусад зайлшгүй зардлыг ашиглагч хариуцна.

28.4.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн ашиглалтын төлбөрийн доод хэмжээ, түүнийг тогтоох аргачлалыг тухайн үл хөдлөх эд хөрөнгийн байршил, зориулалт, ашиглах этгээдийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлээс хамааруулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Төрийн өмчийн хороо тогтооно.

29 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг бусдад ашиглуулах шийдвэрийн агуулга

29.1.Төрийн болон орон нутгийн өмчлөгч, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, өмчийн эзэмшигч нь хуульд заасан эрх хэмжээний хүрээнд өмчийг бусдад ашиглуулах шийдвэрийг гаргана.

29.2.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах шийдвэр нь дараах агуулгатай байна:

29.2.1.ашиглуулах хөрөнгийн мэдээлэл;

29.2.2.хөрөнгө ашиглуулах хугацаа, ашиглалтад шилжүүлэх огноо;

29.2.3.ашиглалтад шилжүүлэх арга;

29.2.4.дуудлага худалдаа, эсхүл уралдаант шалгаруулалт зохион байгуулах этгээдийн талаарх мэдээлэл;

29.2.5.ашиглалтын төлбөрийг тогтоосон нөхцөл, үндэслэл;

29.2.6.ашиглалтын төлбөрт тохируулга хийх аргачлал;

29.2.7.гэрээ шууд байгуулах аргаар ашиглуулж байгаа бол ашиглагчийн нэр, иргэн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар.

30 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг бусдад ашиглуулах гэрээ

30.1.Энэ хуулийн 29.1-д заасан шийдвэрийг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах гэрээ байгуулна.

30.2.Өмчийг ашиглуулах гэрээг төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөгч, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, өмчийн эзэмшигч нь өмчийг ашиглагч талтай бичгээр байгуулж, Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газарт бүртгүүлнэ.

30.3.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглалтад шилжүүлсэн, хүлээн авсан талаарх баримтыг бичгээр үйлдэх бөгөөд тухайн баримтад хөрөнгийн гадаад, дотоод шинж байдал, тоо хэмжээ, шилжүүлэх үеийн үзүүлэлтийг тусгана.

30.4.Төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөгч, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, өмчийн эзэмшигч нь нь өмчийг ашиглуулах гэрээнд дараах нөхцөлийг тусгана:

30.4.1.гэрээний талуудын нэр, улсын бүртгэлийн дугаар, иргэн бол төрсөн он, сар, өдөр;

30.4.2.гэрээний зүйл, зориулалт;

30.4.3.гэрээний төлбөрийн хэмжээ, төлбөр төлөх хугацаа;

30.4.4.хөрөнгийг ашиглалтад шилжүүлэх нөхцөл, хугацаа;

30.4.5.гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах арга;

30.4.6.гэрээний нэмэлт нөхцөл;

30.4.7.гэрээ байгуулахтай холбоотой зардлыг хуваарилах журам.

30.5.Дараах тохиолдолд өмчийг ашиглуулах гэрээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулж болно:

30.5.1.төр, эсхүл орон нутагт хохирол, алдагдал учруулахгүй, нэмэлт үүрэг хүлээлгэхээргүй бол;

30.5.2.дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалт зохион байгуулах журмыг зөрчихөөргүй бол.

30.6.Төрийн өмчийг ашиглуулах гэрээний бүртгэлийг Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийг ашиглуулах гэрээний бүртгэлийг Орон нутгийн өмчийн газар хөтөлнө.

30.7.Дараах тохиолдолд өмчийг ашиглуулах гэрээг цуцлах, шилжүүлсэн өмчийг буцаан авах, буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэл болно:

30.7.1.эрх бүхий этгээдийн шийдвэр, зөвшөөрөлгүйгээр дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалтыг зохион байгуулсан, эсхүл ялагчид хууль бус давуу байдал үүсгэсэн;

30.7.2.энэ хуулийн 52.5.2, 52.5.4-т заасан нөхцөл илэрсэн;

30.7.3.гэрээнд зааснаас өөр зориулалтаар ашигласан, хохирол учруулсан;

30.7.4.өмчийг ашиглуулах доод үнээс бага үнээр худалдсан, ашиглуулахыг зөвшөөрөөгүй хөрөнгө оролцуулсан;

30.7.5.гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь зохих ёсоор биелүүлээгүй.

30.8.Энэ хуулийн 30.7-д заасан үндэслэлээр гэрээг цуцлах шийдвэрийг Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газар гаргана.

30.9.Төрийн өмчийг ашиглуулах үйл ажиллагаанд Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийг ашиглуулах үйл ажиллагаанд Орон нутгийн өмчийн газар хяналт тавина.

31 дүгээр зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхээр бусдад ашиглуулах

31.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхээр бусдад ашиглуулах бол энэ хуулийн 29.2-т заасан шийдвэрт эд юмсын хязгаарлагдмал эрхийн гэрээний нөхцөлийн талаарх мэдээллийг тусгана.

31.2.Үл хөдлөх эд хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхийн үндсэн дээр бусдад ашиглуулах шийдвэр гаргах эрхийг бусад этгээдэд шилжүүлж болохгүй.

31.3.Төрийн өмчийн газрыг эд юмсын хязгаарлагдмал эрхийн үндсэн дээр эзэмшиж байгаа өмчийн эзэмшигч нь бусад этгээдэд эрхийн зүйлийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь ашиглуулах, шилжүүлэх, эрхийн зүйлийг бусдад барьцаалуулах, эрхийг зориулалтын бусаар ашиглахыг хориглоно.

31.4.Төрийн өмчийн газарт нийтийн ба хувийн сервитут олгох тухай шийдвэрт сервитут хэрэгжих талбай, нэвтрэх болон зорчих хэсгийн зураглалыг, хөдлөх ба үл хөдлөх иж бүрдэл буюу цогцолбор эд хөрөнгийг узуфруктээр бусдад ашиглуулах бол узуфрукт олгох тухай шийдвэрт узуфруктын зүйлийн бүрдэл хэсгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргана.

31.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг узуфруктын үндсэн дээр бусдад ашиглуулах дээд хугацаа 60 жил байна. Узуфруктын хугацаа дуусгавар болохоос өмнө хуулийн этгээд татан буугдсан, хувь хүн нас барсан бол узуфрукт дуусгавар болно.

Тайлбар: Энэ зүйлд заасан бусад этгээд гэдэгт төрийн болон орон нутгийн өмчийн бус этгээдээс гадна уг эрхийг эзэмшдэггүй төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигч нэгэн адил хамаарна.

32 дугаар зүйл.Эд юмсын хязгаарлагдмал эрхийн гэрээ, төлбөр

32.1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхээр ашиглуулах гэрээ нь хууль болон эд юмсын хязгаарлагдмал эрх үүсгэх тухай энэ хуулийн 29.2-т заасан шийдвэрт нийцсэн байна.

32.2.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг эд юмсын хязгаарлагдмал эрхээр ашиглуулах гэрээнд хязгаарлагдмал эрхийн төрөл, агуулгыг тусгана.

32.3.Төрийн болон орон нутгийн өмчид үүсгэсэн эд юмсын хязгаарлагдмал эрхийн төлбөрийн хэмжээ, төлбөр төлөх журмыг энэ хуулийн 32.1-д заасан гэрээгээр тохирно.

32.4.Төрийн өмчийн газрыг хязгаарлагдмал эрхээр ашиглаж байгаа этгээдийн өмчийн хэлбэрээс үл хамааран уг эрхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэх бөгөөд ийнхүү бүртгүүлснээр эд юмсын хязгаарлагдмал эрх хүчин төгөлдөр болно.

32.5.Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь гэрээний хэрэгжилтийн явцад урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдал үүссэн, эсхүл эд юмсын хязгаарлагдмал эрх үүссэнээс хойш гурван жил тутамд уг эрхийн төлбөрийн хэмжээнд тохируулга хийхийг шаардах эрхтэй.

33 дугаар зүйл.Албаны орон сууцны арчлалт, хамгаалалт

33.1.Төрийн болон орон нутгийн өмчийн албаны зориулалттай орон сууцны арчлалт, хамгаалалтын зардлыг төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигч хариуцаж, ашиглалтын хэвийн байдлыг хангана.

33.2.Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигч нь албаны зориулалттай орон сууцны арчлалт, хамгаалалт, ашиглалтын хэвийн байдлыг хангах ажил үүргээ гэрээний үндсэн дээр бусдад шилжүүлж болно.

33.3.Төрийн өмчийн хороо энэ хуулийн 33.2-т заасан гэрээний загвар болон гэрээний үндсэн дээр ажил үүрэг гүйцэтгэх этгээдэд тавих шаардлагыг батална.

ГУРАВДУГААР ДЭД БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙГ БУСДАД ШИЛЖҮҮЛЭХ

34 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг бусдад шилжүүлэх

34.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийтийн эрх ашгийг хангах зорилгоор энэ хуульд заасан үндэслэлээр зах зээлийн үнээр, эсхүл төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр, эсхүл хариу төлбөргүйгээр бусдад шилжүүлнэ.

34.2.Төрийн болон орон нутгийн өмчийг бусдад шилжүүлэх шийдвэрийг өмчийн өмчлөгч, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, түүнээс эрх шилжүүлэн авсан этгээд, өмчийн эзэмшигч энэ хуульд заасан журмын дагуу гаргана.

34.3.Хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бусдад хандив, тусламж, дэмжлэг үзүүлэхийг хориглоно.

35 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг бусдад шилжүүлэх үндэслэл

35.1.Дараах үндэслэлээр төрийн болон орон нутгийн өмчийг бусдад шилжүүлж болно:

- 35.1.1.өмчийн эзэмшигчид хэрэгцээгүй, шаардлагагүй болсон;
- 35.1.2.компанид мөнгөн бус хэлбэрээр хувь нийлүүлэх болсон;
- 35.1.3.хуульд заасан бусад.

35.2.Энэ хуулийн 35.1.1-д заасан үндэслэлээр тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин нэмэгдүүлснээс доошгүй хэмжээний нэг бүрийн балансын үнэ бүхий хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг бусдад шилжүүлэхээс өмнө Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газраас дүгнэлт авсан байна.

35.3.Энэ хуулийн 35.1.1-д заасан үндэслэлээр төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад шилжүүлэхээс өмнө энэ хуулийн 68 дугаар зүйлд заасны дагуу магадлах ажиллагаа хийнэ.

36 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр, эсхүл хариу төлбөргүй шилжүүлэх

36.1.Дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийг төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр бусдад шилжүүлж болно:

36.1.1.төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчийг шилжүүлэн авах хүсэлт гаргасан;

36.1.2.орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэн авах хүсэлт гаргасан;

36.1.3.орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага тухайн орон нутагт оршин суугаа иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг хангах зорилгоор төрийн өмчийг шилжүүлэн авах хүсэлт гаргасан.

36.2.Төрийн болон орон нутгийн өмчийг энэ хуулийн 36.1.1, 36.1.2-т заасан тохиолдолд бусдад хариу төлбөргүй шилжүүлж болно.

36.3.Төрийн болон орон нутгийн өмчийг хоёр болон түүнээс дээш этгээд шилжүүлэн авах хүсэлт гаргасан тохиолдолд илүү ашигтай нөхцөлийг санал болгосон этгээдэд шилжүүлнэ.

36.4.Төрийн болон орон нутгийн өмчийг хоёр болон түүнээс дээш этгээд хариу төлбөргүй шилжүүлэн авах хүсэлт гаргасан тохиолдолд нийтийн эрх ашигт илүү хувь нэмэр оруулах үйл ажиллагааг явуулах этгээдэд шилжүүлнэ.

37 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг бусдад шилжүүлэх арга

37.1.Энэ хуулийн 47.1-д заасан аргаар төрийн болон орон нутгийн өмчийг бусдад шилжүүлнэ.

37.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэхдээ тэргүүн ээлжид дуудлага худалдааны аргыг хэрэглэх бөгөөд тусгай болзол, нөхцөл заах шаардлагатай бол уралдаант шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.

37.3.Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшлийн үнэт цаасыг бусдад шилжүүлэхдээ тухайн харилцааг зохицуулсан хуулийг тэргүүн ээлжид баримтална.

37.4.Энэ хуулийн 36.1.1, 36.1.2, 36.1.3-т заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийг бусдад шилжүүлэх тохиолдолд гэрээ шууд байгуулж болно.

37.5.Төрийн өмчийг шилжүүлэх ажиллагаанд Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийг шилжүүлэх үйл ажиллагаанд Орон нутгийн өмчийн газар хяналт тавина.

37.6.Төрийн болон орон нутгийн өмчийг бусдад шилжүүлэх гэрээ байгуулах журам, гэрээний загварыг Төрийн өмчийн хороо батална.

38 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлсний төлбөр

38.1.Төрийн болон орон нутгийн өмчийг бусдад хариу төлбөртэй шилжүүлэх бол төлбөрийг тухайн хөрөнгийн зах зээлийн үнээр тогтооно.

38.2.Төрийн болон орон нутгийн өмчийг бусдад төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр шилжүүлэх бол төлбөрийн доод хэмжээг тухайн хөрөнгийн зах зээлийн үнийн 50 хувиас багагүй байхаар тогтооно.

39 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн зах зээлийн үнийг тогтоох

39.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийг тогтоохдоо дараах шаардлагыг хангасан үнэлгээний тайлан гаргана:

39.1.1.тусгай зөвшөөрөл бүхий үнэлгээний хуулийн этгээдээр хийлгэсэн байх;

39.1.2.хөрөнгийн үнэлгээний сайн туршлагад үндэслэж, боловсруулсан байх.

39.2.Үнэлгээний тайланг тухайн төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх шийдвэр гаргахаас зургаан сарын өмнө гаргасан байна.

39.3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөдлөх эд хөрөнгө, үнэт цааснаас бусад эдийн бус хөрөнгийн зах зээлийн үнийг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7.2-т заасан журам, аргачлалыг баримтлан Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газар тогтоож болно.

39.4.Тухайн төрлийн хөрөнгийн идэвхтэй зах зээлгүй, харьцуулалт хийх боломжгүйн улмаас үнийг тогтоох боломжгүй талаарх мэргэшсэн үнэлгээчний дүгнэлтийг үндэслэн Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газар тухайн шилжүүлэх өмчийн үнийг боломжит бусад үндэслэл, тооцоололд суурилан тогтоож болно.

40 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг солих

40.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийг дараах тохиолдолд өөр төрлийн эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгөөр сольж болно:

40.1.1.бусдын өмчийг нийтийн эрх ашгийн төлөө дайчлан авсан бөгөөд өмчлөгчид буцаан өгөх боломжгүй болсон буюу чанар байдлын хувьд доройтуулсан бол;

40.1.2.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг өөр хөрөнгөөр солих нь нийтийн эрх ашигт нийцэх бол;

40.1.3.хуульд заасан бусад.

40.2.Солилцож байгаа хөрөнгийн үнийн зөрүү нь үл хөдлөх эд хөрөнгийн хувьд 10 хувиас, хөдлөх эд хөрөнгийн хувьд 30 хувиас хэтрэхгүй байна.

40.3.Солилцож байгаа эд хөрөнгийн үнийн зөрүүг төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэн авсан этгээд улсын болон орон нутгийн төсөвт мөнгөн хэлбэрээр төлнө.

40.4.Төрийн болон орон нутгийн өмчийг өөр хөрөнгөөр солих нөхцөл, шаардлагыг ил тод зарлаж, солилцоо хийх этгээдийг нээлттэй сонгон шалгаруулна.

40.5.Солилцооны зүйл нь нэг бүрийн шинжээр тодорхойлогдох бол энэ хуулийн 40.4-т заасныг баримтлахгүй.

40.6.Солилцоо хийхийн өмнө тухайн хөрөнгөд энэ хуулийн 67 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээ хийнэ.

40.7.Солилцож байгаа хөрөнгө нь үл хөдлөх эд хөрөнгө бол энэ хуулийн 68 дугаар зүйлд заасны дагуу магадлах ажиллагаа хийнэ.

40.8.Соёлын биет өвийг солилцохыг хориглоно.

40.9.Энэ хуульд заасан төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх шийдвэр гаргах журмыг солилцох харилцаанд нэгэн адил мөрдөнө.

41 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг барьцаалуулах

41.1.Төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөгч, өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшлийн үл хөдлөх эд хөрөнгийг төрийн болон орон нутгийн, эсхүл гуравдагч этгээдийн гүйцэтгэх үүргийн биелэлтийг хангах зорилгоор барьцаалуулахыг хориглоно.

41.2.Энэ хуулийн 41.1-д заасныг зөрчсөн бол учирсан хохирлыг шийдвэр гаргасан этгээд өөрийн хөрөнгөөр хариуцан төлнө.

42 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх шийдвэрийн агуулга

42.1.Төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх шийдвэр дараах агуулгатай байна:

42.1.1.шилжүүлж байгаа хөрөнгийн мэдээлэл;

42.1.2.төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх болсон хуульд заасан үндэслэл;

42.1.3.төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх арга, журам, аргачлал;

42.1.4.дуудлага худалдаа, эсхүл уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах, төлөөлөн гэрээ байгуулах этгээд;

42.1.5.дуудлага худалдаагаар худалдах доод үнэ;

42.1.6.уралдаант шалгаруулалтаар худалдах бол нэмэлт нөхцөл;

42.1.7.хөрөнгө шилжүүлэх ажлыг зохион байгуулах зардал, зардлын эх үүсвэр.

42.2.Төрийн болон орон нутгийн өмчийн үнэт цаасыг шилжүүлэх шийдвэрт тусгах нэмэлт нөхцөлийг холбогдох хуулиар нарийвчлан зохицуулна.

43 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг шилжүүлэх ажиллагаа

43.1.Хууль болон энэ хуулийн 34.2-т заасан шийдвэрт өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигч өмчийг шилжүүлэх ажиллагааг зохион байгуулна.

43.2.Хууль болон энэ хуулийн 34.2-т заасан шийдвэрт өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигч нь өмчийг шилжүүлэх гэрээнд дараах нөхцөлийг тусгана:

43.2.1.гэрээний талуудын нэр, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн дугаар, иргэн бол төрсөн он, сар, өдөр;

43.2.2.гэрээний зүйл;

43.2.3.гэрээний төлбөр;

43.2.4.хөрөнгийн өмчлөх эрх шилжих журам, хугацаа;

43.2.5.гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах арга;

43.2.6.гэрээний нэмэлт нөхцөл;

43.2.7.гэрээ байгуулахтай холбоотой зардлыг хуваарилах журам;

43.2.8.өмчийг хариу төлбөргүй, эсхүл төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр шилжүүлж байгаа бол өмчийг ашиглах тусгай зориулалт.

43.3.Өмчийг шилжүүлэх гэрээний нөхцөлд дараах нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулж болно:

43.3.1.төр, эсхүл орон нутагт хохирол, алдагдал учруулахгүй, нэмэлт үүрэг хүлээхээргүй бол;

43.3.2.дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалт зохион байгуулах журмыг зөрчихөөргүй бол.

44 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг баланс хооронд шилжүүлэх

44.1.Төрийн болон орон нутгийн өмчийг баланс хооронд хариу төлбөргүй шилжүүлэхэд дараах журмыг баримтална:

44.1.1.төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага хооронд үл хөдлөх эд хөрөнгө шилжүүлэх шийдвэрийг Засгийн газар;

44.1.2.төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага хооронд хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө шилжүүлэх шийдвэрийг Төрийн өмчийн хороо;

44.1.3.орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшлийн үл хөдлөх эд хөрөнгийг тухайн орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагад шилжүүлэх шийдвэрийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;

44.1.4.орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшлийн хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг тухайн орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагад шилжүүлэх шийдвэрийг Засаг дарга.

45 дугаар зүйл.Орон нутгийн өмчийг төрийн өмчид шилжүүлэх

45.1.Улсын Их Хурал нь нийтийн эрх ашгийг хангах зорилгоор орон нутгийн өмчийг төрийн өмчид шилжүүлэн авах талаар Засгийн газрын саналыг хэлэлцэж, шийдвэр гаргана.

45.2.Засгийн газар нь дараах тохиолдолд орон нутгийн өмчийг төрийн өмчид буцаан шилжүүлж болно:

45.2.1.олон улсын гэрээний дагуу үүрэг хүлээсэн бол;

45.2.2.улсын төсвийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцсөний үндсэн дээр.

45.3.Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн Засгийн газрын шийдвэрээр орон нутгийн өмчийг төрийн өмчид шилжүүлж болно.

45.4.Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зөвшөөрснөөс бусад тохиолдолд орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон орон нутгийн өмчийг төрийн өмчид шилжүүлэн авахыг хориглоно.

46 дугаар зүйл.Өмч шилжүүлсний дараах хяналт

46.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг шилжүүлэхэд тавьсан тусгай болзол, шаардлага болон уралдаант шалгаруулалтын нэмэлт нөхцөлийг хангаж байгаа эсэхийг тогтоох зорилгоор өмч шилжүүлсний дараах хяналтыг хэрэгжүүлнэ.

46.2.Өмч шилжүүлсний дараах хяналтыг гэрээг дүгнэх болон хяналт шалгалтын журмаар дараах этгээд хэрэгжүүлнэ:

46.2.1.гэрээний дүгнэлтийг энэ хуулийн 34.2-т заасан этгээд;

46.2.2.төрийн өмчид хамаарах хяналт шалгалтыг Засгийн газрын шийдвэрээр Төрийн өмчийн хороо;

46.2.3.орон нутгийн өмчид хамаарах хяналт шалгалтыг аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр Орон нутгийн өмчийн газар.

46.3.Өмч шилжүүлэн авсан этгээд энэ хуулийн 46.1-д заасан тусгай болзол, шаардлага, уралдаант шалгаруулалтын нэмэлт нөхцөлийг хангаагүй, эсхүл

хяналтаар дараах нөхцөл байдал илэрсэн бол гэрээг цуцлах, шилжүүлсэн өмчийг буцаан авах, буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэл болно:

46.3.1.эрх бүхий этгээдийн шийдвэр, зөвшөөрөлгүйгээр дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалт зохион байгуулсан, эсхүл ялагчид хууль бус давуу байдал үүсгэсэн;

46.3.2.энэ хуулийн 52.5.2, 52.5.4-т заасан нөхцөл илэрсэн;

46.3.3.гэрээнд зааснаас өөр зориулалтаар ашигласан, хохирол учруулсан;

46.3.4.худалдах доод үнээс бага үнээр худалдсан, шилжүүлэхийг зөвшөөрөөгүй хөрөнгө оролцуулсан;

46.3.5.гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь зохих ёсоор биелүүлээгүй.

46.4.Энэ хуулийн 46.3-т заасан үндэслэлээр гэрээг цуцлах шийдвэрийг Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газар гаргана.

46.5.Гэрээг цуцлах шийдвэрт тухайн хөрөнгийг хамгаалах болон цаашид авах арга хэмжээний талаар заана.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙГ АШИГЛУУЛАХ, ШИЛЖҮҮЛЭХ АРГА, ЖУРАМ

47 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах, шилжүүлэх арга

47.1.Төрийн болон орон нутгийн өмчийг бусдад ашиглуулах, шилжүүлэхдээ дараах аргын хэрэглэнэ:

47.1.1.дуудлага худалдаа;

47.1.2.уралдаант шалгаруулалт;

47.1.3.гэрээ шууд байгуулах.

47.2.Энэ хуулийн 47.1.1-д заасан аргыг хэрэглэхдээ зөвхөн нээлттэй дуудлага худалдааны хэлбэрээр явуулна.

47.3.Дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалт зохион байгуулах журмыг Төрийн өмчийн хороо батална.

НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ ДУУДЛАГА ХУДАЛДАА ЯВУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

48 дугаар зүйл.Дуудлага худалдааны журам

48.1.Дуудлага худалдааны аргыг дараах тохиолдолд хэрэглэнэ:

48.1.1.гэрээ шууд байгуулах болон уралдаант шалгаруулалт явуулахаас бусад тохиолдолд өмчийг бусдад ашиглуулах, шилжүүлэх бол;

48.1.2.дуудлага худалдааны аргыг хэрэглэхээр хуульд заасан бол.

48.2.Дуудлага худалдаа явуулах шийдвэрийг энэ хуулийн 29.1, 34.2-т заасан этгээд гаргах ба тус шийдвэрт дуудлага худалдаа зохион байгуулах этгээдийг тодорхой заана.

48.3.Дуудлага худалдаа явуулах тухай зар мэдээг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газрын болон тухайн өмчийн эзэмшигч байгууллагын цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.

48.4.Санал хүлээн авах хугацааг зар мэдээг гаргасан өдрөөс хойш 14-өөс доошгүй хоног байхаар тогтоох бөгөөд үл хөдлөх эд хөрөнгийн дуудлага худалдааны зар мэдээг 30-аас доошгүй хоногийн өмнө мэдээлнэ.

48.5.Энэ хуулийн 48.3-т заасан зар мэдээнд шилжүүлэх, ашиглуулах эд хөрөнгө, түүний зориулалт, эд хөрөнгийн үнэ, эдийн засгийн үр ашгийн үзүүлэлт, эд хөрөнгийг худалдах доод үнэ, эд хөрөнгө, ажил, үйлчилгээний нөхцөл, онцлогтой холбогдох бусад болон гэрээний төслийн талаарх мэдээлэл, дуудлага худалдаа явуулах хугацаа, хураамж, дэнчин болон бусад нөхцөлийг тусгасан байна.

48.6.Дуудлага худалдааны зар мэдээг олон нийтэд мэдээлснээс хойш сонирхогч аливаа этгээд зохион байгуулагчийн тогтоосон газар, цагт ашиглуулах, шилжүүлэх хөрөнгийг шалган үзэж, гэрээний нөхцөл, саналтай танилцаж болно.

48.7.Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгөд үзлэг, тооллого хийх бөгөөд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцан хамгаалах, хөрөнгийг шинэ өмчлөгчид хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд хамгаалалтыг этгээд хариуцах этгээдийг тухайн хөрөнгийг эзэмшигч томилно.

48.8.Дуудлага худалдаа зохион байгуулах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх бөгөөд орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

48.9.Дуудлага худалдааны тайланг Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, холбогдох баримт материалыг зохих журмын дагуу архивд шилжүүлнэ.

48.10.Дуудлага худалдааны үнийг бүрэн төлсөн талаар энэ хуулийн 77.1-д заасан мэдээллийн нэгдсэн санд оруулж, хөрөнгийн эрх шилжилтийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлнэ.

49 дүгээр зүйл.Дуудлага худалдааны доод үнэ

49.1.Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн санал болгох доод үнийг тогтоохдоо Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийг баримтална.

49.2.Дуудлага худалдааны доод үнийг тухайн хөрөнгийн зах зээлийн үнэлгээг харгалзан тогтоох бөгөөд төрийн өмчийн хөрөнгөд Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн хөрөнгөд Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрлийг авна.

49.3. Дуудлага худалдааг дахин зарлах тохиолдолд доод үнийг шинээр тогтоох бөгөөд хоёр дахь дуудлага худалдааны доод үнийг анхны дуудлага худалдааны доод үнийн 50 хүртэл хувиар багасган тогтоож болно.

50 дугаар зүйл. Хураамж, дэнчин тогтоох

50.1. Энэ хуулийн 29.1, 34.2-т заасан этгээд дуудлага худалдааны хураамж болон дэнчингийн хэмжээг тогтооно.

50.2. Дуудлага худалдааны хураамжийн хэмжээг тухайн эд хөрөнгийн дуудлага худалдааны доод үнийн 10 хүртэлх хувиар тогтоож болно.

50.3. Дуудлага худалдааны дэнчинд төлөх мөнгөн дүнг тухайн эд хөрөнгийн дуудлага худалдааны доод үнийн 20 хүртэлх хувиар тогтооно.

50.4. Дуудлага худалдаанд ялагч болсон этгээд гэрээг тогтоосон хугацаанд байгуулаагүй, байгуулахаас татгалзсан, эсхүл гэрээний үүргийг гүйцэтгэх баталгааг гаргаж чадаагүй тохиолдолд дуудлага худалдааны дэнчингийн мөнгийг буцаан олгохгүй.

51 дүгээр зүйл. Дуудлага худалдааг зохион байгуулах

51.1. Дуудлага худалдааг танхим, эсхүл цахим хэлбэрээр нээлттэй зохион байгуулна.

51.2. Оролцогчид дуудлага худалдаанд биечлэн оролцох боломжтой нөхцөлд дуудлага худалдааг танхимаар зохион байгуулж болно.

51.3. Танхимаар зохион байгуулах дуудлага худалдаанд оролцогчид биечлэн, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөө байлцуулж, үнийн саналаа ээлж дараалан өсгөн хэлэх замаар оролцоно.

51.4. Дуудлага худалдаанд оролцогчийн санал дуудлага худалдааны дүн гартал хүчинтэй гэж тооцогдох ба дуудлага худалдаанд ялагчийн үнийн саналыг гэрээ байгуулах хүртэл хүчинтэй гэж үзнэ.

51.5. Цахим хэлбэрээр явуулах дуудлага худалдаанд оролцогчид харилцаа холбооны сүлжээгээр дамжуулан дуудлага худалдаа зохион байгуулагчтай холбогдож, саналаа гаргана. Дуудлага худалдаанд оролцогчийн үнийн санал бусад оролцогчид нэгэн зэрэг ил харагдах боломжтой байна.

52 дугаар зүйл. Дуудлага худалдааны үр дүнг батлах

52.1. Танхимын хэлбэрээр зохион байгуулсан дуудлага худалдааны ялагч ба хоёр дахь дээд үнийн санал гаргасан оролцогчийн үнийн санал, бүртгэлийн дугаарыг дуудлага худалдааны ялагч тодормогц нээлттэй зарлан мэдэгдэнэ.

52.2. Цахим дуудлага худалдааны үр дүнг ялагч тодормогц бүх оролцогчид болон олон нийтэд харилцаа холбооны сүлжээгээр дамжуулан тэр даруй мэдэгдэнэ.

52.3. Дуудлага худалдаа зохион байгуулах шийдвэр гаргасан этгээд дуудлага худалдааны үр дүнг хүлээж авснаас хойш ажлын 10 өдрийн дотор дуудлага худалдааг хүчинтэй эсэхийг баталгаажуулна.

52.4. Дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулсан шийдвэрт дуудлага худалдааны ялагчийн нэр, ялсан үнийн санал болон хоёр дахь дээд үнийн санал ирүүлсэн этгээдийн нэрийг үнийн саналын хамт тусгана.

52.5. Дараах тохиолдолд дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулахаас татгалзаж, энэ тухай зарлана:

52.5.1. оролцогчид хөтлөгчийн зааварчилгааг дагаагүй, дуудлага худалдааны дэг, журам зөрчсөн нь дуудлага худалдааны үр дүнд нөлөөлсөн бол;

52.5.2. дуудлага худалдааны үеэр оролцогчид өөр хоорондоо хуйвалдсан, түүнтэй төсөөтэй үйлдэл гаргасан бөгөөд энэ нь дуудлага худалдааны үр дүнд нөлөөлсөн болох нь илэрсэн бол;

52.5.3. дуудлага худалдааг зохион байгуулах этгээд, эсхүл дуудлага худалдааны хөтлөгч нь дуудлага худалдаа явуулах дэг, журмыг зөрчсөн нь дуудлага худалдааны үр дүнд нөлөөлсөн бол;

52.5.4. дуудлага худалдааны ялагч нь дуудлага худалдаанд оролцох эрхгүй этгээд бол.

52.6. Дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулахаас татгалзах шийдвэрт шалтгааныг тодорхой тусгана.

53 дугаар зүйл. Дуудлага худалдааг дахин зарлах

53.1. Дуудлага худалдааг дараах тохиолдолд дахин зарлана:

53.1.1. хоёроос доош оролцогч бүртгүүлсэн, эсхүл дуудлага худалдаанд оролцсон;

53.1.2. хоёроос доош санал ирсэн, эсхүл шаардлага хангасан санал ирээгүй;

53.1.3. энэ хуулийн 54.4-т заасан нөхцөл бий болсон;

53.1.4. дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулахаас татгалзах шийдвэр гарсан бол.

54 дүгээр зүйл. Дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулах

54.1. Энэ хуулийн 29.1, 34.2-т заасан этгээд нь ялагчтай гэрээ байгуулах хугацааг дуудлага худалдааны үр дүнг баталгаажуулснаас хойш нэг сараас илүүгүй байхаар тогтооно. Хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд гэрээ байгуулах хугацааг мөн хугацаагаар нэг удаа сунгаж болно.

54.2. Ялагч гэрээ байгуулахаас татгалзсан, эсхүл энэ хуульд заасан хугацаанд гэрээ байгуулаагүй, эсхүл гэрээний үүргийг гүйцэтгэх баталгаа гаргаж чадаагүй бол

хоёр дахь дээд үнийн санал ирүүлсэн оролцогчийг ялагчаар баталгаажуулж, гэрээ байгуулах саналыг гаргана.

54.3.Энэ хуулийн 54.2-т заасны дагуу хоёр дахь дээд үнийн санал ирүүлсэн оролцогчийг ялагчаар баталгаажуулсан бол гэрээг нэг сарын дотор байгуулна.

54.4.Хоёр дахь дээд үнийн санал ирүүлсэн оролцогч гэрээ байгуулахаас татгалзсан бол дуудлага худалдааг дахин зарлана.

54.5.Дуудлагын худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийг өмчлөх эрх нь худалдах, худалдан авах гэрээний зүйлийн үнийг бүрэн төлж, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

55 дугаар зүйл.Уралдаант шалгаруулалтын журам

55.1.Төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах, шилжүүлэхэд тусгай болзол, шаардлагыг тогтоох бол уралдаант шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.

55.2.Уралдаант шалгаруулалт явуулах шийдвэрийг энэ хуулийн 29.1, 34.2-т заасан этгээд гаргах ба тус шийдвэрт уралдаант шалгаруулалт зохион байгуулах этгээдийг тодорхой заана.

55.3.Уралдаант шалгаруулалтын зар мэдээг шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө олон нийтэд мэдээлнэ.

55.4.Уралдаант шалгаруулалтын зар мэдээнд энэ хуулийн 48.5-д зааснаас гадна дараах зүйлийг тусгана:

55.4.1.уралдаант шалгаруулалтын шалгуур үзүүлэлт;

55.4.2.хөрөнгийн цаашдын ашиглалт, захиран зарцуулалтад тавих тусгай болзол, шаардлага;

55.4.3.уралдаант шалгаруулалтад оролцогчийг урьдчилан бүртгэх хугацаа;

55.4.4.уралдаант шалгаруулалтын төслийг ирүүлэх эцсийн хугацаа;

55.4.5.гэрээний ерөнхий нөхцөл;

55.4.6.дэнчин, хураамжийн хэмжээ.

55.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгийг удирдах үйл ажиллагааг менежментийн гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр уралдаант шалгаруулалт явуулж болно.

55.6.Энэ хуулийн 48.5, 48.6, 48.7, 48.8, 48.9, 48.10, 51.3, 51.5-д заасан журам уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахад нэгэн адил үйлчилнэ.

55.7.Уралдаант шалгаруулалтын доод үнэ болон хураамж, дэнчинг энэ хуулийн 49, 50 дугаар зүйлд заасны дагуу тогтооно.

56 дугаар зүйл.Уралдаант шалгаруулалтын нэмэлт нөхцөл

56.1.Уралдаант шалгаруулалтаар төрийн болон орон нутгийн өмчийг ашиглуулах, шилжүүлэхэд дараах нэмэлт нөхцөл тогтоож болно:

56.1.1.хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалт хийх;
56.1.2.эд хөрөнгийг тусгай зориулалтаар ашиглах үүрэг хүлээлгэх;
56.1.3.ажилтнуудыг тогтвортой ажиллуулах;
56.1.4.шинэ ажлын байр бий болгох;
56.1.5.тогтоосон шаардлагад нийцсэн техникийн, санхүүгийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах;

56.1.6.байгаль орчныг хамгаалах шаардлагыг биелүүлэх;
56.1.7.тухайн бүс, орон нутгийн иргэдэд шаардлагатай нийтийн үйлчилгээг хүргэх;

56.1.8.уралдаант шалгаруулалт явуулах шийдвэр гаргасан этгээдээс тогтоосон бусад нэмэлт нөхцөл.

57 дугаар зүйл.Уралдаант шалгаруулалтын ялагчтай гэрээ байгуулах

57.1.Төрийн болон орон нутгийн өмчийг уралдаант шалгаруулалтаар ашиглуулах, шилжүүлэх шийдвэр гаргасан этгээд ялагчтай гэрээ байгуулна.

57.2.Уралдаант шалгаруулалтын ялагчтай байгуулах гэрээнд дараах нөхцөлийг тусгана:

57.2.1.үндсэн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүйгээр хөрөнгө оруулж, технологийг шинэчлэх замаар хуулийн этгээдийн үр ашгийг дээшлүүлэх;

57.2.2.хуулийн этгээдийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг нийгэм, бүс, орон нутгийн хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлж өөрчлөн байгуулах;

57.2.3.менежментийн гэрээг хэрэгжүүлэгч этгээдээс үйлдвэрлэл, үйл ажиллагааны зохион байгуулалт, технологийн үйл ажиллагааг өөрчлөн байгуулах болон үр ашгийг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, үе шат, түүнийг үнэлэх шалгуур үзүүлэлт, менежментийн гэрээ хэрэгжүүлэгч этгээдийн цалин хөлс, урамшуулал;

57.2.4.гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлсэн нөхцөлд төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгөөс шилжүүлэн өгөх хэмжээ, хэлбэр, үнэ;

57.2.5.гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй нөхцөлд хүлээлгэх хариуцлага, учруулсан хохирлыг нөхөн төлөх хэлбэр, хэмжээ, барьцаалах хөрөнгө.

57.3.Менежментийн гэрээгээр ажиллах этгээд нь гэрээнд заасан бол өөрийн багийг бүрдүүлж болно.

58 дугаар зүйл.Гэрээ шууд байгуулах журам

58.1.Гэрээ шууд байгуулах аргыг дараах тохиолдолд хэрэглэнэ:

58.1.1.төрийн өмчийг төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага, төрийн өмчит компанид шилжүүлэх, ашиглуулах бол;

58.1.2.орон нутгийн өмчийг тухайн орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага, орон нутгийн өмчит компанид шилжүүлэх, ашиглуулах бол;

58.1.3.дуудлага худалдааг дахин зарласан боловч ялагч тодроогүй бол;

58.1.4.уралдаант шалгаруулалтын тусгай болзол, шаардлага болон нэмэлт нөхцөлийг бууруулж, дахин зарласан боловч ялагч тодроогүй бол;

58.1.5.гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхээр хуульд заасан бол.

58.2.Энэ хуулийн 58.1.3, 58.1.4-т заасан тохиолдолд гэрээ шууд байгуулах зарлалыг тухайн төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигч байгууллагын цахим хуудсанд зарлан нийтэлнэ.

58.3.Сонирхогч этгээд нь гэрээ шууд байгуулах зарлалыг байршуулсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор хэлэлцээнд орох сонирхлоо илэрхийлэх бөгөөд сонирхлоо илэрхийлэх эцсийн хугацаанаас хойш ажлын таван өдрийн дотор хэлэлцээг сонирхогч этгээдтэй нэгэн зэрэг хийнэ.

58.4.Энэ хуулийн 58.3-т заасан хэлэлцээнд оролцсон сонирхогч этгээдээс гаргасан хамгийн сайн үнийн саналыг үндэслэн тухайн этгээдтэй гэрээ байгуулах шийдвэр гаргана.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, ТООЛЛОГО, ТАЙЛАН

59 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл

59.1.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийг нэгдсэн болон дагнасан бүртгэл гэж ангилна.

59.2.Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэл нь дараах өмчийн бүртгэлээс бүрдэнэ:

59.2.1.төрийн нийтийн өмчийн бүртгэл;

59.2.2.төрийн тусгайлсан өмчийн бүртгэл;

59.2.3.орон нутгийн өмчийн бүртгэл.

59.3.Төрийн нийтийн өмчийн анхан шатны бүртгэлийг тухайн салбарыг хариуцсан төрийн байгууллага, нэгтгэсэн бүртгэлийг Төрийн өмчийн хороо хөтөлнө.

59.4.Төрийн тусгайлсан өмчийн анхан шатны бүртгэлийг өмчийн эзэмшигч, нэгтгэсэн бүртгэлийг Төрийн өмчийн хороо хөтөлнө.

59.5.Орон нутгийн өмчийн анхан шатны бүртгэлийг өмчийн эзэмшигч, нэгтгэсэн бүртгэлийг Орон нутгийн өмчийн газар хөтөлнө.

59.6.Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна оршиж байгаа төрийн өмчийн анхан шатны бүртгэлийг Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар хөтөлнө.

59.7.Төрийн нууцад хамаарах өмчийн бүртгэлийг энэ хуулийн 3.5-д заасан журмаар эрх олгосон этгээд хөтөлнө.

59.8.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл хөтлөх журмыг Төрийн өмчийн хороо батална.

59.9.Төрийн нийтийн болон төрийн тусгайлсан өмчийн төрлөөр дагнасан бүртгэлийг хөтөлж болно.

59.10.Төрийн болон орон нутгийн өмчийн дагнасан бүртгэлийн ангилал, код, маягтын загварыг Үндэсний статистикийн хорооны зөвшөөрлийг үндэслэн Төрийн өмчийн хороо батална.

60 дугаар зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийн дагнасан бүртгэл

60.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө, түүнийг бусдад ашиглуулах, шилжүүлэх болон холбогдох гэрээ хэлцэлд хяналт тавих, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор үл хөдлөх эд хөрөнгийн дагнасан бүртгэлийг хөтөлнө.

60.2.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн дагнасан бүртгэлийг өмчийн эзэмшигч хөтөлнө.

60.3.Төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн нэгтгэсэн бүртгэлийг Төрийн өмчийн хороо, орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн нэгтгэсэн бүртгэлийг Орон нутгийн өмчийн газар хөтөлнө.

60.4.Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд дараах мэдээллийг тусгана:

60.4.1.үл хөдлөх эд хөрөнгө, түүний зориулалт;

60.4.2.үл хөдлөх эд хөрөнгийн хөдөлгөөн, эзэмшигчийн мэдээлэл;

60.4.3.үл хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, дамжуулан ашиглуулах болон шилжүүлэх гэрээ, тухайн үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой шийдвэр, мэдэгдэл, бусад гэрээ;

60.4.4.бусдын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигч ашиглаж байгаа бол холбогдох шийдвэр, гэрээ;

60.4.5.үл хөдлөх эд хөрөнгийн цахилгаан, дулаан ашиглалтын талаарх мэдээлэл;

60.4.6.хуульд заасан бусад.

60.5.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн зориулалтыг өөрчлөх бол Төрийн өмчийн хороо, эсхүл Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрлийг авсан байна.

60.6.Өмчийн эзэмшигч нь үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой гэрээний талаарх мэдээллийг гэрээ байгуулсан, эсхүл түүнд нэмэлт, өөрчлөлт оруулснаас

хойш ажлын таван өдрийн дотор нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, холбогдох өөрчлөлтийг оруулах үүрэгтэй.

61 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого

61.1.Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого нь төрийн өмчийн тооллого, орон нутгийн өмчийн тооллого, дагнасан тооллогоос бүрдэнэ.

61.2.Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогыг тухайн өмчийн бүртгэл дээр үндэслэн явуулна.

61.3.Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн тооллогыг дараах хэлбэрээр зохион байгуулна:

61.3.1.төрийн нийтийн өмчийн нэгдсэн тооллого;

61.3.2.төрийн тусгайлсан өмчийн нэгдсэн тооллого;

61.3.3.орон нутгийн өмчийн нэгдсэн тооллого.

61.4.Энэ хуулийн 61.3.1-д заасан тооллогыг дөрвөн жил тутам тухайн өмчийг харьяалах төрийн байгууллагатай хамтран холбогдох хуульд заасны дагуу Төрийн өмчийн хороо зохион байгуулна.

61.5.Энэ хуулийн 61.3.2-т заасан тооллогыг дөрвөн жил тутам Төрийн өмчийн хороо зохион байгуулж, тайланг Засгийн газарт хүргүүлнэ.

61.6.энэ хуулийн 61.3.3-т заасан тооллогыг хоёр жил тутам Засаг даргын шийдвэрийн дагуу Орон нутгийн өмчийн газар зохион байгуулж, тайланг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Төрийн өмчийн хороонд хүргүүлнэ.

62 дугаар зүйл.Дагнасан тооллого

62.1.Дагнасан тооллогыг дараах хэлбэрээр зохион байгуулна:

62.1.1.төрийн нийтийн өмчийн тодорхой төрлийн дагнасан тооллого;

62.1.2.төрийн тусгайлсан өмчийн тодорхой төрлийн дагнасан тооллого;

62.1.3.тодорхой салбарт ашиглагдах төрийн болон орон нутгийн өмчийн дагнасан тооллого.

62.2.Энэ хуулийн 62.1.1, 62.1.2-т заасан дагнасан тооллогыг Засгийн газрын шийдвэрээр, энэ хуулийн 62.1.3-т заасан дагнасан тооллогыг Засгийн газар, Засаг даргын шийдвэрээр тухай бүр зохион байгуулна.

62.3.Тооллогын зохион байгуулалтыг улсын хэмжээнд Төрийн өмчийн хороо, орон нутгийн хэмжээнд Орон нутгийн өмчийн газар хариуцна.

62.4.Дагнасан тооллогыг хэрэгжүүлэх ажилд хяналт тавих, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий туслах төлөөлөгчийг орон нутагт, эсхүл тодорхой салбарт Төрийн өмчийн хороо томилон ажиллуулж болно.

62.5.Засгийн газар энэ хуулийн 62.1.1-д заасан тооллогын дүнг тухай бүр Улсын Их Хуралд хүргүүлнэ.

63 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын журам

63.1.Төрийн нийтийн өмчийн тооллого хийх нийтлэг журмыг хуульд заасан холбогдох байгууллагын саналыг үндэслэн Төрийн өмчийн хороо батална.

63.2.Төрийн нийтийн өмчөөс бусад төрийн болон орон нутгийн өмчийн тооллогыг дараах журмаар явуулна:

63.2.1.төрийн болон орон нутгийн байгууллагын өмчийн тооллого;

63.2.2.төрийн болон орон нутгийн нийтийн үйлчилгээний байгууллагын өмчийн тооллого;

63.2.3.төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасны тооллого.

64 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын өмчийн тооллого

64.1.Төрийн болон орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын удирдлага өмчийн тооллогыг дараах хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгах үүрэгтэй:

64.1.1.үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт болон барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жил тутам хийж, тайланг тухайн оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 31-ний өдрийн дотор;

64.1.2.түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг хагас жил тутам гүйцэтгэж, тайланг тухайн оны 06 дугаар сарын 01, 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор;

64.1.3.дуусаагүй үйлдвэрлэл, өөрийн үйлдвэрийн хагас боловсруулсан зүйл, үнэт цаасны тооллогыг улиралд тутам хийж, тайланг улирлын сүүлийн сарын 25-ны өдрийн дотор;

64.1.4.мөнгөн хөрөнгийн тооллогыг сар бүр хийж, тайланг дараа сарын 05-ны өдрийн дотор;

64.1.5.мал, амьтны тооллогыг жил тутам хийж, тайланг тухайн оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

64.1.6.бүх төрлийн харилцах дансны хуулгыг тухай бүр нь авч, дансны гүйлгээг шалгаж, улирал бүрийн дансны үлдэгдлийг баталгаажуулах;

64.1.7.гэнэтийн буюу давагдашгүй шинжтэй нөхцөл байдлын улмаас хөрөнгөд хохирол учирсан, эсхүл хөрөнгийг солих бол хэсэгчилсэн тооллогыг тухай бүр.

64.2.Төрийн болон орон нутгийн өмчит компани нь хөрөнгийн дотоодын тооллогоор дутагдсан, илүүдсэн хөрөнгө болон цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийг тооцож, хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

65 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасны тооллого

65.1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлага тухайн компанийн хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасны тооллогыг дараах хугацаанд тогтоосон аргачлалын дагуу хийнэ:

65.1.1.нээлттэй хувьцаат компанийн эзэмшлийн хувийг тухайн оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 31-ний өдрийн дотор, сүүлийн зургаан сарын зах зээлийн жигнэсэн дундаж үнэд тулгуурлан;

65.1.2.хаалттай хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эзэмшлийн хувийг тухайн оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 31-ний өдрийн дотор, хувьцааны үнэлгээний аргад тулгуурлан.

65.2.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хувьцааны үнэлгээг хийхэд Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7.2-т заасан журам, аргачлалыг баримтална.

66 дугаар зүйл.Тооллогын комисс, түүний эрх, үүрэг

66.1.Төрийн болон орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага, компанийн удирдлага тооллого эхлэхээс өмнө Тооллогын комисс байгуулна.

66.2.Тооллогын комисс байгуулах шийдвэрт тооллого эхлэх, дуусах хугацааг тооллого явуулах салбар, нэгж бүрээр заасан байна.

66.3.Тооллогын комисс дараах эрхтэй:

66.3.1.тооллого явуулахын өмнө эд хариуцагчаас хөрөнгийн орлого, зарлагын бүх баримтыг нягтлан бодогчид бүрэн шилжүүлсэн эсэх баталгааг гаргуулан авах ба нягтлан бодогч уг баримтыг хүлээн авсан эсэхийг шалгах;

66.3.2.тооллого явуулахын өмнө хариуцагчийн хариуцаж байгаа бараа материалын үнэ бүхий зүйл, мөнгөн касс, агуулахыг лацдаж ломбодох болон харуул хамгаалалтын талаар илэрсэн дутагдлыг арилгах арга хэмжээ авахыг холбогдох этгээдээс шаардах;

66.3.3.тооллогын явцад түүхий эд, бараа материал, мөнгөн хөрөнгийг хүлээн авах, тавьж олгохыг бүрэн зогсоох, байгууллагын хэвийн ажиллагааг хангах зорилгоор Тооллогын комиссын хяналт дор зөвхөн үйлдвэрлэлийн хэрэгцээний зайлшгүй шаардлагатай түүхий эд, материалыг гаргах ба хүлээн авахыг зөвшөөрөх.

66.4.Тооллогын комисс дараах үүрэгтэй:

66.4.1.хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;

66.4.2.тоолсон хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн жишиг үнэтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих;

66.4.3.агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, өмнөх тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;

66.4.4.Тооллогын комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;

66.4.5.эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнээс өндөр үнээр авсан, эсхүл доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг гаргаж, авах арга хэмжээний талаарх санал гаргах.

66.5.Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигчийн ерөнхий буюу ахлах нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш ажлын таван өдрийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж, дансны үлдэгдлийг тулган шалгана.

67 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээ

67.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө бүрийн үнэлгээг бүртгэлд тусгасан байна.

67.2.Өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч болон эзэмшигч нь дараах ажиллагааг хэрэгжүүлэхийн өмнө тухайн хөрөнгөнд үнэлгээ хийлгэх үүрэгтэй:

67.2.1.хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэх бол;
67.2.2.компани, санд хувь нийлүүлэх, хөрөнгө оруулах бол;
67.2.3.бусад этгээдээс тухайн өмчид хөрөнгө оруулах бол;
67.2.4.төрийн өмчийн компанийн хувьцааг нийтэд санал болгох бол;
67.2.5.хохирол арилгуулах, нэхэмжлэх бол;
67.2.6.авлагад тооцож хөрөнгө хүлээн авах, өглөгөд тооцож хөрөнгө шилжүүлэх бол;

67.2.7.барьцаалуулах бол;
67.2.8.солилцох бол;
67.2.9.хуульд заасан бусад.

67.3.Төрийн болон орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага нь дараах тохиолдолд эд хөрөнгийн үнэлгээг хийлгэж болно:

67.3.1.тухайн хөрөнгийн бүртгэлийн үнэ зах зээлийн үнээс материаллаг хэмжээний зөрүүтэй болсон бол;

67.3.2.ашиглалтын хугацаа дуусаж үлдэгдэл өртөггүй болсон боловч цаашид ашиглах боломжтой үл хөдлөх эд хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоох бол;

67.3.3.хөдлөх хөрөнгийн ашиглалтын хугацаа дуусаагүй боловч цаашид ажлын хэрэгцээ шаардлага хангахгүй, эсхүл ашиглах боломжгүй болсон бол;

67.3.4.шаардлагатай бусад.

67.4.Үл хөдлөх эд хөрөнгө, түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалт зүйл, биет болон биет бус хөрөнгө, хязгаарлагдмал эрхээс бусад дараах хөрөнгийн үнийг тухайн байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн саналыг үндэслэн Төрийн өмчийн хороо шинэчлэн тогтоож болно:

67.4.1.ашиглалтын хугацаа дуусаж үлдэгдэл өртөггүй болсон боловч цаашид ашиглах боломжтой хөдлөх хөрөнгө;

67.4.2.акталсан боловч бусдад худалдах боломжтой хөрөнгө.

67.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн үнэлгээг хийхэд Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7.2-т заасан журам, аргачлалыг баримтална.

68 дугаар зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийг магадлах ажиллагаа

68.1.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэхээс өмнө төрийн болон орон нутгийн хэрэгцээнд шаардлагатай эсэхийг тодорхойлох зорилгоор магадлах ажиллагаа хийнэ.

68.2.Магадлах ажиллагаа дараах тохиолдолд хийхгүй байж болно:

68.2.1.төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, эсхүл улс орны эдийн засгийн хөгжилд ач холбогдол бүхий хөрөнгө оруулалттай төслийг хэрэгжүүлэх бол;

68.2.2.тухайн бүс, орон нутгийн бизнесийн орчныг хөгжүүлэхэд төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг хязгаарлагдмал эрхээр ашиглуулах шаардлагатай болсон бол;

68.2.3.үл хөдлөх эд хөрөнгийг нийтийн хэрэгцээний шугам сүлжээний ажил, улсын болон орон нутгийн чанартай авто замын ажилд ашиглуулж байгаа бол;

68.2.4.үл хөдлөх эд хөрөнгөд сервитутын эрх үүсгэж байгаа бол.

68.3.Магадлах ажиллагааг дараах байгууллагын төлөөллөөс бүрдсэн баг хэрэгжүүлнэ:

68.3.1.төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч;

68.3.2.хот төлөвлөлтийн болон газар зохион байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, үл хөдлөх эд хөрөнгө байрлаж байгаа нэгжийн нутгийн захиргааны байгууллага;

68.3.3.Төрийн өмчийн хороо, эсхүл Орон нутгийн өмчийн газар;

68.3.4.шаардлагатай бусад.

68.4.Өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, өмчийн эзэмшигч нь магадлах ажиллагаа хийх тухай мэдэгдэл гаргаж нийтэд мэдээлнэ. Магадлах ажиллагааг эхлүүлэхээс өмнө ирүүлсэн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах тухай хүсэлтийг мэдэгдэлд хавсаргана.

68.5.Сонирхогч этгээдээс тухайн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах хүсэлт хүлээн авах хугацааг энэ хуулийн 68.4-т заасан мэдэгдлийг нийтлүүлсэн өдрөөс хойш ажлын 15 хүртэл өдөр байхаар тогтооно.

68.6.Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигчээс ирүүлсэн хүсэлт нь бусад этгээдээс ирүүлсэн хүсэлтээс давуу эрхтэйд тооцогдоно.

68.7.Үл хөдлөх эд хөрөнгийн магадлах ажиллагаа хийх журмыг Төрийн өмчийн хороо батална.

69 дүгээр зүйл.Эд хөрөнгийг ашиглах боломжгүй болсонд тооцох

69.1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг дараах тохиолдолд ашиглах боломжгүй болсонд тооцно:

69.1.1.ашиглалт, эдэлгээний хугацаа дууссан, цаашид ашиглах, хэрэглэх эдийн засгийн үр ашиггүй, эсхүл ашиглалт, хадгалалтын өндөр зардал гарах болсон;

69.1.2.иргэний гүйлгээнд оруулахыг хуулиар хориглосон;

69.1.3.үндэсний, олон нийтийн болон хувь хүний аюулгүй байдалд илт ноцтой сөрөг нөлөө үзүүлэх шинжтэй болсон;

69.1.4.ашиглалт, эдэлгээний хугацаа дуусаагүй боловч цаашид ашиглах, хэрэглэх эдийн засгийн үр ашиггүй болох нь тогтоогдсон, эсхүл ашиглалт, хадгалалтын өндөр зардал гарах болсон;

69.1.5.ашиглалт, эдэлгээний хугацаа дуусаагүй боловч төрийн болон орон нутгийн байгууллагын хэрэгцээ, шаардлагыг хангахгүй болсон;

69.1.6.бүрэн болон хэсэгчлэн устсан, гэмтсэн, тоногдсон, муудсан, хулгайд алдагдсан зэрэг шалтгааны улмаас ашиглах, хэрэглэх, эсхүл бусдад ашиглуулах, шилжүүлэх боломжгүй болсон.

69.2.Төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшилд байгаа тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүй болсонд тооцож, данс бүртгэлээс хасах шийдвэрийг эрх бүхий албан тушаалтны саналыг, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Төрийн өмчийн хороо, орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшлийн хөрөнгийн хувьд Орон нутгийн өмчийн газар зөвшөөрөл олгоно.

69.3.Төрийн болон орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 69.1.1, 69.1.2, 69.1.3, 69.1.4, 69.1.5-д заасан үндэслэлээр өөрийн эзэмшилд байгаа үл хөдлөх эд хөрөнгө, газар ашиглах эрх болон тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөс бусад эд хөрөнгийг ашиглах боломжгүйд тооцож данс, бүртгэлээс хасах шийдвэрийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн санал, эсхүл тооллогын комиссын дүгнэлтийг үндэслэн гаргана.

69.4.Энэ хуулийн 69.1.6-д заасан үндэслэлээр эд хөрөнгийг ашиглах боломжгүй болсон бол буруутай этгээдийг тогтоож, хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

69.5.Эд хөрөнгийг ашиглах боломжгүй болсонд тооцох шийдвэрт тухайн хөрөнгийн тодорхойлолт, шийдвэр гаргасан үндэслэл болон бусдад шилжүүлэх, устгах хэлбэрийг тодорхой тусгаж, шаардлагатай бусад мэдээллийг хавсаргана.

70 дугаар зүйл.Ашиглах боломжгүй хөрөнгийг данс, бүртгэлээс хасах

70.1.Ашиглах боломжгүй болсонд тооцогдсон хөрөнгийг бусдад шилжүүлсэн, устгасан, сэлбэгээр ашиглах болсон, барилга байгууламжийг нурааж буулгасан тухай тэмдэглэгээг холбогдох бүртгэлд хийж, данс, бүртгэлээс хасна.

70.2.Ашиглах боломжгүй болсонд тооцогдсон эд хөрөнгийг устгах, нурааж буулгах ажиллагааг боломжит хамгийн бага зардлаар, хүн, мал, амьтны эрүүл мэндэд аюулгүй, байгаль орчинд ээлтэй хэлбэрээр гүйцэтгэнэ.

70.3.Ашиглах боломжгүй болсонд тооцогдсон эд хөрөнгийг устгах, данс, бүртгэлээс хасах журмыг Төрийн өмчийн хороо батална.

70.4.Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зориулалттай зэвсэглэл, тусгай хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүй болсонд тооцож, эд хөрөнгийг устгах, данс, бүртгэлээс хасах асуудлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

70.5.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг нурааж буулгах, данс, бүртгэлээс хассан нь газар эзэмших, ашиглах эрхийг дуусгавар болгох, эсхүл зориулалтыг өөрчлөх үндэслэл болохгүй.

70.6.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө, газар эзэмших, ашиглах эрхийг эрх бүхий этгээдийн шийдвэр, энэ хуулийн 69.2-т заасан эд хөрөнгийг холбогдох эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр данс, бүртгэлээс хасахыг хориглоно.

71 дүгээр зүйл.Төлөвлөгөө, тайлан, мэдээ гаргах

71.1.Төрийн болон орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага нь өмчийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгийн удирдлагын стратегийг тодорхойлсон өмчийн ашиглалтын менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

71.2.Энэ хуулийн 71.1-д заасан өмчийн ашиглалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, заавар болон төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлж дүгнэх журмыг Төрийн өмчийн хороо батална.

71.3.Төрийн болон орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага энэ хуульд заасан, төрийн болон орон нутгийн өмчит компани нь Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуульд заасан холбогдох мэдээ, тайланг батлагдсан маягт, зааврын дагуу тухай бүр, санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай

хуульд заасны дагуу, эд хөрөнгийн удирдлагын жилийн тайланг дараа жилийн эхний улиралд багтаан тайлагнах үүрэгтэй.

71.2.Төрийн өмчийн хороо дараах нэгтгэсэн тайланг гаргаж, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлнэ:

71.2.1.төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигчийн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн нэгтгэсэн тайланг цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналын хамт дараа жилийн эхний улиралд багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад;

71.2.2.төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг жил бүр гаргаж, дараа жилийн эхний хагас жилд багтаан Засгийн газарт;

71.2.3.Засгийн газрын хэлэлцсэн төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланд дүгнэлт гаргуулахаар Үндэсний аудитын газарт.

71.3.Засгийн газар энэ хуулийн 71.2.2-т заасан нэгдсэн тайланг Үндэсний аудитын газрын дүгнэлтийн хамт Төсвийн тухай хуульд заасны дагуу нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг өргөн мэдүүлэх хугацаанд Улсын Их Хуралд хүргүүлнэ.

71.4.Орон нутгийн өмчийн газар нь аймаг, нийслэлийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, дараа жилийн эхний улиралд багтаан Төрийн өмчийн хороонд хүргүүлнэ.

71.5.Өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланд төрийн болон орон нутгийн өмчийн өөрчлөлт, хөдөлгөөн, өмчийн удирдлагын хэрэгжилтийн байдал, өмчийн ашиглалтын менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн талаарх нэгдсэн мэдээллийг тусгасан байна.

71.6.Өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланг Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн өмчийн хороо, харьяа орон нутгийн өмчийн төлөв байдлын тайланг аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газрын цахим хуудсанд тус тус байршуулна.

71.7.Өмчийн төлөв байдлын нэгдсэн тайланд тавигдах шаардлага, тайлагнах журмыг Засгийн газар, орон нутгийн өмчийн төлөв байдлын тайланд тавигдах шаардлага, тайлагнах журмыг Төрийн өмчийн хороо батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ

72 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хяналт

72.1.Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт нь өмчлөгчийн хяналт, төрийн хяналт болон өмчийн эзэмшигчийн дотоодын хяналтаас тус тус бүрдэнэ.

72.2.Төрийн өмчийн өмчлөгчийн хяналтыг Улсын Их Хурал, Засгийн газар, орон нутгийн өмчийн өмчлөгчийн хяналтыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.

72.3.Төрийн хяналтыг энэ хуульд заасан журмын дагуу Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газар хэрэгжүүлнэ.

72.4.Төрийн аудитын байгууллага болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь чиг үүргийнхээ хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн төрийн хяналтыг холбогдох хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.

73 дугаар зүйл.Өмчлөгчийн хяналт

73.1.Энэ хуулийн 72.2-т заасан этгээд нь өмчлөгчийн хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

73.1.1.төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллогын дүн, тайлан, мэдээтэй танилцах, үүрэг чиглэл өгөх;

73.1.2.төрийн болон орон нутгийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын үр дүн, эд хөрөнгийн удирдлагын талаар гаргасан шийдвэр, гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулсан, дүгнэсэн байдалтай танилцаж, үүрэг чиглэл өгөх;

73.1.3.өмчийн чиглэлээр хэрэгжүүлсэн төрийн болон дотоод хяналт шалгалт, аудитын тайлан, зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтэй танилцах, үүрэг чиглэл өгөх;

73.1.4.нээлттэй сонсгол зохион явуулах;

73.1.5.хуульд заасан бусад.

73.2.Өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлэгч нь шаардлагатай бол дараах арга хэмжээг хэрэгжүүлж болно:

73.2.1.төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч, түүнээс эрх шилжүүлэн авсан этгээдээс хөрөнгө олж авсан, өмчийг ашиглуулж, шилжүүлсэн шийдвэр, өмчийн удирдлагыг хэрэгжүүлсэнтэй холбоотой бусад баримт бичиг, мэдээлэлтэй танилцах, асуулга, асуулт тавих;

73.2.2.энэ хуулийн 73.2.1-д заасан этгээдийн холбогдох бүртгэлд оруулсан мэдээлэл үнэн зөв эсэхийг нягтлах зорилгоор газар дээр нь үзлэг, шалгалт хийх;

73.2.3.холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, илэрсэн зөрчлийг арилгах талаар тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг, даалгавар өгөх.

73.2.4.хуульд заасан бусад.

73.3.Энэ хуулийн 73.2-т заасан этгээдээс өгсөн үүрэг, даалгаврын биелэлтэд хяналт тавих, холбогдох тайлан, мэдээллээр хангах үүргийг Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газар хариуцна.

74 дүгээр зүйл.Төрийн хяналт

74.1.Энэ хуулийн 72.3-т заасан этгээд нь төрийн болон орон нутгийн өмчийг удирдах, өмчийн хадгалалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.1-д заасны дагуу дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

- 74.1.1.төлөвлөгөөт;
- 74.1.2.төлөвлөгөөт бус;
- 74.1.3.урьдчилан сэргийлэх;
- 74.1.4.гүйцэтгэлийн.

74.2.Төлөвлөгөөт хяналт шалгалтыг Төрийн өмчийн хороо, эсхүл Орон нутгийн өмчийн газрын даргын баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хэрэгжүүлнэ.

74.3.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг энэ хуульд заасан хяналтаар илэрсэн зөрчил, дутагдлын шалтгааныг тогтоох, эсхүл өмчийг удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой иргэн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу явуулна.

74.4.Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, ашиглалт, хамгаалалтад учирч болзошгүй эрсдэл, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор явуулна.

74.5.Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хянах зорилгоор явуулна.

74.6.Энэ хуулийн 74.1-д заасан хяналт шалгалтыг Төрийн өмчийн хороо, эсхүл Орон нутгийн өмчийн газар нь эрх бүхий бусад байгууллагатай хамтран хийж болно.

74.7.Төсвийн аудит, хяналт шалгалтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төсвийн тухай хуулийн 11.1.11, 12.1.6-д заасны дагуу хэрэгжүүлнэ.

74.8.Өмчийн эзэмшигч нь энэ хуулийн 74.7-д заасан төсвийн аудит, хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, баримтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд бүрэн гаргаж өгөх үүрэгтэй.

74.9.Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газрын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд⁴ зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

74.9.1.нягтлан бодох бүртгэлийн анхан шатны болон өмчийн харилцаатай холбоотой санхүүгийн баримтад иж бүрэн хяналт шалгалт хийх;

74.9.2.хөрөнгөд үзлэг, шалгалт хийх;

74.9.3.өмчийн харилцааг зохицуулсан хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг зөрчсөн аливаа үйлдлийг таслан зогсоох, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар хугацаатай албан шаардлага хүргүүлэх;

⁴ Төрийн хяналт шалгалтын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2003 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

74.9.4.хяналт шалгалтын явцад илэрсэн төлбөр, хохирлыг нөхөн төлүүлэхээр акт тавих, шүүхэд нэхэмжлэх гаргах хүрээнд холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

74.9.5.эрх бүхий байгууллагаас баталсан төсөв, төлөвлөгөөгүй олж авсан хөдлөх эд хөрөнгийг хураан авч, битүүмжлэх;

74.9.6.шаардлагатай тохиолдолд хөрөнгийг бусдад ашиглуулах, шилжүүлэх шийдвэрийн биелэлтийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хяналт шалгалт хийж дуусах хүртэлх хугацаанд түдгэлзүүлэх;

74.9.7.зөрчил, дутагдал гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх саналыг эрх бүхий этгээдэд хүргүүлэх;

74.9.8.шалгалтаар илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

74.9.9.шалгалтын дүн, авсан арга хэмжээний талаар гомдол, мэдээлэл гаргасан этгээдэд мэдэгдэх;

74.9.10.хураан авсан хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдаж, төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих;

74.9.11.хуульд заасан бусад.

74.10.Улсын байцаагч нь төрийн болон орон нутгийн өмчит компанид зөвхөн энэ хуулийн 74.9.3, 74.9.4, 74.9.7-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

74.11.Улсын байцаагч нь өөрийн хийсэн хяналт шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, албан шаардлагын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг хариуцна.

74.12.Улсын байцаагчийн шаардлагыг биелүүлээгүй нь холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

74.13.Улсын байцаагч нь энэ хуулийн 74.9.3-т заасан албан шаардлагын биелэлтийг шалгах, энэ хуулийн 75.9.7-д заасан саналын шийдвэрлэлтийг эрх бүхий этгээдээс шаардах эрхтэй.

74.14.Улсын байцаагч нь улсын ерөнхий байцаагчид хяналт шалгалтын талаарх тайлан, мэдээг дараа жилийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

74.15.Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигчийн эрх бүхий албан тушаалтан хяналт шалгалттай холбоотой дараах үүргийг хүлээнэ:

74.15.1.улсын байцаагч хуульд тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрэн хангаж ажиллах;

74.15.2.улсын байцаагчийн албан үүрэгт хөндлөнгөөс оролцох, дарамт шахалт үзүүлэх, нөлөөлөхгүй байх;

74.15.3.хяналт шалгалтад шаардлагатай баримт материалыг цахим болон цаасан хэлбэрээр бүрэн гаргаж өгөх.

75 дугаар зүйл.Дотоодын хяналт

75.1.Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигчийн дотоодын хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

75.1.1.өмчийн эзэмшигч өөрийн үйл ажиллагаанд хууль тогтоомжид заасан журмаар;

75.1.2.төрийн байгууллага, орон нутгийн нэгжийн удирдлага нь өөрийн харьяа байгууллага, хуулийн этгээдийн эд хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаанд.

75.2.Өмчийн эзэмшигчийн хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий байнгын ажиллагаатай, орон тооны бус Өмч хамгаалах байнгын зөвлөл ажиллана.

75.3.Өмч хамгаалах байнгын зөвлөлийг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр удирдах албан тушаалтан ахалж, ерөнхий нягтлан бодогч, мэргэжлийн инженер, техникийн ажилтан, технологич зэрэг хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

75.4.Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг Төрийн өмчийн хороо батална.

75.5.Энэ хуулийн 75.1.2-т заасан хяналт шалгалтын тайланг жил бүрийн эхний улиралд багтаан Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газарт хүргүүлнэ.

75.6.Өмчийн эзэмшигч нь дотоодын хяналтыг жил бүр зохион байгуулж, тайланг баталгаажуулан тухайн жилийн 12 дугаар сарын 25-ны дотор мэдээллийн санд оруулна.

НАЙМДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЦАХИМ СИСТЕМ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН САН

76 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн цахим систем

76.1.Төрийн болон орон нутгийн өмчийн цахим систем /цаашид “Өмчийн цахим систем” гэх/ гэж төрийн болон орон нутгийн өмчийн талаарх өгөгдөл, мэдээллийг цуглуулах, боловсруулах, хайлт хийх, илгээх, хүлээн авах, ашиглах болон аюулгүй байдлыг хангах зорилго бүхий программ хангамж, техник хангамж, мэдээллийн сан, бусад бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийн иж бүрдлийг ойлгоно.

76.2.Төрийн өмчийн хороо нь өмчийн цахим системийн үйл ажиллагааг хариуцан хөтлөх, хөгжүүлэх, удирдлага зохион байгуулалтаар болон аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

76.3.Өмчийн цахим систем нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.3-т заасан үндсэн системээр дамжуулж, бусад нийтийн мэдээллийн дэд бүтэцтэй холбогдоно.

76.4.Өмчийн цахим системийн ашиглалтын болон мэдээллийн санг хөтлөх, мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах, нууцлал, аюулгүй байдлыг хангах журмыг Засгийн газар батална.

76.5.Өмчийн цахим систем, төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн сан /цаашид “Өмчийн мэдээллийн сан” гэх/-г Үндэсний дата төвд байршуулна.

77 дугаар зүйл.Өмчийн мэдээллийн сан

77.1.Өмчийн мэдээллийн санд төрийн болон орон нутгийн өмчийн ангилал, бүртгэл, тооллого, өмчийн эзэмшигч, өмчийн хөдөлгөөн, энэ хууль болон холбогдох бусад хуульд заасан тайлан, дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалтад оруулах хөрөнгийн талаарх мэдээллийг төвлөрүүлнэ.

77.2.Өмчийн мэдээллийн сан нь төрөлжсөн мэдээллийн санд хамаарна.

77.3.Өмчийн мэдээллийн санд мэдээллийг төрийн болон орон нутгийн өмчийн тайлан, өмчийн эзэмшигчид холбогдох хөрөнгийн мэдээлэл, бусдад ашиглуулах, шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл гэсэн төрлөөр ангилан тусгана.

77.4.Төрийн болон орон нутгийн өмчийн тайланд дараах мэдээллийг тусгана:

77.4.1.төрийн нийтийн өмч, тусгайлсан өмч, орон нутгийн өмчийн нэгдсэн тооллогын дүнгийн талаарх тайлан;

77.4.2.жил тутмын төрийн тусгайлсан өмчийн төлөв байдлын тайлан;

77.4.3.жил тутмын орон нутгийн өмчийн төлөв байдлын тайлан;

77.4.4.төрийн болон орон нутгийн өмчийн өөрчлөлт, хөдөлгөөний тайлан;

77.4.5.энэ хуулийн 73.1, 74.1, 75.1-д заасан хяналт шалгалтын тайлан.

77.5.Өмчийн мэдээллийн сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан өөрт хамаарах мэдээллийг агуулсан байна.

77.6.Өмчийн мэдээллийн санг эрхлэн хөтлөх, мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах болон аюулгүй байдлыг хангах асуудлыг Төрийн өмчийн хороо хариуцна.

77.7.Төрийн болон албаны нууцад хамаарах болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хаалттай болон хязгаарлалтайгаас бусад өмчийн мэдээллийн сангийн мэдээлэл нь олон нийтэд ил тод, нээлттэй байна.

77.8.Энэ хуулийн 77.7-д заасан ил тод, нээлттэй байх мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.8, 8.9, 8.10-т заасан журмаар олон нийтэд хүргэнэ.

77.9.Өмчийн мэдээллийн санг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны нээлттэй өгөгдөл болгон боловсруулж, өөрийн цахим хуудас болон нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд нийтэлнэ.

78 дугаар зүйл.Өмчийн мэдээллийн санд мэдээлэл байршуулах

78.1.Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газар, төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигч нь энэ хуулийн 76.4-т заасан журмын дагуу өмчийн мэдээллийн санд мэдээллийг байршуулна.

78.2.Энэ хуулийн 78.1-д заасан этгээд нь холбогдох бүртгэл, мэдээллийг өмчийн мэдээллийн санд тогтоосон хугацаанд бүрэн, үнэн зөв оруулах үүрэгтэй.

78.3.Энэ хуулийн 78.2-т заасан тухайн өмчийн эзэмшигчийн үүргийн биелэлтэд Төрийн өмчийн хороо, Орон нутгийн өмчийн газар хяналт тавина.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

79 дүгээр зүйл.Гомдол хянан шийдвэрлэх

79.1.Иргэн, хуулийн этгээд нь захиргааны байгууллага, албан тушаалтнаас төрийн болон орон нутгийн өмчийг эзэмшиж, ашиглах болон бусдад ашиглуулах, шилжүүлэхтэй холбоотой гаргасан шийдвэрт Захиргааны ерөнхий хуулийн 92, 93 дугаар зүйлд заасны дагуу гомдол гаргана.

79.2.Энэ хуулийн 79.1-д заасан гомдлыг хүлээн авсан захиргааны байгууллага Захиргааны ерөнхий хуулийн 94, 95, 96, 97, 98, 99 дүгээр зүйлд заасан журмын дагуу гомдлыг шийдвэрлэнэ.

79.3.Иргэн, хуулийн этгээд нь энэ хуулийн 79.2-т заасны дагуу захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

80 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

80.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

80.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль⁵, эсхүл Зөрчлийн тухай хууль⁶ заасан хариуцлага хүлээлгэнэ.

81 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

81.1.Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---oOo---

⁵ Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙТИЙН ӨМЧИЙН ХУУЛИЙГ ДАГАЖ
МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу байгуулагдсан албан газар, төрийн өмчит үйлдвэрийн газрыг нийтийн үйлчилгээний байгууллага, компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах асуудлыг энэ хуулийн 5.1-д заасан хугацаанд Засгийн газар шийдвэрлэнэ.

2 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг нийтийн үйлчилгээний байгууллага, компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах асуудлыг энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан хугацаанд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

3 дугаар зүйл.Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө төрийн нийтийн өмчийг ашиглах зорилгоор байгуулсан орон нутгийн өмчит компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцааг төрийн өмчид шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг дагаж мөрдсөнөөс хойш нэг жилийн хугацаанд багтаан дараах арга хэмжээг зохион байгуулна:

4.1.энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу төрийн өмчит төрийн өмчит албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг татан буулгах, өөрчлөн байгуулах;

4.2.энэ хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах, өөрчлөн байгуулах;

4.3.энэ хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу орон нутгийн компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцааг төрийн өмчид шилжүүлэх шийдвэрийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

4.4.батлан хамгаалах, зэвсэгт хүчин, хил хамгаалах байгууллагаас бусад төрийн байгууллагын дэргэд үйл ажиллагаа явуулж байгаа амралт, сувиллын газар, спорт, соёлын төв зэрэг чиг үүрэгт нь хамаарахгүй хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулж, орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх;

4.5.Нийтийн өмчийн хуулийн 78 дугаар зүйлд заасан төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх.

5 дугаар зүйл.Нийтийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлд заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн төлөв байдлын нэгдсэн тайлан гаргах, эрх бүхий

байгууллагад хүргүүлэхтэй холбоотой зохицуулалтыг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

6 дугаар зүйл.Хуульд заасан дараах нэр томьёог Нийтийн өмчийн хуульд заасан доор дурдсан нэр томьёотой ижил утгаар ойлгож хэрэглэнэ:

6.1.“төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж” гэснийг Нийтийн өмчийн тухай хуульд заасан “төрийн болон орон нутгийн өмчийн нийтийн үйлчилгээний байгууллага” гэж;

6.2.“төрийн өмчит хуулийн этгээд” гэснийг Нийтийн өмчийн хуульд заасан “төрийн өмчийн эзэмшигч” гэж;

6.3.“орон нутгийн өмчит хуулийн этгээд” гэснийг Нийтийн өмчийн хуульд заасан “орон нутгийн өмчийн эзэмшигч” гэж;

6.4.“төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд” гэснийг Нийтийн өмчийн хуульд заасан “төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигч” гэж;

6.5.“аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар”, “улсын төсөвт үйлдвэрийн газар” гэснийг Нийтийн өмчийн хуульд заасан “нийтийн үйлчилгээний байгууллага”, эсхүл Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглал, ил тод байдал, бүтээмжийг сайжруулах тухай хуульд заасан “төрийн өмчит компани”, эсхүл “орон нутгийн өмчит компани” гэж.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд” гэсний өмнө “1996 оны 5 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн зүйлийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “төрийн өмч” гэснийг “төрийн нийтийн өмч” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн өмч” гэснийг “төрийн нийтийн өмч” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн өмч” гэснийг “төрийн тусгайлсан өмч” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 40¹ дүгээр зүйлийн 40^{1.1} дэх хэсгийн “төрийн өмч” гэснийг “төрийн тусгайлсан өмч” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын тосны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “төрийн өмчид” гэснийг “төрийн нийтийн өмчид” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Генетик нөөцийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “төрийн өмч” гэснийг “төрийн нийтийн өмч” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Геодези, зураг зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “төрийн өмч” гэснийг “төрийн тусгайлсан өмч” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“15.6. Гүйцэтгэх ажлын зориулалттай эд хөрөнгийг худалдан авах, үйлдвэрлэх, эргэлтийн хөрөнгөд бүртгэх, захиран зарцуулах, шилжүүлэх, устгахтай холбогдсон харилцааг Нийтийн өмчийн хуулийн 3.5-д заасан журмаар зохицуулна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Зөрчил шалган шийдвэрлэх тухай
хуульд нэмэлт оруулах тухай хуулийн
төсөл

Нийтийн өмчийн хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт Төрийн өмчийн хороонд улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, мөн хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт Улсын ерөнхий байцаагчаас эрх олгосноор улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллахаар тус тус заасан.

Улсын байцаагч нь хуулийн төслийн 74 дүгээр зүйлийн 74.9 дэх хэсэгт заасны дагуу Төрийн хяналт шалгалтын тухай хуульд зааснаас гадна нягтлан бодох бүртгэлийн анхан шатны болон өмчийн харилцаатай холбоотой санхүүгийн баримтад иж бүрэн хяналт шалгалт хийх, хөрөнгөд үзлэг, шалгалт хийх, өмчийн харилцааг зохицуулсан хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг зөрчсөн аливаа үйлдлийг таслан зогсоох, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар хугацаатай албан шаардлага хүргүүлэх, хяналт шалгалтын явцад илэрсэн төлбөр, хохирлыг нөхөн төлүүлэхээр акт тавих, шүүхэд нэхэмжлэх гаргах хүрээнд холбогдох байгууллагатай хамтран ажиллах, зөрчил, дутагдал гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх саналыг эрх бүхий этгээдэд хүргүүлэх зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тусгасан.

Энэ хүрээнд хуульд заасны дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн хяналтын улсын байцаагч нь Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйл (Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих), 15.2 дугаар зүйл (Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах)-д заасан зөрчлийг шалган шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт нэмэлтээр оруулах хуулийн төслийг боловсруулсан болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 6.66 дахь заалт нэмсүгэй:

“6.66.Төрийн өмчийн, эсхүл орон нутгийн өмчийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.2.Төрийн болон орон нутгийн өмчит компани, нийтийн үйлчилгээний байгууллага, ашгийн төлөө бус хуулийн этгээд, гадаад улсын хуулийн этгээд энэ хуулийн зохицуулалтад хамаарахгүй.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗАР ДАХЬ ХЯНАЛТЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “улсын төсөвт үйлдвэрийн газар,” гэснийг “нийтийн үйлчилгээний байгууллагын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн” гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.18 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4.1.18. “төрийн өмчит хуулийн этгээд” гэж Нийтийн өмчийн хуулийн 15.2-т заасан этгээдийг.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Кино урлагийг дэмжих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “Хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах журмыг” гэсний дараа “Нийтийн өмчийн хуульд нийцүүлэн” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Кино урлагийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д заасны дагуу” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.6 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.1.6 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.6 дахь заалт, 63 дугаар зүйлийн 63.1.6 дахь заалтын “зохион байгуулж,” гэсний дараа “шаардлагатай тохиолдолд” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“4.1.9. “орон нутгийн өмч” гэж орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилготой Нийтийн өмчийн хуулийн 10 дугаар зүйлд заасан хөрөнгийг;”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “улсын үйлдвэрийн газар, байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид” гэснийг “нийтийн үйлчилгээний байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компани, төрийн чиг үүргийг хууль, эсхүл гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа этгээдэд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

МУЗЕЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Музейн тухай хуулийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль” гэснийг “Нийтийн өмчийн хууль” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар” гэснийг “Нийтийн өмчийн хуулиар” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Төрийн байгууллагын” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн байгууллагын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**НОМЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Номын сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд” гэснийг “Нийтийн өмчийн хуульд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль” гэснийг “Нийтийн өмчийн хууль” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ОЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ойн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “төрийн өмч” гэснийг “төрийн нийтийн өмч” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Өрийн удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд” гэснийг “Нийтийн өмчийн хуульд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Соёлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль” гэснийг “Нийтийн өмчийн хууль” гэж, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар” гэснийг “Нийтийн өмчийн хуулиар” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг:

“9.1.Нийтийн өмчийн соёлын биет өвд үнэлгээ тогтоох журмыг төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн санхүү, төсвийн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

2/22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг:

“22.5.Соёлын өв устсан, үрэгдсэн тохиолдолд Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран зохих шийдвэр гаргана.”

2 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсгийн “төрийн өмчид” гэснийг “төрийн тусгайлсан өмчид” гэж, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “төрийн өмч” гэснийг “төрийн нийтийн өмч” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.6 дахь заалтын “төрийн” гэсний дараа “болон орон нутгийн” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “нийтийн өмч” гэснийг “төрийн өмч” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.10 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.3.4 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “нийтийн өмчтэй” гэснийг “төрийн өмчтэй” гэж, 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсгийн “нийтийн өмчийг” гэснийг “төрийн өмчийг” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль” гэснийг “Нийтийн өмчийн хууль” гэж, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “аж ахуйн тооцоот төрийн өмчит үйлдвэрийн газар байх бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд” гэснийг “төрийн өмчийн компани байх бөгөөд холбогдох хуульд заасны дагуу” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөл

Нийтийн өмчийн хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуульд заасан тодорхой чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор өмчтэй байхаар заасан бөгөөд энэ хүрээнд мөн хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтад заасны дагуу “орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшлийн үл хөдлөх эд хөрөнгийг нэгээс гурав хүртэлх жилийн хугацаагаар бусдад ашиглуулах”, 18.1.4 дэх заалтад заасны дагуу “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300 дахин нэмэгдүүлснээс доошгүй хэмжээний нэг бүрийн балансын үнэ бүхий хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг бусдад ашиглуулах” шийдвэрийг тухайн орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч буюу Засаг дарга гаргахаар зохицуулсан.

Харин хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.6.2 дахь заалтад заасны дагуу “орон нутгийн байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллагын эзэмшлийн үл хөдлөх эд хөрөнгийг гурван сараас нэг хүртэлх жилийн хугацаагаар бусдад ашиглуулах” тохиолдолд аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн газрын зөвшөөрлийг авсны үндсэн дээр тухайн орон нутгийн өмчийн эзэмшигч шийдвэр гаргахаар тусгасан.

Дээрх шийдвэр гаргах ажиллагаатай холбогдуулан орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, үр ашгийг сайжруулах, орон нутгийн орлогын эх үүсвэрийн төрлийг нэмэгдүүлэх зорилгоор Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт заасан “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн эх үүсвэрт орон нутгийн өмчийн хөрөнгийг ашигласны төлбөрийг хамааруулахаар тусгасан.

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.17 дахь заалтад “төрийн өмчийн эд хөрөнгө ашигласны төлбөрийн хэмжээг тогтоох” бүрэн эрхийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хэрэгжүүлэхээр тусгасан боловч одоогоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор Сангийн яамны саналыг үндэслэн “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар”-ыг батлан мөрдүүлж, түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын дүнгийн 40 хувиар тогтоон хэрэгжүүлж байна.

Иймд Нийтийн өмчийн хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэгт “Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн ашиглалтын төлбөрийн доод хэмжээ, түүнийг тогтоох аргачлалыг тухайн үл хөдлөх эд хөрөнгийн байршил, зориулалт, ашиглах этгээдийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлээс хамааруулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Төрийн өмчийн хороо тогтооно” гэж заасантай нийцүүлэх хүрээнд Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.17 дахь заалтын “төрийн өмчийн эд хөрөнгө ашигласны төлбөрийн хэмжээг тогтоох” гэснийг “төрийн өмчийн хөрөнгийг ашигласны төлбөрөөс улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг тогтоох” гэж өөрчилж, уг бүрэн эрхийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дангаараа хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Мөн Төсвийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн “төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээслэсний орлого” гэснийг Нийтийн өмчийн хуулийн төсөлд тусгасан нэр томъёотой нийцүүлэх зорилгоор “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашигласны төлбөр” гэж өөрчлөхөөр холбогдох хуулийн төслийг боловсруулсан болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 60.2.11 дэх заалт нэмсүгэй:

“60.2.11.орон нутгийн өмчийн хөрөнгийг ашигласны төлбөр.”

2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.17 дахь заалтын “төрийн өмчийн эд хөрөнгө ашигласны төлбөрийн хэмжээг тогтоох” гэснийг “төрийн өмчийн хөрөнгийг ашигласны төлбөрөөс улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг тогтоох” гэж, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн “төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээслэсний орлого” гэснийг “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашигласны төлбөр” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “төрийн өмч” гэснийг “төрийн нийтийн өмч” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “төрийн өмч” гэснийг “төрийн тусгайлсан өмч” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БАРЬЦААНЫ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд” гэснийг “Нийтийн өмчийн хуульд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн тухай 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай,” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.8, 7.1.9, 7.1.10 дахь заалтыг доор дурдсан тус тус өөрчлөн найруулсугай:

“7.1.8.төрийн байгууллага;
7.1.9.нийтийн үйлчилгээний байгууллага;
7.1.10.Засгийн газрын тусгай сан.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “төрийн өмч” гэснийг “төрийн нийтийн өмч” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд” гэснийг “төрийн байгууллага” гэж, мөн зүйлийн 3.1.2 дахь заалтын “төрийн өмчит үйлдвэрийн газар” гэснийг “нийтийн үйлчилгээний байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн тухай 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар” гэснийг “Нийтийн өмчийн хуулиар” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсгийн “хууль зааснаас бусад төрийн” гэсний дараа “болон орон нутгийн” гэж, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “Төрийн” гэсний дараа “болон орон нутгийн өмчийн” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийн “эрхийн улсын бүртгэлд бүртгэх журмыг Засгийн газар батална.”, 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсгийн “эрхийн улсын бүртгэлд бүртгэх журмыг энэ хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн Засгийн газар батална.” гэснийг “Нийтийн өмчийн хуульд заасан журмын дагуу бүртгэнэ.” гэж, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд” гэснийг “Нийтийн өмчийн хуульд” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн тухай 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар” гэснийг “Нийтийн өмчийн хуулиар” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрчим хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “төрийн өмчлөлд” гэснийг “төрийн тусгайлсан өмч” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ
ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.1996 оны 05 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Нийтийн өмчийн хуульд нийцүүлэн Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан өргөн мэдүүлэх;

2/Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан өргөн мэдүүлэх;

3/Төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан өргөн мэдүүлэх;

4/Нийтийн өмчийн хуулийн 11.3.3-т заасан бусдын өмчлөлд шилжүүлж үл болох төрийн тусгайлсан өмчийн жагсаалтыг боловсруулж, Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан өргөн мэдүүлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо (Р.Сэддорж)-нд даалгасугай.

3.Энэ тогтоолыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

**“ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО,
БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧИЙГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ”
ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын тохируулагч агентлаг” гэсэн хэсэгт “-Төрийн өмчийн хороо” гэж нэмсүгэй.

2. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар” гэснийг хассугай.

3. Энэ тогтоолыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг